



МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,  
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН**

**19 ТАЛААРХ  
ДЭХ ИЛТГЭЛ**

Улаанбаатар хот  
2020 он





МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

# **МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19 ДЭХ ИЛТГЭЛ**

Улаанбаатар хот  
2020 он

ННА: 67.404

ДАА: 347

М-692

Цаасны хэмжээ: 145x205 мм

Хэвлэлийн хуудас: 16.0 х.х

Хэвлэсэн тоо: 2000 ширхэг

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Тусгаар тогтнолын талбай Засгийн газрын XI байр, 5 давхар

Цахим хуудас: [www.nhrctm.gov.mn](http://www.nhrctm.gov.mn)

Цахим шуудан: [info@nhrctm.gov.mn](mailto:info@nhrctm.gov.mn)

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-9919-9531-3-3



## АГУУЛГА

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын  
талаарх 19 дэх илтгэлийн танилцуулга .....5

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн  
нөхцөл байдал: Хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон  
нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал.....9

- 1.1 Малчин эмэгтэйчүүдэд хамаарах статистик  
мэдээлэл болон амьжиргаа, аж байдал,  
хөдөлмөр эрхлэлтийн зарим асуудал..... 11
- 1.2 Малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс  
ангид байх эрхийн асуудал.....40
- 1.3 Малчин эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн  
үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал .....60

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Жендэрийн эрх тэгш байдлыг  
хангах тухай хуулийн хэрэгжилт .....85

- 2.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах  
талаарх нутгийн захиргааны байгууллагын  
чиг үүргийн хэрэгжилт .....90
- 2.2 Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын  
баталгааг хангаж буй байдал.....95
- 2.3 Орон нутгийн хэмжээнд жендэрийн сургалт,  
гэгээрлийн үйл ажиллагаа явуулж буй байдал ..... 104
- 2.4 Жендэрийн ялгаварлан гадуурхалт,  
ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой  
гомдол шийдвэрлэлтийн байдал..... 107

ГУРАВДУГААР БҮЛЭГ. Химийн хорт болон аюултай  
бодисын хадгалалт, хамгаалалтын талаар тулгамдаж  
буй зарим асуудал..... 117

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Хүний эрхийн олон улсын индекс	
ба Монгол Улсын эзлэх байр..... 141	
4.1	Шударга шүүхээр шүүлгэх болон хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрх..... 147
4.2	Хэвлэн нийтлэх эрх чөлөө ..... 150
4.3	Боолчлол, боолын худалдаанд өртөхгүй байх эрх ..... 153
4.4	Сурч боловсрох эрх ..... 156
4.5	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ..... 161
4.6	Жендэрийн индекс ..... 164
4.7	Тогтвортой Хөгжлийн Зорилгын 2019 оны индекс ..... 169

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилт..... 177	
---	--

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар өгч буй санал.....251	
---	--

## МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19 ДЭХ ИЛТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11, 9 дүгээр зүйлийн 9.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу Комисс нь тухайн жилийн хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлыг тодорхойлж Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн барьдаг билээ.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийг “Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн нөхцөл байдал: Хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт”, “Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтын талаар тулгамдаж буй зарим асуудал”, “Хүний эрхийн олон улсын индекс ба Монгол Улсын эзлэх байр” гэсэн үндсэн 4 сэдвийн хүрээнд боловсруулав.

Энэхүү ээлжит илтгэлийг Комиссын стратеги төлөвлөгөө, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд хийсэн хяналт шалгалт, судалгаа, иргэдээс Комисст гаргасан өргөдөл, гомдол, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, иргэний нийгмийн болон бусад байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, дүн шинжилгээ, Засгийн газар, яам, агентлаг, болон бусад байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулж, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 болон 17 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахаар 23 санал хүргүүлж байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийн агуулгыг бүлэг тус бүрээр тоймлон танилцуулбал:

**Нэгдүгээр бүлэг. Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн нөхцөл байдал: Хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал**

Комисст ирж буй гомдол, мэдээлэлд үндэслэн малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн зарим нөхцөл байдлыг тодорхойлох үүднээс 2019 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр алслагдсан аймаг, сум дахь малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтийг судалж, үнэлснийг энэхүү бүлэгт тусгав.

**Хоёрдугаар бүлэг. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт**

Монгол Улсад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 9 жил өнгөрч байгаа боловч тухайн хуулийн хэрэгжилт тун хангалтгүй байна. Комисс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Завхан, Архангай, Төв, Хөвсгөл, Булган зэрэг нийт 16 аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв зэрэг нийт 160 байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг

хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийсэн билээ. Дээрх хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, хяналт шалгалтын хүрээнд 1,681 төрийн албан хаагчаас авсан судалгааны санал асуулгын нэгтгэсэн дүн, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага болон холбогдох байгууллагаас ирүүлсэн судалгаа, баримт, мэдээлэлд тулгуурлан энэхүү бүлгийг боловсруулав.

### Гуравдугаар бүлэг. Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтын талаар тулгамдаж буй зарим асуудал

Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэлд хүргэх үйлчилгээтэй, тэсрэмтгий, шатамхай, исэлдүүлэгч, идэмхий, цочроогч шинж чанартай химийн хорт болон аюултай бодисыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэж байгаагаас үүдэн хугацаа нь дууссан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, удаан хугацаанд хадгалагдсан химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, хамгаалах, зайлуулах, устгах асуудал эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн тулгамдсан асуудал болж байна.

Иймд химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтад төрөөс анхаарал хандуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагын үүднээс Комиссоос хийсэн хяналт шалгалт, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, холбогдох эрх бүхий байгууллагын судалгаа, баримт, мэдээлэлд үндэслэн энэхүү бүлгийг боловсруулав.

### Дөрөвдүгээр бүлэг. Хүний эрхийн олон улсын индекс ба Монгол Улсын эзлэх байр

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын мэдээлэл бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчдад хүрч

холбогдох шийдвэр гарч ирсний зэрэгцээ олон нийт ч улс орны хүний эрхийн төлөв байдал олон улсын түвшинд ямар байгаа, улс орнуудын дунд ямар байр эзэлж байгаа талаар ач холбогдол өгөн анхаарч, мэдээлэл хайдаг болжээ. Иймд Комисс улс орнуудыг нийгмийн болон хүний хөгжлийн түвшингээр нь тодорхой шалгуураар үнэлж оноо өгдөг, индексжүүлэн эрэмбэлдэг олон улсын байгууллага, судалгаа шинжилгээний төвүүдээс гаргасан тайлан мэдээллээс хүний эрхэд холбогдох индексийг түүвэрлэн, зарим эрхийн хүрээнд нэгтгэн энэ бүлэгт танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолыг баталсан билээ. Уг тогтоолын 2 дугаар заалтад “Энэ тогтоолын хэрэгжилтийг хангах нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт...” даалгасан боловч одоог хүртэл хэлэлцүүлээгүй байх тул Комиссоос тус тогтоолын хэрэгжилтийн байдлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон холбогдох яам, агентлаг зэрэг төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн нэгтгэн танилцуулж байна.

# I

БҮЛЭГ

**МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН  
НӨХЦӨЛ БАЙДАЛ: ХҮЧИРХИЙЛЛЭС АНГИД  
БАЙХ ЭРХ, БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН  
ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН  
ЗАРИМ АСУУДАЛ**

*“Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй эрх тэгш байх үндсэн дээр хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх, хэрэгжүүлэх баталгааг олгох зорилгоор тэдний бүрэн хөгжил, дэвшлийг хангахын тулд бүхий л салбарт, тухайлбал улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбарт зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээ авна.”*

(Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 3 дугаар зүйл)

*“Оролцогч улсууд хөдөө нутгийн эмэгтэйчүүдийн өмнө тулгарч буй онцлог асуудал болон тэднээс гэр бүлийнхээ эдийн засгийн амьдралд гүйцэтгэж буй чухал үүрэг, түүний дотор аж ахуйн таваарын бус салбарт гүйцэтгэж буй ажлыг анхааран үзэж, хөдөө нутгийн эмэгтэйчүүдийн хувьд энэхүү Конвенцын заалтуудыг хэрэгжүүлэх талаар зохистой бүх арга хэмжээг авна.”*

(Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 14 дүгээр зүйл)

*“...эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг устгахын тулд гэр бүл төлөвлөлтийг оролцуулан эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зохистой бүх арга хэмжээг авна.”*

(Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 12 дугаар зүйл)



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст ирж буй гомдол, мэдээлэлд үндэслэн малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн зарим нөхцөл байдлыг тодорхойлох үүднээс 2019 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр алслагдсан аймаг, сум дахь малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтийг судалж, үнэллээ. Судалгааны хүрээнд нийт 20 аймгийн 631 малчин эмэгтэйгээс асуулга авч, Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Баянхонгор, Завхан, Хөвсгөл аймгийн 19 сумыг сонгон авч, Комиссын ажлын хэсэг очиж ажиллалаа.


Судалгаанд сонгогдсон аймаг, сумын удирдлага, Засаг даргын тамгын газрын албан хаагчид, малчин эмэгтэйчүүдтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж, Комисст хандаж хууль зүйн зөвлөгөө авсан малчин эмэгтэйчүүдийн талаарх мэдээлэл болон судалгаагаар цуглуулсан жишээ, тохиолдлыг шинжлэн судлахын зэрэгцээ Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудаас малчдын асуудлаар ирүүлсэн судалгаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийснийг энэхүү бүлэгт тусгалаа.

### 1.1 Малчин эмэгтэйчүүдэд хамаарах статистик мэдээлэл болон амьжиргаа, аж байдал, хөдөлмөр эрхлэлтийн зарим асуудал

2019 оны байдлаар Монгол Улсын ажил эрхэлдэг дөрвөн хүн тутмын нэг нь, мөн нийт ажиллах хүчний 24.1

хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж байна.<sup>1</sup> Харин тус онд нийт 285,482 малчин бүртгэгдсэний 166,368 нь буюу 58.3 хувь нь эрэгтэй, 119,114 нь буюу 41.7 хувь нь эмэгтэйчүүд байгаагаас харахад хүйсийн хувьд эрэгтэйчүүд давамгайлж байна. Нийт малчдын 31 хувь нь 15–34 нас, 59.2 хувь нь 35–59 нас, 9.9 хувь нь 60–аас дээш насны малчид байна. Мөн 15–24 насны залуу малчдын 69.8 хувь нь эрэгтэй, 30.2 хувь нь эмэгтэй байна. Үндэсний статистикийн хорооны мэдээллээс<sup>2</sup> үзэхэд сүүлийн жилүүдэд залуу, дунд үеийн малчдын тоо буурч, малчдын залгамж халаа багасах хандлагатай байгаагийн зэрэгцээ залуу малчдын дундах хүйсийн харьцаа зөрүү ихтэй байна.

Бүдүүвч 1.1 Малчдын статистик үзүүлэлт (1990–2019 он)




<sup>1</sup> Үндэсний статистикийн хорооны “Ажиллах хүчний судалгаа”-ны 2019 оны урьдчилсан мэдээ, 2020 он


<sup>2</sup> Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn), “Хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга” урьдчилсан мэдээ, 2020 он.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:  
ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХ, БЭЛГИЙН БОЛОН  
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Бүдүүвч 1.2 Малчдын нас, хүйсийн ангилал (2019 он, хувиар)




Бүдүүвч 1.3 Малчдын нас, хүйсийн суварга (2019 он)



Комиссын судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн насны ангиллыг үзвэл дараах байдалтай байна.

### Бүдүүвч 1.4 Насны ангилал



Мал аж ахуйн салбарт туслах малчин, хөлсний малчин гэсэн ойлголт бий болж, улмаар сүүлийн жилүүдэд туслах малчин гэсэн нэршил, ойлголтыг түлхүү хэрэглэх болсноор Үндэсний статистикийн хорооноос туслах малчинтай холбоотой мэдээллийг албан ёсоор гаргах болжээ. Малчин өрх нь жилийн бүх улиралд мал хариулж, малын ашиг шимээ амьжиргааны эх үүсвэрээ болгодог. Харин малаа ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг, голдуу суурин газар амьдардаг өрхийг мал бүхий өрхөд хамааруулдаг байна. Мал бүхий өрх болон малчин өрхийг хамтад нь малтай өрх гэж томъёолж байна.<sup>3</sup>

<sup>3</sup> Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn). “Хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга” урьдчилсан мэдээ, 2020 он. Үндэсний статистикийн хорооноос малчдын талаарх нэр томъёог дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

“Мал бүхий өрх” гэж малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг ойлгоно.


“Малчин өрх”-д жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хамруулна.

“Малтай өрх” гэж мал бүхий өрх болон малчин өрхийг хэлнэ.

“Малчид” гэж жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа мал аж ахуй эрхлэгчдийг ойлгоно.

Комиссын судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүдийн 70-аас дээш хувь нь малчин өрхийн гишүүн бөгөөд тэдний 84.4 хувь нь мал аж ахуй эрхэлж, 12.6 хувь нь малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлж, суурин газарт аж төрж байна.

Бүдүүвч 1.5 Малчин өрхийн ангилал



Судалгааны хүрээнд малчин эмэгтэйчүүдийн гэрлэлт, боловсрол, амьжиргаа, орлогын эх үүсвэр, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүндрэл бэрхшээл, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, туслах малчны ажил, хөдөлмөртэй холбоотой зарим асуудалд дүн шинжилгээ хийв.

### Гэрлэлтийн байдал

Нийт 285,482 малчны 81 хувь нь гэрлэсэн бөгөөд үүний 76 хувь нь гэрлэлтээ батлуулсан, 5 хувь нь гэрлэлтээ батлуулаагүй байна. Харин тэдний 12.8 хувь нь гэрлээгүй, 4.9 хувь нь бэлэвсэн, 0.7 хувь нь гэрлэлтээ цуцалсан, 0.6 хувь нь гэрлэлтээ тусгаарлажээ.<sup>4</sup>


<sup>4</sup> Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn), "Хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга" урьдчилсан мэдээ, 2020 он.

Хүснэгт 1.1 Малчдын гэрлэлтийн байдлыг насны  
бүлгээр гаргасан үзүүлэлт (2019 он, тоо болон хувиар)

Насны бүлгээр	Нийт	Огт гэрлээгүй	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэсэн батлуулаагүй	Тусгаарласан	Цуцалсан	Бэлэвсэн
Нийт	285,482	36,581	216,832	14,410	1,697	2,057	13,905
15-24	23,776	15,529	6,484	1,719	16	16	12
25-34	64,693	11,138	47,365	5,462	219	261	248
35-44	84,134	5,166	72,939	3,641	502	703	1,183
45-54	64,006	2,866	54,452	2,377	583	712	3,016
55-64	33,680	1,375	26,456	1,005	301	307	4,236
65 ↑	15,193	507	9,136	206	76	58	5,210
Дүнд эзлэх хувь							
Нийт	100	12.8	76.0	5.0	0.6	0.7	4.9
15-24	100	65.3	27.3	7.2	0.1	0.1	0.1
25-34	100	17.2	73.2	8.4	0.3	0.4	0.4
35-44	100	6.1	86.7	4.3	0.6	0.8	1.4
45-54	100	4.5	85.1	3.7	0.9	1.1	4.7
55-64	100	4.1	78.6	3.0	0.9	0.9	12.6
65 ↑	100	3.3	60.1	1.4	0.5	0.4	34.3

Комиссын судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүд  
гэр бүлийн байдлаа дараах байдлаар тодорхойлжээ.

Бүдүүвч 1.6 Гэр бүлийн байдал



Судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүдийн 3.6 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан байна. Малчин эмэгтэйчүүдийн гэрлэлтээ цуцлуулж буй шалтгаанд хүүхдийг 6 настайгаас эхлэн сургуульд элсүүлдэг болсноор зарим талаар залуу малчдын гэр бүлийн тогтвортой байдал алдагдах, гэр бүл салахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа талаар аймаг, сумдын төрийн албан хаагчид, малчид ярилцлагын үеэр олонтаа хөндөж байв.

### Тохиолдол 1.1

*Олон жил орон нутагт амьдарсны хувьд хэлэхэд сүүлийн үед боловсролын системээс шалтгаалж гэр бүл салах боллоо. Зургаан настай хүүхдээ сургуульд оруулна, түүнээс өмнө цэцэрлэгт явуулна гэх шалтгаанаар хөдөөгийн залуучууд сумын төвд их ирдэг. Ингээд эрэгтэйчүүд гэр бүлээ тэжээх, мал аж ахуйгаа эрхлэх үндсэн ажил нь болохоор хөдөө их амьдарч байна. Энэ хугацаанд бие биеэсээ хөндийрч, эрчүүд нь өөр айлын охин, эхнэртэй уулзах явдал мэр сэр гарна. Сумын төвд олны дунд ороод ирсэн эмэгтэйчүүд онц хийсэн ажилгүй дэмий сэлгүүцэх, баар цэнгээний газраар явах, мал аж ахуйн ажлаас хөндийрснөөр залуу гэр бүл хоорондоо таарамжгүй болж салж байна...*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын төрийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас)

### Тохиолдол 1.2

*Малчин эцэг эх хүүхдээ дагаад суманд ирж амьдардаг. Хүүхдээ дотуур байранд оруулчихаад малаа малламаар юм, заримдаа хөдөөх ажлаасаа зугтаад суманд ирдэг юм болов уу гэж боддог. Мал дээр үлдсэн аав нь архи дарс ууж, гэр бүлээс гадуур харилцаа үүсгэдэг. 6-7 жилийн өмнө нэг ээж*

*хүүхдээ дагаж ирээд, гэр бүл салж, ээж нь дөрвөн хүүхдээ аав дээр нь орхичихоод явчихсан. Зундаа аав дээрээ хэдэн сар байчихаад бусад үед байранд амьдардаг тохиолдол ч гарч байсан. Энэ байдал яаж үүссэн бэ гэхээр ээж нь 6 настай хүүхдээ дагаж төв орж ирдэг болсонтой холбоотой.*

(Хөвсгөл аймгийн нэгэн сумын төрийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас)

Малчдад тулгарах болсон энэхүү бэрхшээл нь хүүхдүүдэд хамааралтай тул эцэг эхийн хайр халамжаас хол байгаа хүүхдэд чиглэсэн шинэлэг санаачилгыг зарим аймагт эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байгаагийн нэг нь Завхан аймаг юм. Тус аймаг бага ангийн хүүхдүүдэд зориулсан дотуур байрыг тохижуулж, “Гэр өргөө” төслийг сумдадаа хэрэгжүүлж байна.

### Тохiolдол 1.3

*Хөдөө орон нутагт амьдрах малчин эмэгтэйчүүдийн тоо цөөрч байна. 6 настай хүүхдүүдээ сургуульд сургах гээд малчин эмэгтэйчүүд сум руу хүүхэдтэйгээ хамт ирж байгаагаас гэр бүл салалт ихсэх болсон. Үүнийг багасгах зорилгоор анх удаа 6 настай хүүхдийн “Гэр өргөө”-г байгуулан хэд хэдэн суманд ажиллуулж байна. 6 настай хүүхдийг гэртээ байгаа мэт, заавал эцэг эх нь дэргэд нь байх шаардлагагүй нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж байна. Жишээлбэл, Цагаанчулуут суманд дотуур байрыг засч тохижуулан ажиллуулж байна. Эхлээд малчдын хэдэн хүүхэд сургуульд шинээр элсэн орохыг судлаад түүндээ тохируулан өрөө тасалгааны тоог тодорхойлдог. Хүүхдийн хувцсыг угааж өгөхөөс эхлээд багшийн орон тоо хангалтгүй тул хүн нэмж ажиллуулж байна. Үүнийг орон нутгийнхаа төсвөөс шийдсэн...*

(Завхан аймгийн удирдлагуудтай хийсэн ярилцлагаас)



Судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн 90-ээс дээш хувь нь сайн дурын үндсэн дээр гэр бүлээ зохиосон бол эцэг эх, хамаатан садны оролцоотойгоор гэрлэсэн эмэгтэйчүүд 4 хувийг эзэлж байв. Түүнчлэн “хүчинд автаж гэрлэсэн” гэж 16 эмэгтэй хариулжээ.

### *Боловсрол*

Нийт малчдын боловсролын түвшинг авч үзвэл 23.2 хувь нь бага, 39.9 хувь нь суурь, 23.1 хувь нь бүрэн дунд, 6.4 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 3.7 хувь нь дээд боловсролтой, 3.7 хувь нь боловсролгүй байна. Тэгвэл малчин эмэгтэйчүүдийн 3.3 хувь нь боловсролгүй, 20.8 хувь нь бага боловсролтой, 38.3 хувь нь суурь боловсролтой, 25.9 хувь нь бүрэн дунд боловсролтой, 7 хувь нь мэргэжлийн боловсролтой, 4.6 хувь нь дээд боловсролтой байна.<sup>5</sup>

Хүснэгт 1.2 Малчдын боловсролын түвшинг насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт (2019 он, тоо болон хувиар)

Насны бүлгээр	Нийт	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Нийт	285,482	10,461	66,193	113,999	66,002	18,182	10,645
15-24	23,776	1,033	3,576	9,013	7,068	2,073	1,013
25-34	64,693	2,914	15,427	20,079	17,352	3,589	5,332
35-44	84,134	3,172	21,723	39,535	16,417	1,398	1,889
45-54	64,006	1,527	8,354	29,051	18,201	5,842	1,031
55-64	33,680	1,027	9,166	13,161	5,658	3,858	810
65 ↑	15,193	788	7,947	3,160	1,306	1,422	570


<sup>5</sup> Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn), “Хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга” урьдчилсан мэдээ, 2020 он.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,  
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19 ДЭХ ИЛТГЭЛ

Дүнд эзлэх хувь							
Нийт	100	3.7	23.2	39.9	23.1	6.4	3.7
15–24	100	4.3	15	37.9	29.7	8.7	4.3
25–34	100	4.5	23.8	31	26.8	5.5	8.2
35–44	100	3.8	25.8	47	19.5	1.7	2.2
45–54	100	2.4	13.1	45.4	28.4	9.1	1.6
55–64	100	3	27.2	39.1	16.8	11.5	2.4
65 ↑	100	5.2	52.3	20.8	8.6	9.4	3.8

Комиссын судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүдийн боловсролын түвшинг авч үзвэл дараах байдалтай байна.

Бүдүүвч 1.7 Боловсролын түвшин



Малчин эмэгтэйчүүд ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт хангалттай хамрагдаж чадахгүй, түүнчлэн мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ бүрэн эдлэх боломжгүй байгааг ярилцлагын үеэр өөрсдөө болон аймаг, сумдын боловсролын асуудал хариуцсан ажилтнууд онцолж байв. Тухайлбал 1990 онд зах зээлийн тогтолцоонд шилжсэний дараа нэгдлийн малыг хувьчилснаар олон тооны хүүхэд

мал маллахаар сургууль завсардсан бөгөөд өдгөө 30–40 насны бичиг үсэг тайлагдаагүй малчин залуу олон байна.

Тэд тэр бүр сум, аймгийн төв рүү ирэх боломжгүй, багш, нийгмийн ажилтнуудын хувьд орон нутагт ажиллах төсөв хомс зэрэг шалтгааны улмаас шаардлагатай мэдээ мэдээллийг, ялангуяа эрүүл мэндийн боловсрол, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх мэдээллийг цаг тухайд нь авч чаддаггүй байна.

#### Тохиолдол 1.4

*Ерөнхий боловсролын сургуульд 1 дүгээр ангид элсэж буй 6 настай хүүхдүүдийн 20 орчим хувь нь малчдын хүүхэд байдаг. Сүүлийн жилүүдэд малчид сум, аймгийн төвд нэг гэрт, ээжүүд 1 дүгээр ангийн хүүхдээ хариуцан хамт байх нь түгээмэл болсон. Гэтэл 1 дүгээр ангийн хүүхдүүдээ дагаад ирж буй малчин ээжүүдийн олонх нь бичиг үсгийн чадваргүй байдаг. Зөвхөн сургуульд хүргэж өгөх, авахаас хэтрэхгүй, бага боловсролын суурийг тавихад хамтран ажиллах үүрэгтэй ч тэдний боловсрол хангалтгүй байна.*

*Үүнийг шийдвэрлэх үүднээс аймгийнхаа Насан туршийн боловсролын төвтэй хамтарч бичиг үсгийн боловсрол багатай ээжүүдийн бичиг үсгийн чадварыг дээшлүүлэхээр ажиллаж үзсэн. Аймгийн захиргаа, сургуулийн удирдлагаас ач холбогдлыг нь сайн хэлж өгсөн ч ээжүүд ирэх нь цөөн, сүүлдээ ирэхээ байсан. Гэтэл хүүхэд 4–5 сар суралцсаны дараа ээжээсээ илүү болчихдог. Ээжүүд багшийн өгсөн гэрийн даалгаврыг самбараас хуулаад авч чадахгүй байх жишээтэй. Иймд малчин эмэгтэйчүүдийн боловсролын түвшинг дээшлүүлэх талаар анхаарах ёстой гэж боддог...*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын  
терийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас)

### Тохиолдол 1.5

*Малчин эмэгтэйчүүдийн боловсрол, тэр дундаа эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлмээр байна. Тухайлбал 2016 онд эхийн ноцтой хүндрэл гарч байсан. Манайх жирэмсэн ээжийг амаржих хугацаа нь дөхөнгүүт сарын хугацаанд 2 удаа аймаг руу хүргэж өгсөн. Сумын төвд амьдардаг, 3–4 хүүхэдтэй тэр ээж эхийн амрах байранд хүргэмэгц буцаад харьчихдаг. Дахиад хүргээд өгөхөөр 20 хоног хэвтэж байгаад эхийн амрах байрнаас оргоод сумын төвд ирээд маргааш нь амаржихдаа цус алдаж байсан...*

(Дорнод аймгийн нэгэн сумын эрүүл мэндийн төвийн эмчтэй хийсэн ярилцлагаас)

Энэ мэт боловсрол, мэдээллийн хүртээмжийн асуудал аймаг, сум бүрт хөндөгдөж байгаа бөгөөд төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, малчид өөрсдөө үүрэг хариуцлагаа ухамсарлах чадвар сул байгаагаас эрх нь зөрчигдөх тохиолдол гарсаар байна. Үүний зэрэгцээ зарим аймаг өөрийн эрх хэмжээний хүрээнд малчин эмэгтэйчүүдийг харилцан мэдээлэл солилцуулах, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах зорилгоор шинэ санаачилгууд хэрэгжүүлж байгааг сурталчлах, сэдэл өгөх үүднээс дараах тохиолдлуудыг жишээ болгов.

### Тохиолдол 1.6

*Сумандаа “Өөрчлөлтийг өөрөөсөө” хөтөлбөрийг 5 жилийн төлөвлөгөөтэй баталж ажиллаж байна. Малчдыг аравтын системд шилжүүлж, гэрт нь хүн очдоггүй, хүнтэй уулзаж чаддаггүй хүмүүст малчин эмэгтэйчүүдээр дамжуулан соёлжуулах ажлыг эхлүүлсэн. Ингэж чадвал гэр бүлийн*

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:  
ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХ, БЭЛГИЙН БОЛОН  
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

*хүчирхийлэл зэрэг асуудал багасах болов уу гэж найдаж байна. Энэхүү аравтын системд дандаа малчин эмэгтэйчүүд байдаг. Манайх 6 багтай учраас 6 аравтын системийн эхлэлийг тавьсан. Цаашдаа арав арван хүн хариуцаад 600 хүнтэй болно.*

[Хөвсгөл аймгийн нэгэн сумын төрийн албан хаагчидтай хийсэн ярилцлагаас]

## Тохиолдол 1.7

*Манай аймаг Төлчин эмэгтэйчүүдийн чуулган зохион байгуулдаг. Эхний жил үр дүн муу байсан. Чуулган болсон эхний өдрийн орой малчин эмэгтэйчүүдийн нөхрүүд нь архидах, зодолдох гэх мэт зөрчил гаргасан. Зохих хариуцлагыг нь хүлээлгээд журамласны дараа ийм зөрчил зогссон. Зарим малчин эмэгтэй нөхөртэйгээ ирж оролцдог болсон. Төлчин эмэгтэйчүүдийн чуулганаас олон санал гардаг, их мэдээлэл солилцдог. Энэ нь ард иргэдийг нийгэмшүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.*

[Завхан аймгийн удирдлагуудтай хийсэн ярилцлагаас]

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг баталж, 2020–2024 онд хэрэгжүүлэхээр болсныг сайшааж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлэхээр төлөвлөсөн нь тэднийг мэдлэг, ур чадвартай малчин болж төлөвшихөд чухал үр нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

### *Амьжиргаа, орлогын эх үүсвэр*

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх хэсэгт мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг "малчин" гэж тодорхойлсон болно. Судалгаанд хамрагдсан малчдын өрхийн орлогын бүтцийг авч үзвэл малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалт, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, өрхийн бизнес зэрэг бусад эх үүсвэрээс бүрдэж байна. Үүнээс малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалт өрхийн орлого бүрдүүлэхэд голлох нөлөө үзүүлдэг ч суурьшлын бүсэд ойр байх тусам малын ашиг шимээс гадна өөр бусад эх үүсвэрээс орлого олох боломж нэмэгддэг байна.

Малчин эмэгтэйчүүд амьдралын хэмнэл, улирлын онцлогоос хамаарч, урин дулаан цагт цагаан идээ боловсруулдаг хэдий ч өрхийн хэрэглээнээс хэтэрдэггүй байна. Сүүлийн үед бог малаа сааж, сүүг нь боловсруулахаа бараг больжээ. Хэрэв цагаан идээ үйлдвэрлэх технологийг хөгжүүлэхэд тодорхой дэмжлэг үзүүлбэл бог малаа сааж, орлогоо бага ч гэсэн нэмэгдүүлэх боломжтой байгаагаа ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үед малчин эмэгтэйчүүд хэлж байлаа.

Бэлчээрийн малын сүүний гарц өвлийн улиралд татарч, зун, намрын улиралд элбэгшдэг бол хаврын улиралд ноос, ноолуур, идэшний үеэр арьс, шир элбэгшдэг байна. Иймд малын түүхий эдээс олж буй орлого тогтмол бус бөгөөд зах зээл дэх түүхий эдийн үнэ ханшаас шууд хамааралтай байна. Сум, суурин газарт ойр амьдардаг малчид цагаан идээ борлуулж, ашгийг нь хүртэх боломж харьцангуй өндөр бол суурин газраас алслагдсан малчид хэрэгцээнээсээ илүү гарсныг нь зарж борлуулах боломж хомс байна.<sup>6</sup>

<sup>6</sup> "Малчдын аж байдлын судалгаа" Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, УБ, 2018 он.

Комиссын судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүд орлогоо дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 1.3 Гэр бүлийн орлогын эх үүсвэр

№	Гэр бүлийн орлого		Давхардсан тоогоор	Хувь
1	Үндсэн орлого	Ноос, ноолуур, арьс, шир, сүү, цагаан идээ, мал, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалт	313	62.3
2		Цалин хөлс	38	7.5
3		Тэтгэвэр, тэтгэмж	85	17
4	Бусад орлого	Хүнсний ногоо тарьж, борлуулах	19	3.8
5		Дэлгүүр, гуанз ажиллуулах, дээл хувцас оёх	2	0.4
6		Зээлтэй тул мал аж ахуйтай холбоотой аливаа ажил хийдэг	1	0.2
7		Нэмэлт орлогогүй	44	8.8
Нийт			502	100

Малчин эмэгтэйчүүдийн 55.4 хувь нь гэр бүлийн сарын орлогоо “320,000 төгрөгөөс бага” гэж хариулсан бол 1 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 6.5 хувийг эзэлж байв. Банкинд хадгаламжтай эсэхийг тодруулахад 68.3 хувь нь хадгаламжгүй байв. Мөн гэр бүлийнхээ санхүүг захиран зарцуулж, хэрэгцээт зүйлсээ худалдан авч чаддаг эсэхийг тодруулахад 50.2 хувь нь нөхөр/хамтран амьдрагчтайгаа хамт шийддэг, 41.2 хувь нь гэр бүлийнхээ санхүүг захиран зарцуулах асуудлыг өөрөө шийддэг ч, өөртөө зарцуулж чаддаггүй, 8.6 хувь нь “гэрийнхээ төсвийг захиран зарцуулах асуудлыг нөхөр/хамтран амьдрагч шийддэг” гэжээ.

### Тохиолдол 1.8

*Манай сумын эгч дүү малчдын ээж нь аймгийн төвд нас барсан. Нөхрүүд нь өөрсдөө мянгат малчид хэрнээ тус бүрд нь 10,000 төгрөг өгөөд явуулсан байх жишээтэй. Тэр мөнгөө буяны ажилд зарцуулаад зөвхөн эргэж ирэх шуудангийн зардалд 25,000 төгрөг өгсөн байв. Тэгээд замдаа хоол ч идэлгүй гэртээ ирсэн тохиолдол гарч байсан...*

[Сүхбаатар аймгийн нэгэн сумын төрийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас]

Түүнчлэн улсын хилтэй ойр зарим аймаг, сумын малчид тухайлбал Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хувьд цөөнгүй малчид Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд мал хариулж, гэрээгээр ажиллаж амьдралаа залгуулдаг байна.

### Тохиолдол 1.9

*Манай суманд малчид цөөрч байна. Мөнгө олохын тулд малчид урагшаа гарч мал малладаг болсон. Тэнд монгол малчны ажлын өдрийн хөлсийг 100 юаниар үнэлдэг. 30 хоног ажиллахад 2,800 юань авна. Энэ нь зах зээлийн ханшаар 1 сая орчим төгрөг болдог. Гэтэл дотооддоо нэг малчныг 1 сая төгрөгөөр цалинжуулах боломж байхгүй.*

*Малчид тэнд ямар орчинд ажиллаж байгааг мэдэх аргагүй, хянах боломжгүй. Хааяа хилийн цаанаас хятад дугаартай утаснаас ярьдаг...*

[Сүхбаатар аймгийн нэгэн сумын цагдаагийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас]



### *Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүндрэл бэрхшээл*

Малчдын хөдөлмөрийн нөхцөл нь цаг агаар, улирлын шинж байдал, өвс ногооны гарц, бэлчээр зэргээс шалтгаалдаг онцлогтой юм. Харин малчин эмэгтэйчүүдийн хувьд өрхийн хөдөлмөр хуваарилалт, мал аж ахуй эрхлэхэд зарцуулж буй цагаар хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цаг нь тооцогдохоор байна.

Комиссын судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүдийн өдөр тутамд эрхэлж буй ажил, хөдөлмөрийг дараах байдлаар тодорхойлжээ.

#### *Хүснэгт 1.4 Өдөр тутамд эрхэлж буй ажил, хөдөлмөр*

№	Малчин эмэгтэйчүүдийн өдөр тутамдаа эрхэлдэг ажил, хөдөлмөр	Давхардсан тоогоор	Хувь	
1	Мал аж ахуй эрхлэхтэй холбоотой хөдөлмөр	Мал саах, цагаан идээ боловсруулах	343	18.3
2		Малаа хариулах, услах, эрж хайх	244	13.1
3		Төл мал угжих, хооллох, өвчтэй мал эмнэх	214	11.4
4		Малын хашаа хороо барих, цэвэрлэх	198	10.6
5		Хонь хяргах, ямаа самнах	3	0.2
1	Ахуйн хүрээн дэх хөдөлмөр	Гэр цэвэрлэх, хоол хийх, хувцас угаах, дээл хувцас оёх	368	19.7
2		Хүүхэд харах, өндөр настай аав, ээжээ асрах	270	14.5
3		Ундны ус, түлээ, түлшээ бэлтгэх	227	12.1
Нийт		1,867	100	

Малчин эмэгтэйчүүдээс өглөө хэдэн цагт босч, орой хэдэн цагт унтаж амардаг талаар тодруулахад 76.2 хувь нь “4–6 цагт босдог”, 23.5 хувь нь “6–8 цагт босдог”, 0.3 хувь нь “9–10 цагт босдог” гэжээ. Харин 41.3 хувь нь “19–22

цагт унтдаг”, 58.7 хувь нь “22–02 цагт унтдаг” гэж тус тус хариулжээ. Үүнээс үзэхэд малчин эмэгтэйчүүд өдөрт дунджаар 15–20 цагийн хөдөлмөр эрхэлж байна. Мөн тэд хавар, намар, зуны улиралд мал төллөх, сааль сүүний үеэр илүү уртасгасан цагаар ажилладаг талаар ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагаар хэлж байлаа.

Уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч, экосистем болон биологийн олон янз байдлын тоо хэмжээ, амьдрах орчны өөрчлөлт нь малчдад томоохон сорилт болж байгаа төдийгүй ахуй амьдрал, мал аж ахуйгаа эрхлэхэд нь нөлөөлөх болжээ.<sup>7</sup> Ялангуяа зуд, ган, хуурайшилт, бороо, цас, шуурга, үер зэрэг байгалийн үзэгдэл, гамшгийн давтамж нэмэгдэж байгаагаас мал аж ахуй эрхлэхэд учрах хохирлын хэмжээ ихсэхийн сацуу малчид гэмтэж бэртэх, амь нас эрсдэх аюултай байна. 2018–2019 онд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, осолд өртсөн малчдын мэдээлэлтэй танилцахад дараах байдалтай байна.<sup>8</sup>

Хүснэгт 1.5 Гамшиг, аюулт үзэгдэл,  
осолд өртсөн малчдын статистик мэдээлэл

Он	Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	Өртсөн малчид	Хувь	Хорогдсон малын тоо	Учирсан хохирлын хэмжээ (төгрөгөөр)
2018	4,373	304	6.95	1,906,565	467.3 тэрбум
2019	4,990	262	5.25	26,134	35.8 тэрбум

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас 2018 онд 208 хүн нас барсны 29 нь малчин байсан бөгөөд 12 нь малаа даган төөрч, сураггүй болж, 15 нь үер усны ослоор, 2 нь гал түймрийн улмаас нас баржээ. Харин 2019 онд 203 хүн

<sup>7</sup> “Монгол Улсын бэлчээрийн тогтвортой байдал, Малчдын амьжиргаа ба уур амьсгалын өөрчлөлт”, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Азийн хөгжлийн банкнаас гаргасан эмхэтгэл, УБ, 2014 он.

<sup>8</sup> Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны 11 дүгээр сарын 13–ны өдрийн 6/2612 дугаар албан бичиг, 2019 оны гамшиг, аюулт үзэгдэл, ослын нэгдсэн мэдээлэл: <https://nema.gov.mn/n/94381>

нас барсны 7 нь малчин байснаас 6 нь малаа даган төөрч сураггүй болж, 1 нь аянганд цохиулж нас баржээ.

## Тохиолдол 1.10

*Манайх зуднаар бүх малаа алдаад баруун аймгаас Булган, Эрдэнэтийн залгаа нутагт шилжин ирж, айлд үхэр маллан гэр бүлээрээ туслах малчнаар ажиллахаар болов. Нийт 30 гаруй үнээ маллаж, саадаг, сүүг нь сүүний үйлдвэрт өгдөг учраас өглөө оройдоо үнээгээ саахад дор хаяж 2-3 цаг зарцуулдаг байв. Энэ нутагт бороо орох үед аянга цахилгаан ихтэй.*

*Нэг удаа үнээ сааж байхад дуу цахилгаантай хүчтэй бороо орлоо. Үнээгээ заавал саахгүй бол нормын сүүг өгч чадахгүй болох учир нөхөртэйгөө хамт үнээгээ саасан. Тэгээд ч харанхуй болох гээд юм юм л давхцаад байсан үе юм. Тэгсэн сүүлийн 2 үнээгээ ивэлгээд сааж байх үеэр хүчтэй аянга бууж, миний бие аянгад өртсөн. Саалийн хувин маань төмөр хувин байсан татсан болов уу гэж боддог. Мөн малын хашаа хороог төмрөөр бэхэлсэн байсан. Ер нь тэгээд хуванцар сав хортой гэхээр нь сааль сүүнд хуванцар сав хэрэглэдэггүй, уг нь модон саалийн хувин байсан бол ийм юм болохгүй ч байсан юм бил үү гээд юм юм л бодогддог.*

*Булганы харьяа нутаг хэдий ч Эрдэнэттэй ойрхон учраас хамгийн ойр газраас манай эзэн тусламж дуудаж авчирсан. Эмнэлгийн тусламж ирэх хооронд намайг шороонд нэлээд удаан булж байлгасан. Бүтэн жил эмчлүүлж, гайгүй болсон ч одоо байнгын эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон...*

(Орхон аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

Малчин эмэгтэйчүүдээс байгаль, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд, мал хариулах үедээ гэмтэл бэртэл авч байсан эсэхийг тодруулахад 28.9 хувь нь дараах шалтгаанаар “гэмтэж бэртсэн” гэжээ.

Хүснэгт 1.6 Гэмтэж бэртсэн тохиолдол

№	Гэмтэж бэртсэн тохиолдол	Хариулт	Хувь
1	Малд хазуулах, өшиглүүлэх, гишгүүлсэн	98	32.1
2	Морь, тэмээ зэргээс унасан	63	20.7
3	Наршсан	58	19
5	Гар, хөлийн хуруу, нүүр, чихээ хайрч, хөлдөөсөн	44	14.4
6	Хальтирч унахдаа гар, хөл, хүзүү толгойгоо гэмтээсэн	41	13.4
7	Байгалийн гамшигт үзэгдэл болоход гэр нурснаас гэмтсэн	1	0.3
Нийт		305	100

Цаг агаарын хүнд нөхцөлд аюулгүй байдлаа хангахдаа гол төлөв дулаан хувцаслаж, гэр бүлийнхээ хэн нэгэн гишүүнтэй хамт малд явдаг, үр хүүхдээ харах хүнгүй үед нөхөр нь ганцаараа малдаа явах зэргээр зохицуулдаг байна. Үүний зэрэгцээ хүн бүл цөөтэй малчин эмэгтэйчүүд цаг агаар муу үед бага насны хүүхдээ гэртээ үлдээж, малдаа явах тохиолдол олонтаа гардаг ажээ.

Тохиолдол 1.11

*Ам бүл цөөтэй учир өвөл цас ихтэй, цаг агаарын хүнд нөхцөлд мал маллах хүндрэлтэй байдаг. Нэг удаа мал цасан шуурганд уруудаад нөхөр бид хоёр хойноос нь явсан. Ингэхдээ 3 настай хүүгээ гэртээ уяж орхиод, галаа сайн түлээд түгжээд явсан. Тэр шөнөдөө малаа олж чадалгүй хээр хоносон. Хүү гэртээ ганцаараа яаж байгаа бол гэж их санаа зовсон. Аз болоход муу юм болоогүй...*

(Өмнөговь аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

Байгаль, цаг уурын хүнд нөхцөлөөс гадна нийгэм, соёлын хүчин зүйлстэй холбоотойгоор хот айлаар амьдрах

хэв маяг өөрчлөгдөж, туслах малчинтайгаа хоёр гэрээр амьдрах, эсхүл ганц айлаараа амьдрах үзэгдэл нийтлэг болжээ. Үүнээс үүдэн малын хулгай ихсэх, хүчирхийлэл, дарамтад өртөх, амь насаа алдах зэрэг сөрөг үр дагавар гарах болсон бөгөөд ялангуяа ам бүл цөөн өрх толгойлсон малчин эмэгтэйчүүд малаа хулгайд алдах, бэлгийн хүчирхийлэлд өртөх болжээ.

### Тохиолдол 1.12

*Малчид малаа хулгайд их алддаг боллоо. Хулгайч ихэвчлэн өрх толгойлсон эмэгтэй, өндөр настан, хүн хүч муутай айлуудыг судалж, малыг нь хулгайлдаг. Яагаад гэвэл тэд тэр болгон малынхаа араас эрэл хайгуул болж хөөцөлдөж чаддаггүй. Одоогийн Эрүүгийн хуулиар 24-өөс дээш тооны бог мал хулгайлсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Харин бага тооны мал хулгайлсан бол баривчлах юм уу торгох ялаар шийтгэх зохицуулалттай болохоор малыг 5-10 тоогоор хулгайлах нарийн аргад шилжсэн. Үүнээс болж малчид малаа цувуулж алдсаар 40-50 малтай үлдэж байгаа тохиолдол бий. Иймд энэ хуулийг эргэн харах зайлшгүй шаардлагатай байна...*

[Хөвсгөл аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас]

### Тохиолдол 1.13

*Энэ жил өрх толгойлсон хоёр малчин эмэгтэй нас барсан. Нэг нь малдаа өвс өгч байгаад нас барсан, нөгөөх нь гэртээ нас барсан байдалтайгаар олдсон. Тэдний аль аль нь ганц бие эмэгтэй малчид байсан...*

[Хөвсгөл аймгийн нэгэн сумын төрийн албан хаагчидтай хийсэн ярилцлагаас]

Байгалийн гамшгаас гадна хүний буруутай үйл ажиллагаа, малчдын хувийн бэлтгэл, бэлчээрийн даац алдагдаж нөөц хүрэлцэхгүй байгаа, малын өвчин, мал эмнэлгийн үйлчилгээ, мал сүргийн бүтцийн зохистой харилцаа алдагдсан, малын чанар чансаа муудсан зэрэг хүчин зүйл нь малын өсөлт, хорогдолтод сөрөг нөлөөтэй байна.

Монгол Улс 111 сая га бэлчээр, 1.7 сая га хадлангийн талбай бүхий нийт 112.7 сая га газартай. Нийт малын тоо 2018 оны эцэст 66.5 сая толгойд хүрсэн бөгөөд хангайн болон хээрийн бүсийн бэлчээрт хамгийн их сөрөг нөлөө үзүүлдэг ямааны тоо нийт малын 40.8 хувийг эзэлж байна. Түүнчлэн малын тоо толгой 1990 оноос хойш 2.5 дахин өссөн нь бэлчээрийн доройтол үүсэх үндсэн нөхцөл болж байна. Бэлчээрийн доройтол, цөлжилтийн нэг шалтгаан нь малчид нийтийн нөөц бэлчээрийг зохицуулалтгүй, хэт ашиглаж байгаа явдал бөгөөд цөлжилтийг улам эрчимжүүлж байна. Байгаль орчин, уур амьсгал, нийгмийн голлох хүчин зүйлийн хүрээнд хийсэн үнэлгээгээр 2016 оны төлөв байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөөд байгаа бөгөөд үүнээс хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газар 22.9 хувийг эзэлж байна. Газрын доройтол илэрсэн нийт нутаг дэвсгэрийн 49 хувийг хүний болон малын тоо толгой, үлдсэн 51 хувь нь байгалийн хүчин зүйлсээс болж доройтож байна.<sup>9</sup>

Монгол Улсын хувьд тулгамдаж буй экологийн бүлэг асуудал нь цөлжилт, газрын доройтол юм. Иймд бэлчээр ашигласны татвар оногдуулах, малын тоо толгойг зохистой хязгаарт барих, ялангуяа бэлчээрт халтай ямаан сүргийн тоо толгойг хязгаарлах мөн бэлчээрийг сэлгэн ашиглах, отор нүүдлийн зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

<sup>9</sup> Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, УБ, 2019 он.

*Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал*

Үндэсний статистикийн хорооны “Ажиллах хүчний судалгаа”-гаар 2019 онд Монгол Улсад нийт 1,146,162 ажиллагчид байна.

Хүснэгт 1.7 Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын статистик мэдээлэл (2019 он)


Ангилал	Нийт хүн	Хүйс			
		Эрэгтэй		Эмэгтэй	
		хүн	хувь	хүн	хувь
Нийт ажиллагчид	1.146,162	606,814	55.6	539,348	44.3
Албан журмын даатгуулагчид	813,744	416,338	51.2	397,406	48.8
Сайн дурын даатгуулагчид	188,212	69,196	36.8	119,016	63.2
Нийт малчид	285,482	166,368	58.3	119,114	41.7
Нийгмийн даатгал төлдөг малчид	78,227	42,513	54.3	35,714	45.7

2019 оны байдлаар нийт малчдын 27.4 хувь нь буюу 78,227 малчин нийгмийн даатгалд хамрагджээ. Тэдний 42,513 нь буюу 54.3 хувь нь эрэгтэй, 35,714 нь буюу 45.7 хувь нь эмэгтэй малчид байна. Нийгмийн даатгалын ерөнхий газраас эдийн засгийн идэвхтэй хүн амын 75.7 хувь нь нийгмийн даатгалд даатгуулсан, харин даатгалд хамрагдах ёстой үлдсэн 25 орчим хувийн олонхийг малчид<sup>10</sup> эзэлж, нийгмийн даатгалд хамрагдалт тааруу байна гэжээ.<sup>11</sup>

<sup>10</sup> Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас бусад иргэн нийгмийн даатгалын сайн дурын хэлбэрт хамрагдаж болно. Үүнд: малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, газар тариалан эрхлэгч, бичил уурхай эрхлэгч, чөлөөт уран бүтээлч, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн, гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэн, оюутан суралцагч, бусад иргэн хамаарна. Сайн дурын даатгуулагч нь сар бүр өөрийн мэдүүлсэн орлогоосоо 11,5 хувь тэтгэврийн даатгалд, 1 хувь тэтгэмжийн даатгалд, 1 хувь үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд нийт 13,5 хувиар шимтгэл төлнө.

<sup>11</sup> Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээс, 2020 он. <http://www.ndaatgal.mn/v1/view/1202>

Бүдүүвч 1.8 Малчдын нийгмийн даатгалд хамрагдсан  
байдал насны бүлэг (2019 он, хувиар)




Эрүүл мэндийн даатгалд 2019 онд нийт малчдын 188,545 нь буюу 66 хувь нь хамрагдсан байна. Тэдний 103,128 нь буюу 54.7 хувь нь эрэгтэй, 85,417 нь буюу 45.3 хувь нь эмэгтэй малчид байна. Нийт эрэгтэй малчдын 62 хувь, эмэгтэй малчдын 71.7 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагддаг байгаа нь эмэгтэйчүүд эрүүл мэндийн даатгалд хамрагдах нь эрэгтэйчүүдээс 9.7 пунктээр илүү байна.<sup>12</sup>

<sup>12</sup> Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn), “Хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга” урьдчилсан мэдээ, 2020 он.



Бүдүүвч 1.9 Малчдын эрүүл мэндийн даатгалд  
хамрагдсан байдал насны бүлэг (2019 он, хувиар)



Малчин эмэгтэйчүүд нийгмийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа шалтгаанаа орлого хүрэлцдэггүй, бэлэн мөнгөгүй, мөн газар зүйн хувьд алсмагдал, мал хариулах хүн хүч цөөнтэйгөөс сумын төв орж, нийгмийн даатгалын шимтгэл төлөх боломжгүй байдгаар тайлбарлажээ.

Харин залуу малчдаас нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа шалтгааныг тодруулахад ач холбогдлыг нь мэдэхгүй, шимтгэл төлөх сонирхол багатай, энэ талаар тогтмол мэдээлэл авч чаддаггүй гэжээ.

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг баталснаар тус хууль 2020 оноос хэрэгжиж эхэллээ.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд орсон 2017 оны нэмэлт, өөрчлөлтөөр малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил хоёр сараар шимтгэл төлж ажилласан хугацаагаар тооцож байгааг 2020 оны

1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг жилийг нэг жил зургаан сараар тооцохоор болсон билээ. Дээрх нэмэлт, өөрчлөлтөөр малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулж, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 55 нас хүрсэн, 20-иос доошгүй жил ажилласан, үүнээс 15-аас доошгүй жилд нь малчнаар ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй; 50 нас хүрсэн, нийт 20-иос доошгүй жил ажилласан, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй тус тус өндөр насны тэтгэврээ тогтоолгох эрхтэй болжээ.

Гэтэл судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн олонх нь эдгээр хуулийн талаар тодорхой мэдээлэлгүй, тэтгэврээ тогтоолгоход хүндрэл чирэгдэлтэй байгаа болон нийгмийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа талаар хэлж байв.

#### Тохиолдол 1.14

*Би 50 нас хүрээд малчнаар тэтгэвэрт гарах гэтэл ажилласан жил нь хүрэхгүй байна гээд тогтоож өгөөгүй. Уг нь 1990 оноос хойш тогтмол мал маллаж байгаа юм. 1993–1994 онд ажилласан жил тасарсан байсныг архивын лавлагаа мэдээлэл авч, мөн 1990–2000 оны ажилласан жилийг нөхөн тооцуулсан. Гэтэл малчин гэдгээ тодорхойлуулах шаардлага тавиад бичиг баримтыг хүлээж авахгүй, тодорхой зөвлөгөө мэдээлэл өгөхгүй байгаа тул танайд хандаж байна. Ямар бичиг баримт цуглуулж, малчин гэдгээ хэрхэн тодорхойлуулах талаар зөвлөгөө өгнө үү...*

(Завхан аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйд  
Комиссоос өгсөн хууль зүйн зөвлөгөөний тэмдэглэлээс)

### Тохиолдол 1.15

*Малчин эмэгтэйчүүд 50 нас хүрээд тэтгэвэрт гардаг. Хуульд сүүлийн 15 жилд мал малласан байх, нийгмийн даатгалаа төлсөн байх гэсэн шаардлага байдаг. Гэтэл насаараа мал малласан, урьд нь нийгмийн даатгалаа төлөөгүй хүмүүс үүнээс хоцорч байна...*

(Хөвсгөл аймгийн нэгэн сумын төрийн албан хаагчидтай хийсэн ярилцлагаас)

### Тохиолдол 1.16

*Хөдөө, орон нутгийн залуучууд нийгмийн даатгал төлөхөд хүндрэлтэй байна. Ажлын байр байхгүй, тогтмол орлогогүй, ноос ноолуурын цагаар л мөнгөтэй золгодог. Энэ үед л төлөх боломжтой байдаг...*

(Өмнөговь аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаас)

Комиссын судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн 78.4 хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байв. Малчдын дунд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх журам, түүнээс хүртэх үр ашгийн талаар мэдлэг, мэдээлэл хомс байгаа тул энэ чиглэлээр сурталчилгаа нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулах шаардлагатай байна. Тэдний амьжиргааны түвшин ялгаатай, өрхийн орлого нь малын тоо толгойноос голчлон хамаарч байгаа тул эдгээр даатгалд хамруулах зорилгоор шимтгэл төлөх уян хатан зохицуулалт, урамшууллын механизмыг нэвтрүүлэх нь зөв юм.


### Туслах малчны хөдөлмөр

Нийт 285,482 малчны 270,304 нь буюу 94.7 хувь нь үндсэн малчин, 15,178 нь буюу 5.3 хувь нь туслах малчин байна.<sup>13</sup>

Хүснэгт 1.8 Үндсэн болон туслах малчдын харьцуулсан үзүүлэлт (2019 он)

Насны бүлэг	Нийт	Харьцуулсан үзүүлэлт				Дүнд эзлэх хувь	
		Үндсэн малчин	Эрэгтэй	Эмэгтэй	Туслах малчин	Үндсэн малчин	Туслах малчин
Нийт	285,482	270,304	162,795	107,509	15,178	100	100
15-24	23,776	21,340	15,068	6,272	2,436	7.9	16
25-34	64,693	61,052	37,867	23,185	3,641	22.6	24
35-44	84,134	79,948	47,133	32,815	4,186	29.6	27.6
45-54	64,006	60,947	36,108	24,839	3,059	22.5	20.2
55-64	33,680	32,352	18,880	13,472	1,328	12	8.7
65 ↑	15,193	14,665	7,739	6,926	528	5.4	3.5

Бүдүүвч 1.10 Үндсэн болон туслах малчдын харьцуулалт (2019 он, хувиар)



Судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн 3 хувь нь туслах малчнаар ажилладаг, туслах малчин өрхийн гишүүн байв. Туслах малчнаар өрхийн амьжиргаагаа залгуулж

<sup>13</sup> Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn), “Хөдөө аж ахуйн салбарын 2019 оны танилцуулга”, урьдчилсан мэдээ 2020 он.

буй малчин эмэгтэйчүүдэд цалин хөлс, хөдөлмөрийн үнэлэмжтэй холбоотой саад бэрхшээл тулгардаг талаар тэд дурдаж байв. Тухайлбал малчин айл туслах малчин авч ажиллуулахдаа гэрээ байгуулдаггүй, цалин хөлсийг бэлэн мөнгөөр өгдөггүй, оронд нь талх, гурил, элсэн чихэр, будаа зэрэг хүнсний бүтээгдэхүүн эсвэл мал өгөх нь нийтлэг ажээ. Түүнчлэн хөдөлмөрийг нь үнэгүйдүүлэх, дарамтлах тохиолдлын талаар ярьж байв.

### Тохиолдол 1.17

*Манайх ам бүл 8, нөхөр 6 хүүхэдтэйгээ амьдардаг. Өөрийн малгүй, айлын 160 толгой үхэр маллаж, туслах малчнаар ажилласан. Гэр бүлээрээ ажиллаад сард 250,000–300,000 төгрөгийн цалин авдаг. Нөхөр болон 2 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй тул ганцаараа мал маллаж, сааль сүүгээ боловсруулах ажил хийж гэр бүлээ тэжээхэд хүнд байна. 4 ханатай гэр маань их муудсан, салхи шуурганд нурахад бэлэн...*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

### Тохиолдол 1.18

*Бид сумын төвөөсөө 20 гаруй километр зайтай нутагладаг. Гэр бүлээрээ туслах малчнаар ажиллаад сард 250,000 төгрөгийн цалинтай. Энэ цалингаар гэр бүлийнхээ наад захын хэрэгцээг хангаж хүргэхгүй байна. Сум орж дэлгүүрээс хүнс, ахуйн хэрэгцээний зүйлсээ авахдаа тухайн сарынхаа цалинг өмнөх сарынхаа өрөнд суутгаж, өрнөөс өрний хооронд амьдарч байна. Дэлгүүрээс хүнс, ахуйн хэрэгцээний зүйлсээ тэмдэглүүлж, зээлээр авдаг учир нэмэгдэл үнээр бодож тооцдог.*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

### Тохиолдол 1.19

*Туслах малчин авна гэсэн зарын дагуу нөхөр маань ажилд ороод сүүлдээ нөгөө малчин айлдаа хүргэн болсон. Хамт яваагүйгээс ийм байдал үүссэн. Одоо би 3 хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй болсон...*

(Баянхонгор аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

### Тохиолдол 1.20

*Туслах малчид дунджаар 5–6 ам бүлтэй өрхийн гишүүд байна. Тэд сардаа 300,000–400,000 орчим төгрөгийн цалинтай байна...*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын багийн Засаг даргатай хийсэн ярилцлагаас)

Цаашид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн тухай болон холбогдох хууль тогтоомжид туслах малчны нэр томъёог тодорхойлох, туслах малчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалин хөлсийг мөнгөөр төлөхтэй холбоотой зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

## 1.2 Малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх эрхийн асуудал

Хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд хүн бүр амьдарч буй орчин, гэр бүлдээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг баталгаажуулсан болно.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 1 дүгээр зүйлд “Энэхүү конвенцын зорилгоор эмэгтэйчүүдийг ялгаварлах гэсэн нэр томьёо нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарт эмэгтэйчүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх, эсхүл үгүйсгэх үр дагавар, эсхүл зорилго бүхий ялгаварлах, үгүйсгэх гадуурхах буюу хязгаарлахыг хэлнэ” гэж заажээ.

Үүнийг Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хорооны 1992 оны 19 дүгээр Ерөнхий зөвлөмжид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба ялгаварлан гадуурхах явдлын хоорондын харилцаа холбоог тодотгон, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтын хэлбэрийг бий болгодог, ялгаварлан гадуурхалт нь энэ төрлийн хүчирхийлийн гол шалтгаан болно гэж тайлбарласан байна.

Тус Ерөнхий зөвлөмжид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүйсэд тулгуурласан, эрэгтэйчүүдтэй адил тэгш эрх, эрх чөлөө эдлэх эмэгтэйчүүдийн боломжийг ноцтойгоор хязгаарлаж байгаа ялгаварлан гадуурхалтын хэлбэр мөн бөгөөд үүнд бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хор уршигт хүргэж буй үйлдэл, эсвэл аюул заналхийлэл, зовлон шаналгаа учруулан, хүний эрх, эрх чөлөөг бусад байдлаар хязгаарлах аливаа үйлдэл, эс үйлдэхүй хамаардаг гэж тодорхойлжээ.<sup>14</sup>

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гол төлөв гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрээр илэрч байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн гишүүний хэн нэгэн нөгөөгөө

<sup>14</sup> Хүний эрхийн конвенцуудын хорооноос батлан гаргасан ерөнхий санал зөвлөмжүүдийн эмхэтгэл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, УБ, 2004 он.

хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор хяналтаа тогтоон, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус харилцаа бөгөөд энэ нь нэг удаагийн санаандгүй үйлдэл бус, дахин давтагдах, даамжрах шинжтэйгээрээ бусад хэлбэрийн хүчирхийллээс ялгардаг юм.

Монгол Улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2016 онд шинэчлэн батлахдаа хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг “Гэр бүлийн хүчирхийлэл”<sup>15</sup> хэмээн тодорхойлж, иргэний эрх зүйн маргаан бус гэмт хэрэг, зөрчил болохыг хуульчилжээ.

Хуулийн шинэчилсэн найруулга нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, тэдэнд үйлчилгээ үзүүлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход чиглэсэн бөгөөд дараах гол өөрчлөлтүүд орсон байна.

---

<sup>15</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 5.1.1 дэх хэсэг.



Бүдүүвч 1.11 Хамтарсан багийн чиг үүрэг,  
гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх субъект

ХАМТАРСАН БАГ, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ



- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;
- Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;
- Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх.

Гэр бүлийн хүчирхийллийг  
мэдээлэх үүрэг бүхий этгээд

Иргэн, хуулийн этгээд мэдээлэх боломжтой

Сум, дүүрэг,  
баг, хорооны  
холбогдох  
албан  
түшаалтан

Төрийн  
албан  
хаагч

Гэрээгээр  
төрийн үүргийг  
гүйцэтгэгч  
төрийн бус  
байгууллагын  
ажилтан

Багш,  
сургуулийн  
нийгмийн  
ажилтан, бусад  
ажилтан

Эрүүл мэндийн,  
нийгмийн,  
хүүхэд, гэр  
бүлийн асуудал  
хариуцсан  
ажилтан

Хэнд



Сум, багийн Засаг дарга

Цагдаагийн албан хаагч

Цагдаагийн байгууллагад 2019 онд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 985 бүртгэгдсэн байна.<sup>16</sup>

Хүснэгт 1.9 Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн статистик мэдээлэл (2018, 2019 он)

Он	Дорнод	Сүх-баатар	Завхан	Хөвсгөл	Баян-хонгор	Өмнө-говь	Улаан-баатар	Бусад аймаг	Нийт
2018	24	21	3	38	31	11	590	352	1070
2019	30	9	17	17	17	21	494	380	985

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын мэдээлэл доорх байдалтай байна.<sup>17</sup>

Хүснэгт 1.10 Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн статистик мэдээлэл (2018, 2019 он)

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч			Үүнээс		Хэлбэр							
			Аюулын зэргийн үнэлгээ хийсэн эсэх		Бие махбодын		Сэтгэл санааны		Бэлгийн		Эдийн засгийн	
Аймаг/он	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Дорнод	4	24	4	24	3	22	1	15				
Сүхбаатар	16	9	16	9	2	4		1		2		
Завхан	3	17	3	17	2	15	1	2		1		
Хөвсгөл	19	18	19	18	15	9	2	2		2		
Баянхонгор	28	14	28	14	25	4	5	1	1		1	

<sup>16</sup> Цагдаагийн ерөнхий газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэл” (EGBV) төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээлэл, өргөдөл, гомдол, захиргааны зөрчил, гэмт хэрэг, хүчирхийлэл үйлдэгчийн мэдээллийг нэгтгэж нэгдсэн судалгаа, лавлагаа хийх боломжтой мэдээллийн сан бүрдүүлсэн байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл (Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ) <https://police.gov.mn/resource/information/File/2020/01/06/w3fp8kgj5qn65i7n/2019.12%20sar%20Burtgegsen%20gemt%20hereg.pdf>

<sup>17</sup> Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэгт өртсөн хохирогчийн мэдээлэл (Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ) <https://police.gov.mn/resource/information/File/2020/01/06/ztqfo2kss9i3oapm/2019.12%20sar%20Hohirogch%20itgen%20baigiillaga.pdf>

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:  
ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХ, БЭЛГИЙН БОЛОН  
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Өмнөговь	6	11	6	11	6	11	1					
Улаанбаатар	418	437	418	437	233	205	46	98	2	7	2	3
Бусад аймаг	303	364	303	364	261	295	107	129	13	16	1	
Улсын дүн	797	894	797	894	547	565	163	248	16	28	4	3

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2018–2019 онд хянан шийдвэрлэсэн Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хохирсон хохирогчийн статистик мэдээлэл дараах байдалтай байна.<sup>18</sup>

Хүснэгт 1.11 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хохирсон хохирогчийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн статистик мэдээлэл (2018, 2019 он)

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч					Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр							
					Бие махбодын		Сэтгэл санааны		Бэлгийн		Эдийн засгийн	
Аймаг/он	2018	Малчин	2019	Малчин	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Дорнод	9	2	3	–	6	2	2	–	–	1	1	–
Сүхбаатар	4	–	–	–	4	–	–	–	–	–	–	–
Завхан	–	–	2	–	1	2	–	–	–	–	–	–
Хөвсгөл	7	2	7	2	7	7	–	–	–	–	–	–
Баянхонгор	7	–	4	–	4	–	–	–	–	–	–	–
Өмнөговь	7	1	–	–	7	–	–	–	–	–	–	–
Улаанбаатар	55	–	84	–	48	52	6	30	1	–	–	2
Бусад аймаг	42	7	60	5	44	55	4	5	–	–	–	–
Улсын дүн	131	12	160	7	117	122	12	35	1	1	1	2

Шүүхээс 2018–2019 онд хянан шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн зөрчлийн хэргийн статистик мэдээллээс үзэхэд 2019 онд Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд

<sup>18</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн статистик мэдээлэл болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 04/210 дугаар албан бичиг.

хамаарах 7,122 зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн нь нийт шийдвэрлэсэн зөрчлийн 39.4 хувийг эзэлж байна.<sup>19</sup>

Хүснэгт 1.12 Шүүхээс гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг хянан шийдвэрлэсэн статистик мэдээлэл (2018, 2019 он)

Он	Зөрчлийн хэргийн төрөл	Хэргийн тоо	Холбогдогчийн тоо	Шийдвэрлэх шатанд буй хэрэг	Шийдвэрлэлт			Торгосон	Баривчилсан
					Хэрэгсэхгүй болгосон	Шийтгэлээс чөлөөлсөн	Шийтгэл оногдуулсан		
2018	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих (Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг)	4,239	4270	14	54	7	4,210	173	4,027
2019		7,134	7178	10	47	9	7,122	166	6,951

Харин цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчил, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн 2016–2019 онуудын статистик мэдээллийг харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 1.13 Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт зөрчил болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн статистик мэдээллийн харьцуулалт (2016–2019 он)


№	Нөхцөл байдал	2016	2017	2018	2019
1	Нийт зөрчил	1,038,050	1,327,017	1,698,178	2,175,825
	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил	1,886	4,369	5,821	8,962
2	Нийт зөрчилд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн эзлэх хувь	0.2	0.3	0.3	0.4

<sup>19</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн статистик мэдээлэл болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 04/210 дугаар албан бичиг.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:  
ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХ, БЭЛГИЙН БОЛОН  
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

<b>3</b>	Гэр бүлийн хүчирхийллээр баривчлагдсан хүн	592	2,889	3,680	6,400
----------	--	-----	-------	-------	-------

Бүдүүвч 1.12 Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн өсөлт бууралт (2016–2019 он)



Цагдаагийн байгууллагад 2019 онд 2.175,825 зөрчил бүртгэгдсэний 8,962 нь буюу 0.4 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байна. Ийнхүү зөрчил гаргасан 6,634 хүнд 29.735,000 төгрөгөөр торгох, 6,400 хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ. Мөн онд цагдаагийн алба хаагчид гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг шалгахдаа хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн 10,238 үнэлгээг хийсэн байна.<sup>20</sup>

Судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдээс хүчирхийллийн талаарх мэдлэг ойлголтоо хэрхэн үнэлж байгааг тодруулахад 40.5 хувь нь “дунд”, 37.5 хувь нь “сайн”, 13.5 хувь нь “маш сайн”, 7 хувь нь “муу”, 1.5 хувь нь “маш муу” гэжээ. Тэдний 14 хувь нь алгадаж, цохих, өшиглөх, гарт таарсан зүйлсээ шийдэх, 13 хувь нь хэл амаар доромжлох,

<sup>20</sup> Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 9/5964 дүгээр албан бичиг болон Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээллээс, 2020 он.

дайрч давшлах, 10 хувь нь айлган сүрдүүлэх, гэрээс хөөх, 8 хувь нь хутга, мэсний зүйлс барьж, айлган сүрдүүлэх, 6.8 хувь нь үснээс зулгаах, хоолой боох зэрэг үйлдэл бүхий хүчирхийллийн хэлбэр нийтлэг гардаг гэжээ.

Малчин эмэгтэйчүүдээс хүчирхийллийг таньж мэдэх, мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх, зөвлөгөөг хаанаас авах боломжтой талаар тодруулахад 58.1 хувь нь телевиз, 11.1 хувь нь нийгмийн сүлжээ, бусад нь радио, сонин, нийгмийн ажилтан, найз нөхөд, өрхийн эмч, баг, хорооны Засаг дарга зэргийг дурджээ.

### Тохиолдол 1.21

*Өдөр тутам хүчирхийлэлд өртдөг ч түүндээ дасан зохицож амьдардаг эмэгтэйчүүд олон. Би ч тэдний нэг. Өөрийгөө хүчирхийлэлд өртөж байна гэж бодоогүй явсан. Та бүхний өгсөн мэдээллээс л энэ тухай мэдлээ. Эмэгтэйчүүд бидэнд сургалт, мэдээлэл маш их хэрэгтэй байна. Тиймээс дараагийн удаа сургалтад суумаар байна...*

(Хөвсгөл аймгийн нэгэн сумын  
малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

Санал бодлоо ямар нэг айдасгүйгээр нөхөр/хамтран амьдрагчдаа хэлж чаддаг эсэхийг тодруулахад 88.6 хувь нь “чөлөөтэй илэрхийлдэг”, 11.4 хувь нь “чөлөөтэй илэрхийлж чаддаггүй, айдастай байдаг” гэжээ. Тоймлон авч үзвэл, Комиссын судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн 24.3 хувь нь тодорхой хэмжээгээр хүчирхийлэлд өртсөн буюу өртдөг талаараа дурдсан болно. Ямар төрлийн хүчирхийлэлд өртөж байгаа талаар дараах хариултыг өгчээ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:  
ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХ, БЭЛГИЙН БОЛОН  
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Хүснэгт 1.14 Хүчирхийллийн хэлбэрээ тодорхойлсон байдал

№	Хүчирхийллийн хэлбэр	Хариулт	Хувь
1	Бие махбодын хүчирхийлэл (зодож, цохих, юм авч шидэх, сур ташуураар ороолгох гэх мэт)	53	34.2
2	Сэтгэл санааны хүчирхийлэл (хэл амаар доромжлох, айлган сүрдүүлэх, гэрээс хөөх гэх мэт)	72	46.4
3	Эдийн засгийн хүчирхийлэл (мөнгө төгрөг өгдөггүй, хоол ундаар гачигдуулдаг, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг өөрт өгөхгүй хурааж авах гэх мэт)	15	9.7
4	Бэлгийн хүчирхийлэл (хүсээгүй байхад биеийн эмзэг хэсэгт хүрэх, бэлгийн харилцаанд орохыг шаардах, хүчээр бэлгийн харилцаанд орох гэх мэт)	15	9.7
Нийт		155	100

Хүчирхийлэлд өртсөн малчин эмэгтэйчүүдийн 70 хувь нь хүчирхийллийг “нөхөр/хамтран амьдрагч нь үйлдсэн” гэсэн бол 6.3 хувь нь “найз залуу”, 12 хувь нь “хамаатан садан”, 6.2 хувь нь “таньдаг хүн”, 5.5 хувь нь “ганихгүй хүн үйлдсэн” гэжээ. Хүчирхийлэл үйлдсэн шалтгаан, нөхцөлийг тодруулахад дараах хариултыг өгчээ.

Хүснэгт 1.15 Хүчирхийлэлд өртөж буй шалтгаан, нөхцөл

№	Хүчирхийлэл үйлдсэн шалтгаан, нөхцөл	Хариулт	Хувь
1	Архидан, согтуурсан үедээ	186	45.6
2	Хардалтын улмаас	73	18
3	Мөнгө, санхүүгийн гачигдлаас	44	10.8
4	Үгэнд орсонгүй, зөрлөө гэж	25	6.1
5	Боловсролгүйгээс	31	7.6
6	Өөрийн болон өргөмөл, дөгавар хүүхдийн асуудлаас	20	5
7	Дарамтлах, хүчирхийлэх нь байдаг л зүйл хэмээн хүлээн зөвшөөрсөн хандлага байдаг учраас	11	2.6
8	Мал аж ахуй, гэрийн ажлаа зэрэг амжуулсангүй гэж	10	2.4
9	Бэлгийн харилцаанд орохоос татгалзсанаас	5	1.2
10	Хадам, хамаатан садны хов живээс	2	0.5
11	Нөхөр/хамтран амьдрагч гэр бүлээс гадуур харилцаатай болсноос	1	0.2
Нийт		408	100

## Тохиолдол 1.22

*2009 оноос нөхөртэйгээ хамт амьдарч, 3 хүүхэдтэй болсон. Анх нэг гэрт орохдоо өөрийн өмчийн 20 бог малтай очиж байсан. Өнгөрсөн хугацаанд малын ашиг шимийг хүртэж санхүүгээ өөрөө захиран зарцуулах эрх мэдэлгүй амьдарч ирлээ. Тэр ч бүү хэл хүүхдийн мөнгө, амаржихын өмнөх болон дараа өгдөг мөнгө зэргийг зарцуулж үзээгүй. Хоол унд, угаалгын нунтаг, саван гэх мэт зүйлс дэлгүүрээс зээлээр авахаар бөөн хэрүүл маргаан болдог байв.*

*Хүүхдүүдээ ойрхон төрүүлсэн болохоор багийн эмч дээр очиж жирэмслэлтээс сэргийлэх хамгаалалт тавиулах гэтэл “Хадам ээж чинь битгий тавьж өгөөрэй гэсэн, хадам ээжид чинь загнуулна” гээд тавьж өгөөгүй. Хамтын амьдралын 8 жилийн хугацаанд би энэ айлд мал маллаж, өөрийн болон хадмынхаа гэр барааг нь янзалж тусалж ирсэн. Нөхөр намайг байнга хэл үгээр доромжилж хардаж сэрддэг. Ээж нь “Гар л битгий хүрээрэй. Хууль нь чанга юм билээ” гэдэг болохоор зоддоггүй, гэхдээ үг хэлээр доромжилж, сэтгэл санааны болон эдийн засгийн байнгын хараат байдалд байлгах төдийгүй гадагш хүнтэй харилцуулахгүй, өөрсдийнхөө эрхшээлд байлгаснаас энэ бүгдийг тэсэх аргагүй болсон. Бага хүүхдээ аваад замын унаанд дайгдаж, Улаанбаатар хотод ирсэн... Хүүхдүүдээ өөр дээрээ авч, гэр бүлээ цуцлуулмаар байна...*

(Баянхонгор аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

Хүчирхийлэлд өртсөн гэж хариулсан малчин эмэгтэйчүүдээс жилд дунджаар хэдэн удаа хүчирхийлэлд өртдөг талаар тодруулахад 25.4 хувь нь “1–2 удаа”, 27.1 хувь “3–5 удаа”, 33.9 хувь нь “байнга” гэж хариулжээ. Хүчирхийлэлд өртсөн малчин эмэгтэйчүүд дахин хүчирхийлэлд өртсөн тохиолдолд аль болох гэрээсээ



дайжин зугтахыг хичээдэг бөгөөд хэрвээ зугатсан бол хөдөө хээр хонох, эсхүл танил айлаар хоног төөрүүлдэг талаараа ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үед хэлж байв.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийлэлд өртсөн, эсхүл өртөж болзошгүй хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түр хамгаалан байрлуулах, эсхүл эмнэлгийн тусламж, сэтгэл зүй, нийгмийн халамж, хүүхэд хамгаалал, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээг нэг цэгээс үзүүлэхээр хуульчилжээ. 2019 оны байдлаар улсын хэмжээнд түр хамгаалах байр 14, нэг цэгийн үйлчилгээний төв 15 тус тус ажиллаж байна. Үүнээс төрийн харьяаны 13 түр хамгаалах байр, 14 нэг цэгийн үйлчилгээний төв, төрийн бус байгууллагын харьяаны түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв тус бүр 1 байна.<sup>21</sup> Улсын хэмжээнд 2018, 2019 онд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн иргэдийн статистик мэдээлэлтэй танилцахад дараах байдалтай байна.<sup>22</sup>

Хүснэгт 1.16 Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчдийн статистик мэдээлэл (2018, 2019 он)

№		Иргэн		Үүнээс малчин	
		2018	2019	2018	2019
1	Түр хамгаалах байр	529	596	23	45
2	Нэг цэгийн үйлчилгээний төв	1,210	1,821	6	6

Гэвч судалгаанд хамрагдсан 6 аймагт түр хамгаалах байр, Сүхбаатар аймагт нэг цэгийн үйлчилгээний төв алга байна.

<sup>21</sup> Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 9/5964 дүгээр албан бичиг болон Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээллээс, 2020 он

<sup>22</sup> Мөн тэнд

### Тохиолдол 1.23

*Нөхөртэйгөө амьдраад 27 жил болсон, хоёр хүүхэдтэй, гэрлэлтээ батлуулаагүй болохоор гэрлэлтийн гэрчилгээ байхгүй. Нөхөртөө олон удаа зодуулж, ах дүү нарт нь хэлэх хэлэхгүйгээр доромжлуулж, зодуулж, дарамтлуулж байна. Нөхөртөө зодуулаад харааны бэрхшээлтэй болсон. Хараа 70 хувийн алдагдалтай. Миний нүдийг униар хатгаж ийм болгосон. Тухайн үед айсандаа мориноос унаад нүдээ гэмтээчихлээ гэж эмчид худлаа хэлсэн. Энэ хүнийг хэрэг төвөгт оруулаад яахав гээд уучлаад өнгөрөөдөг байсан. Нөхөр бид хоёр хамт амьдарсан цагаасаа 1993–2012 он хүртэл ахынх нь малыг ямар ч хөлсгүй маллаж ирсэн. Ах нь хүртэл намайг зодож, үг хэлээр доромжилдог. Хадам ах нь бидний талаар ярих юм бол гишгэх газаргүй болгоно, чамайг нөхөртэй чинь 27 жил тэжээсэн, чамд юу ч өгөхгүй гэж дарамталж гэрээс минь хөөсөн. Үнэндээ хөлсөлж байгаа байрныхаа түрээсийг ч төлж чадахгүй тийм л нөхцөл байдалтай байна. Группын мөнгөөрөө зээл авчихсан. Надад ах, дүү хамаатан садан гэж байхгүй. Би аргаа бараад танай байгууллагад эрхээ хамгаалуулахаар хандаж байна...*

*Хүчирхийлэлд өртсөн малчин эмэгтэйд хамтарсан баг эрсдэлийн зэргийн үнэлгээ хийх явцад эмэгтэй дахин зодуулсан байна.*

*Сүхбаатар аймагт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байхгүй учраас дахин хүчирхийлэлд өртөх шалтгаан болсон...*

[Сүхбаатар аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйд  
Комиссоос өгсөн хууль зүйн зөвлөгөөний тэмдэглэлээс]

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар Баруун–Урт сумын Засаг даргын тамгын газартай хамтран түр хамгаалах байрын зураг төслийг хийж, Хууль зүй, дотоод хэргийн

яаманд хүргүүлсэн байна. Мөн 13 сумын цагдаагийн хэсэгт эрүүлжүүлэх, саатуулах байр байхгүйгээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн иргэдийг хохирогчоос тусгаарлах боломж хомс, тэднийг гол төлөв цагдаагийн кубаны байранд байлгадаг байна. Жишээлбэл, Сүхбаатар аймагт аймгийн төвөөс алслагдсан 200 гаруй километр зайтай Эрдэнэцагаан, Наран, Дарьганга сумдад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг аймгийн цагдаагийн газрын эрүүлжүүлэх байранд хүргэх машин, шатахууны зардал хүрэлцдэггүй зэрэг хүндрэл бэрхшээлтэй байна.<sup>23</sup>

#### Тохиолдол 1.24

*Миний бие хөдөө нөхөр, 4 хүүхдийн хамт мал маллаж амьдардаг. Богтлогдож айлын эхнэр болохоос өмнө нөхрөө нэг л удаа харсан. Тэр үед би дээд сургуулиа төгсөөд аймагтаа ирчихсэн, мэргэжлээрээ ажил олоогүй учраас хувийн компанид худалдагчаар ажиллаж байсан. Тэгээд орой ажлаа тараад явж байтал нэг машинтай хүн дэргэд ирж зогсоод хаана хүрэх вэ, гадаа хүйтэн байна, гэрт чинь дөхүүлээд өгье гэж хэлсэн. Би машинд суусан, хэсэг явж байтал ард нь сууж явсан залуу буюу манай нөхөр намайг хүчээр авч явсан.*

*Аймгийн төвөөс 190 гаруй км зайтай нэгэн сумын нутагт нөхрийн аав ээжийн гэрт хүчээр авчирч, аавынхаа болон өөрийнхөө гэрийн галд мөргүүлсэн. Яах ийхийн зуургүй шинэ дээл, хувцас өмсгөж, “Эмэгтэй хүн цагаан зээр хоёр нутаггүй байдаг юм, манай хүүтэй амьдралын замаа холбо, манай хүү муу хүн биш, бид маргааш танай аав ээжид хадаг сүү барьж очно” гэсэн. Хэдийгээр хүсээгүй ч, хэрэв татгалзсан тохиолдолд насаараа жаргал үзэхгүй, ганц бие явдаг гэж урьд нь сонсож байсан учраас уйлан байж эхнэр нь болсон. Шөнө нь манай нөхөр хүчээр бэлгийн харьцаанд орж, удалгүй*

<sup>23</sup> Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газрын 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 45/742 дугаар албан бичиг.

*жирэмсэн болсон. Нэгэнт хүний эхнэр болсон учраас янз бүрийн ааш зан гаргах бүрт тэвчээд амьдарч ирсэн. Гэтэл тэр цагаас хойш байнга зодож, дарамталдаг болсон.*

*Олон удаа цагдаад гомдол гаргаж, эрүүгийн болон зөрчлийн хэргээр арга хэмжээ авахуулж байсан. Нөхөр хоёр ч удаа намайг зодож, хүнд гэмтэл учруулсан учраас аймгийн Цагдаагийн газраас эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, прокуророос яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн ч, шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон. Тухайн үед гомдолгүй гэсэн бичиг хийж өгсөн маань буруу байжээ. Би нөхөртэйгээ байнга хэрүүлтэй байж ирсэн. Гэрлэлтээ цуцлуулж 4 хүүхдээ болон мал, гэр зэргээ өөртөө авмаар байна...*

[Увс аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйд  
Комиссоос өгсөн хууль зүйн зөвлөгөөний тэмдэглэлээс]

## Тохиолдол 1.25

*Өмнөх нөхрөөсөө хоёр хүүхэдтэй бэлэвсэн хоцорсон. Сүүлд суусан нөхрөөсөө гурван хүүхэдтэй, нийт таван хүүхэдтэй. 2009 оноос хойш нөхөртэйгээ хамт айлд туслах малчнаар ажиллаж байна. Суусан цагаас хойш нөхрийн ааш авир танигдаж эхэлсэн, эрүүлдээ ч элдэв янзын ааш гаргадаг ч хүүхдүүдээ бодоод тэвчдэг. Ямар ч шалтгаангүй уурладаг, уурлахаараа биед хүрнэ, хутга шөвөг барина, төмөр авч цохино. Нэг орой намайг буруу зөрүү ярьснаас болж уурлаж, орны төмөр авч чулуудсан, гэрээс гараад зугтсан чинь араас мотоцикльтой хөөсөн. Энэ талаар цагдаад хэлье гэхээр хүүхдүүдээ бодоод, нөхрөө өрөвдөөд чаддаггүй. Нэг шөнө ууртай залгахаар нь айсандаа хүүхдүүдээ аваад машиндаа хоносон, тэгтэл эргүүлийн цагдаатай таарч, бичиг баримт шалгатал, бичиг баримтаа яарсандаа авч гараагүй байсан. Цагдаа сэжиг аваад надаас учир байдлыг асууж, миний нөхцөл байдлыг мэдсэн. Ингэж арав гаруй жил цагдаад хэлэлгүй тэвчсэний дараа сая нэг цагдаад мэдүүлэг өгч, нөхрөө долоо хоног баривчилгаанд явуулсан. Өмнөх арав*

*гаруй жилийн хугацаанд гаргасан зан авир, үйлдлийн талаар хэлээгүй, зөвхөн тухайн үед болсон хэргээр л баривчлуулсан. Нөхрөөсөө байнга айдаг, зүрх өвддөг болсон...*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын  
малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлээд 3 жил өнгөрч байна. Тус хуулийн шинэчлэлд зарчмын томоохон өөрчлөлт оруулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах, үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж өгснөөрөө онцлог юм. Гэвч цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны болон бүх шатны Засаг дарга нарын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд бүтэц, тогтолцоо төсөв хөрөнгийн хувьд тулгамдсан, шийдвэрлэх шаардлагатай зарим асуудал байна.

Тухайлбал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж, уг нэгжийн ажилд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтныг оролцуулахаар заажээ.<sup>24</sup> Одоогоор Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бие даасан нэгжтэй болсон байна. Энэ нэгж нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс тус бүрд 1–2 алба хаагчийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг батлан, тэдэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Иймээс энэ бүтцийг нутаг

<sup>24</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3 дахь хэсгүүд.

дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 153 дугаар тогтоолоор “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, дэд бүтэц, зам харилцааны нөхцөл, бусад онцлогийг харгалзан баталсан ч өнөөгийн эдийн засгийн байдлаас шалтгаалан цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, ашиглаж буй тээврийн хэрэгслийн тоо энэхүү жишиг нормативт хүрдэггүй байна.

Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах тогтолцоонд голлох үүргийг хэрэгжүүлж, хэрэг, зөрчлийг шийдвэрлэгдэж дуусах хүртэлх бүх үе шатанд оролцож байна. Иймээс цагдаагийн алба хаагч үүргээ хэрэгжүүлэхэд дан ганц өөрөөс нь бус мэргэжил арга зүй, техникийн хангалт болон хамтран ажиллах бусад салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаанаас хамаарч байх тул цагдаагийн алба хаагчид ялангуяа хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчийг хамтарсан багийн гишүүнээр ажиллуулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтныг хамтран ажиллах тодорхой дэмжлэг, арга зүй, аргачлалаар хангах ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Хүчирхийлэл ихэнх тохиолдолд гэр бүлийн орчинд үйлдэгддэг, улмаар гэр бүлийн нэр төрөө бодож хэн нэгэнд мэдэгдэлгүй өнгөрдөг талаар хүчирхийлэлд өртсөн гэх малчин эмэгтэйчүүдийн олонх хариулжээ. Тэд хүчирхийлэгчийг засрал авна гэж найддаг, дахин зодуулахаас айдаг зэргээс шалтгаалан холбогдох газарт ханддаггүй байна. Хүчирхийлэлд өртсөн тухайгаа цагдаагийн

байгууллага гэхээс илүү эхлээд төрөл садан, найз нөхдөдөө хэлдэг байна.

### Тохиолдол 1.26

*Манай нутгийн бэр болж ирсэн 30 настай эмэгтэй нөхөр, гурван хүүхдийн хамт амьдардаг. Нөхөр нь архи ууж элдвээр харааж, доромжлон зоддог. Өмнө нь тэр бүсгүй нөхөртөө зодуулаад харанхуй шөнө хүүхдүүдээ дагуулаад гүйж ирэхэд нь орон гэртээ оруулж, хоол унд хийж өгч хонуулж байсан. Үүнээс хойш нөхөр нь намайг үзэхээ байсан. Тус эмэгтэйг нөхөр нь байнга зодож дарамталдаг болохоор сүүлдээ амиа хорлохыг завдаж, өөрийгөө хутгалж байсан. Энэ асуудлаар цагдаагийн байгууллагад хандаж байгаагүй. Учир нь хадмууд нь “Чи өөрийгөө хутгалсан, бүх зүйл чамаас болдог биз дээ” гэх мэтээр дарамталдаг болсон....*

[Хөвсгөл аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас]

Түүнчлэн малчин эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг тухайд авч чадахгүй байгаа нь хүчирхийлэлд өртөж, гэмтэж бэртсэнээ нуух, орон нутагт нарийн мэргэжлийн эмч байхгүй, бартаат зам ихтэй зэрэгтэй холбоотой байна.

Мөн зарим үед цагдаад дуудлага, мэдээллийг хожимдож өгөх, хүчирхийлэл ихэвчлэн шөнийн цаг, сумаас алс хол үйлдэгддэг, ахуйн хүрээний архидан согтуурах явдал түгээмэл, малчдын өөрийгөө хамгаалах болон хүчирхийллийн талаарх мэдлэг ойлголт, мэдээлэл дутмаг, гэр бүлийнхээ дарамт шахалтаас үүдэн цагдаад мэдэгдэхийг хүсдэггүй, эдийн засгийн боломж муутай зэрэг нь нөлөөлдөг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд Салбар зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах зэрэгт анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдах эрсдлийг буруулах, алслагдмал хөдөө, орон нутагт амьдарч байгаа болон мэдээлэл авах боломжгүй, бичиг, үсэг мэдэхгүй мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны тодорхой ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна.

Бүх шатны Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт цогцоор нь тусгуулах саналыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсэн этгээдийг баривчлахаас гадна албадан сургалтад хамруулахаар<sup>25</sup> заасан бол Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахгүйгээр, эсхүл ял дээр нэмж, зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээг шүүхээс оногдуулахаар<sup>26</sup> заажээ.

<sup>25</sup> Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйл.

<sup>26</sup> Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд<sup>27</sup> заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хорих ял шийтгүүлсэн этгээдэд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллага нь баривчлах, албадан сургалтад хамруулах, шийтгэл хүлээсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг тус тус зохион байгуулахаар байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/73 дугаар тушаалаар “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”-ыг баталснаар зан үйлд нөлөөлөх сургалтын загвар хөтөлбөр, сургалтын гарын авлагатай болж, багш нарыг бэлтгэж байгаа ч бодит байдалд багш нар болон сургалтын байр, танхим, хэрэглэгдэхүүний хүртээмж хангалтгүй байна.<sup>28</sup>

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, шүүхээс баривчлах шийтгэл хүлээсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд<sup>29</sup> хариуцан хэрэгжүүлэхэд багш, боловсон хүчин бэлтгээгүй, нөөц дутмаг, сургалт явуулах байр, танхим, гарын авлага сургалтын хэрэглэгдэхүүн, гэрээгээр ажиллах багш нарт олгох зардал шийдвэрлэгдээгүй байна.

Тухайлбал шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын хэмжээнд 27 сэтгэл зүйчтэй бөгөөд Хөвсгөл аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас бусад аймагт сэтгэл зүйчийн орон тоогүй байна. Зан үйлд нөлөөлөх албадан

<sup>27</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд 44.4 дэх хэсэг.

<sup>28</sup> “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт” мониторингийн тайлан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Швейцарын Хөгжлийн Агентлаг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, УБ, 2018 он.

<sup>29</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, аймаг, суманд цагдаагийн байгууллага гүйцэтгэх, баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүргийг дээрх хугацааны дотор үе шаттайгаар шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад цагдаагийн байгууллагаас шилжүүлэхээр заажээ.

сургалтыг хорих ангитай газруудад нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, харин хорих ангигүй газар, хэлтсүүдэд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч явуулдаг байна.<sup>30</sup>

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 хамтарсан тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг нормативыг тогтоох тухай журам”-д хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх 120 гүйцэтгэх баримт бичиг тутамд нэг шийдвэр гүйцэтгэгч ажиллах ёстой ажээ. Гэвч бодит байдалд тэд тогтоосон хэмжээнээс 2 дахин их ачаалалтай, 250–300 гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явуулж ажиллахын зэрэгцээ зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг давхар хариуцан зохион байгуулдаг байна.

Иймд цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулан ажиллахад мэргэжлийн боловсон хүчний орон тоог нэмэгдүүлэх, сургалт зохион явуулах байр, танхимаар хангах, сургагч багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр, гарын авлага зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэхэд шаардлагатай зардлыг төсөвт суулгах нь зүйтэй юм.

### 1.3 Малчин эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал

Хүний эрүүл мэндээ хамгаалуулах үндсэн эрхэд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал хамаардаг бөгөөд бусад эрхүүдтэй нягт уялддаг юм.<sup>31</sup> Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхэд хосууд болон хувь хүн

<sup>30</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээллээс, 2019 он.

<sup>31</sup> Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 2000 оны 14 дүгээр Ерөнхий зөвлөмж, Хүний эрхийн конвенцуудын хорооноос батлан гаргасан ерөнхий санал зөвлөмжүүдийн эмхэтгэл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, УБ, 2004 он.

гэр бүлээ чөлөөтэй, хариуцлагатайгаар төлөвлөх, энэ талаар мэдээлэлтэй байх, мэдээлэл олж авах аргыг эзэмших, мөн ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт, хүчирхийллээс ангид байж шийдвэр гаргах зэрэг өргөн хүрээний эрхүүд хамаарна.<sup>32</sup> Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд түлхүү хамааралтай учраас тэдэнд учирч болзошгүй эрүүл мэндийн эрсдэл тэр дундаа эх, хүүхдийн эндэгдлийг багасгах, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, тэдний бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг үгүйсгэдэг хортой ёс заншил, арга барил болон эрүүл мэндийн үйлчилгээнд саад учруулж буй бүх бэрхшээлийг арилгах нь чухал гэж үздэг.<sup>33</sup>

Тэгвэл хөгжиж буй орнуудын эмэгтэйчүүд бэлгийн болон нөхөн үржихүйн өвчин эмгэгээр өвчлөх, өсвөр насандаа хүүхэд төрүүлэх, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн золиос болох, дахин хүүхэд төрүүлэх боломжгүй болох, улмаар амь нас, эрүүл мэндээрээ хохирох эрсдэл өнөөг хүртэл оршсоор байна. Түүнчлэн олон улсын түвшинд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн асуудал дотоодын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтээс ихээхэн шалтгаалдаг гэж үздэг. Олон улсын хэм хэмжээнд алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэдэд зориулсан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх мэдээллийг тэдний хэрэгцээ, шаардлага, онцлогт нь тохируулан, хүртээмжтэй хүргэхэд онцгойлон анхаарахыг заажээ.<sup>34</sup>

<sup>32</sup> Хүн ам, Хөгжлийн Олон улсын Бага хурлын Үйл ажиллагааны Хөтөлбөр, 7.3 дугаар бүлэг.

<sup>33</sup> Хүний эрхийн конвенцуудын хорооноос батлан гаргасан ерөнхий санал зөвлөмжүүдийн эмхэтгэл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, УБ, 2004 он, 81 дэх тал.

<sup>34</sup> Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд "Хүн бүр төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг эрж хайх, хүлээн авах, түгээх эрхтэй", Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 10 дугаар зүйлийн (h) хэсэгт "Гэр бүлийн эрүүл мэнд, сайн сайхныг хангахад туслах тусгай боловсролын мэдээлэл, түүний дотор гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх" зэргээр баталгаажуулжээ.


Комиссын судалгаанд оролцогчдоос бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхтэй холбоотой мэдээллийг хаанаас авдаг талаар тодруулахад 32.2 хувь нь “мэргэшсэн эмчээс”, 32.8 хувь нь “телевиз, радиогоос”, 14.5 хувь нь “гэр бүл, найз нөхдөөсөө”, 7.8 хувь нь “сонин, цахим хуудаснаас авдаг” гэсэн бол 13.4 хувь нь “энэ төрлийн мэдээллийг огт авч чаддаггүй”, 34.6 хувь нь “маш бага хэмжээнд авдаг”, 40.8 хувь нь “боломжийн хэмжээнд авдаг”, 11.2 хувь нь “хангалттай мэдээлэл авдаг” гэжээ. Тэдний бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх мэдлэг, боловсролыг нь өөрсдөөр нь үнэлүүлэхэд 6.9 хувь нь “маш сайн”, 38.7 хувь нь “сайн”, 47.4 хувь нь “дунд”, 5.8 хувь нь “муу”, 1.2 хувь нь “маш муу” гэжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 78 дугаар тогтоолоор баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн үндэсний хөтөлбөр”-т “Нийт хүн амд эх, хүүхэд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, мэдлэг олгох ажлыг төрийн бус байгууллагатай хамтран олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх; зорилтот бүлэгт чиглэсэн гэр бүл төлөвлөлт, эсэн мэнд амаржихуй, эмийн зохистой хэрэглээ, хүүхдийн асаргаа сувилгаа, амны хөндийн эрүүл мэнд, хатгалгаа, суулгалт, үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдвар, осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх асуудлаар зан үйлийг өөрчлөх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах” талаар заасан байна.

Гэтэл Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнгээс үзэхэд эмэгтэйчүүдийн 3.7 хувь нь, хөдөөгийн охидын 6.1 хувь нь 18 наснаас өмнө хүүхэд төрүүлсэн байна. Харин тус судалгаанд охидын төрөлтийг 3 жилийн байдлаар хот, хөдөөгөөр харьцуулснаас үзэхэд хөдөө амьдарч буй өсвөр насны охидын төрөлт жилээс жилд өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь хөдөө дэх хүн ам, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, хандлага, дадалд дорвитой өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна.<sup>35</sup>

Бүдүүвч 1.13 Хот болон хөдөө амьдарч буй өсвөр насны охидын төрөлтийн түвшингийн харьцуулалт (2010, 2013, 2018 он, коэффициентээр)



Хөдөө орон нутагт бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, мэдээлэл, цугларалт зохион байгуулдаг боловч эдгээр үйл ажиллагаанд ихэвчлэн эрэгтэйчүүд хамрагддаг талаар ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үеэр хэлж байв.

## Тохиолдол 1.27

*Сумын иргэд гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар суманд зохион байгуулагдаж байгаа хурал, зөвлөгөөнөөс мэдээлэл авдаг. Гэхдээ хурал, зөвлөгөөнд ихэвчлэн нөхрүүд нь ирдэг, харин эхнэрүүд нь мэдээлэл тогтмол авч чадахгүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг нийгмийн ажилтан өгдөг ч айлд болж*

<sup>35</sup> "Монгол Улс–Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа–2018" нэгдсэн тайлан, Үндэсний статистикийн хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, УБ, 2019 он. (15–19 насны охидын төрөлтийн түвшин, судалгаанаас өмнөх 3 жилийн хугацаанд, хот, хөдөөгөөр).

*байгаа хүчирхийллийн талаар иргэд тэр бүр мэдээлдэггүй, хохирогч өөрөө л хэлэхгүй бол тэр бүр мэдэгддэггүй. Иймээс иргэдэд хүртээмжтэй мэдээлэл өгөх, мөн энэ талаар дуудлага мэдээлэл өгдөг, авдаг болгох зэргээр төрийн үйлчилгээг чанартай, шуурхай болгох шаардлагатай байна...*

*(Өмнөговь аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаас)*

Алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа тогтмол биш, санхүүжилт хангалтгүй, малчдад чиглэсэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт, мэдээлэл нь тэдний өдөр тутмын амьдралын хэв маягт нийцтэй биш, хүртээмжгүй байна. Энэ нь тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн боловсрол, мэдээлэл, түүн дотор гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээлэл, зөвлөгөө авах эрх зөрчигдөхөд хүргэж байна.

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хэдий хугацаанд хамрагддагийг тодруулахад 44.2 хувь нь “жилд 1 удаа” гэж хариулсан болно. Тэгвэл 16.6 хувь нь “жилд 2 удаа”, 11.5 хувь нь “2–3 жилд нэг удаа” гэх зэргээр хариулжээ. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой үзлэг оношилгоонд хаана хамрагдаж байгааг тодруулахад дараах хариулыг өгчээ.

Хүснэгт 1.17 Үзлэг, оношилгоонд хамрагдаж буй газар

№	Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдаж буй газар	Давхардсан тоогоор	Хувь
1	Сумын эрүүл мэндийн төв	375	58,5
2	Аймгийн нэгдсэн эмнэлэг	146	23
3	Хувийн эмнэлэг	64	10
4	Улаанбаатар хотын эмнэлэг	24	3,7
5	Өөр аймгийн эмнэлэг	22	3,4

6	Гэртээ	5	0.7
7	Тэр бүр хамрагдаж чаддаггүй, энэ тэндээс эмэгтэйчүүдийн эмч ирэх үед хамрагддаг	5	0.7
Нийт		641	100

Судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн 21.4 хувь нь “эмч, эмнэлгийн ажилтны зан харилцаа, хандлага муу, нууц хадгалж чаддаггүй”, 19.2 хувь нь “эмнэлгийн дараалал, ачаалал их байдаг”, 17.2 хувь нь “эмнэлгийн орчин нөхцөл хангалтгүй”, 15.2 хувь нь “мал хариулах хүн бүл цөөн тул эмнэлэг явах зав гардаггүй” зэрэг хүндрэл бэрхшээл бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээнд хамрагдахад тулгардаг гэжээ.

### Тохиолдол 1.28

*Би хүүхдүүдтэйгээ амьдардаг, хүү 16, охин 12 настай. Өөрийн хэдэн тооны хонь, ямаатай мөн хажуугаар нь айлын малыг хариулж, малладаг. Миний бие өвдөөд Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгт үзүүлэхээр сумаас яваад очиход эмнэлгийн цаг дууссан тул 20 хоногийн дараах цаг байна гэх шалтгаанаар эмчид үзүүлж чадаагүй. Би хэдэн хонь, ямаагаа хажуу айлдаа гуйж үлдээгээд эмнэлэгт үзүүлчихээд орой ирнэ гэж хэлээд орхиод ирсэн. Миний хувьд хүүхдүүдээ зуны амралтаар ирсэн үед зав зайтай болдог энэ үед үзүүлэх гээд очиход зарим эмч нар амралтаа авсан, эсвэл үзүүлэх цаг дууссан гэх шалтгаанаар эмчид үзүүлж чаддаггүй учраас хувийн эмнэлэгт үзүүлчихээд ирсэн. Угтаа би сайн дураараа нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал төлдөг хэдий ч улсын эмнэлэгт үзүүлж чаддаггүй...*

*(Дархан-Уул аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)*

Судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн 63 хувь нь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэгэн арга хэрэгсэл

хэрэглэдэг бол 32 хувь нь хэрэглэдэггүй, 5 хувь нь хэрэглэх шаардлагагүй гэж үзжээ. Тэдний 46.5 хувь нь дээрх арга хэрэгслийг хэрэглэх эсэхээ бие даан шийддэг бол 40.3 хувь нь нөхөр/хамтран амьдрагчтайгаа хамтран шийддэг байна. Мөн 3.9 хувь нь нөхөр/хамтран амьдрагчийн шаардсанаар, 2.4 хувь нь гэр бүлийн бусад гишүүдийн зөвлөснөөр, 6.4 хувь нь эрүүл мэндийн шалтгаан, эмчийн гаргасан шийдвэрээр хэрэглэдэг ажээ.

### Тохиолдол 1.29

*Би 34 настай. 5 сартайгаас 13 хүртэлх насны зургаан хүүхэдтэй. Нөхөртэйгөө суугаад анхны хүүхдээ 2007 онд, бага хүүхдээ 2018 онд төрүүлсэн. Жил өнжөөд хүүхэд гаргаад байхаар эмч нар, ар гэрийнхэн дургүйцдэг. Би эхний хоёр хүүхдээ гаргаад ерөндөг (спираль) тавиулсан ч надад таарахгүй, гуя дагаж өвдөөд сүүлдээ явж чадахгүй суумгай болсон. Дараа нь жирэмслэлтээс сэргийлэх тариа тариулсан боловч мөн л хөл рүү чинэрч өвдөөд, сав үрэвсээд идээ татаад бүтэн гурван сар эмнэлэгт хэвтэж маш их эмчилгээ хийлгэж эдгэсэн. Жирэмслэлтээс сэргийлэх эм ууж үзсэн ч нойр булчирхай өвдөөд бас л таарахгүй байсан. Хадмууд дарамталдаг. Сүүлийн гурван хүүхдээ гаргахаас айж, нууж байсан ч гэдэс томрохоор хүссэн хүсээгүй мэднэ. Жирэмсний хяналтад орохоор очиход эмч нар “Арчаагүйтэж яваад дахиад л хүүхэдтэй болчихоод ирсэн үү” гээд загнадаг. Би хүүхэд олчих вий, хүмүүс юу гэж бодох бол гэхээс, бэлгийн харьцаанд орохдоо хүртэл хүүхэдтэй болчих вий гэж үнэхээр их айдаг. Нөхөртөө бэлгэвч хэрэглэе гэхээр “Тэр заваан юмаар чинь яадаг юм” гээд уурладаг. Жирэмслэлтээс сэргийлэх хамгаалалт таарахгүй, хамгаалж чадахгүй байгаа болохоор харьцаанд орохыг хүсэхгүй, дургүйцэхэд нөхөр “Чи өөр хүнтэй болчихсон юм уу” гэдэг...*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын малчин эмэгтэйтэй хийсэн ярилцлагаас)



Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж буй байдлаар нь харьцуулан үзэхэд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд харьцангуй буурч байна. Тухайлбал 2010 болон 2013 онд тэдгээр эмэгтэйчүүдийн 55 хувь нь хэрэглэдэг байсан бол 2018 онд 48 хувь болж буурчээ.<sup>36</sup>

Бүдүүвч 1.14 Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээний харьцуулалт (2018 он)




Малчин эмэгтэйчүүдээс жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэхгүй байгаа шалтгааныг тодруулахад 34.3 хувь нь хүүхэдтэй болохыг хүсч байгаа учраас, 25.4 хувь нь эрүүл мэндийн шалтгаанаар, 20.4 хувь нь жирэмслэх боломжгүй, 11 хувь нь жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл авах боломжгүй, хэрэглэж хэвшээгүй гэсэн шалтгааныг дурдсан байна.

<sup>36</sup> “Монгол Улс–Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа–2018” нэгдсэн тайлан, Үндэсний статистикийн хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, УБ, 2019 он.

Тайлбар: Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл хэрэглэж байгаа (нөхөр, хамтран амьдрагч нь хэрэглэж болно) 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь, орчин үеийн болон уламжлалт арга, хэрэгслийн төрлөөр. Орчин үеийн арга гэдэгт умайн гуурсан хоолой боох, үрийн суваг боох, ерөндөг/спираль, тариа, суулгац, эм, эрэгтэй бэлгэвч, эмэгтэй бэлгэвч, диафрагм, лаа, царцмаг, хүүхэд хөхүүлэх орно. Уламжлалт арга гэдэгт хуанлийн дагуу түр тэвчих, гадуур тавих орно.

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд хамрагдсан 15–49 насны эмэгтэйчүүдийн жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээг авч үзвэл 51.9 хувь нь “ямар нэгэн арга хэрэгсэл хэрэглэдэггүй”, харин 26.6 хувь нь “ерөндөг (спираль) хэрэглэдэг”, 6.7 хувь нь “эм хэрэглэдэг”, 4.4 хувь нь “бэлгэвч хэрэглэдэг”, 2.8 хувь нь “умайн гуурсан хоолойгоо боолгосон”, 2.6 хувь нь “хуанли хөтөлдөг” гэжээ.<sup>37</sup>

Бүдүүвч 1.15 Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд хамрагдсан 15–49 насны эмэгтэйчүүдийн жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээ (2018 он)



Харин Комиссын судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүдээс жирэмслэлтээс сэргийлэх ямар төрлийн арга хэрэгсэл хэрэглэдгийг тодруулахад санал асуулгад оролцсон малчин эмэгтэйчүүдийн 38 хувь нь “эм тариа”, 28.7 хувь нь “ерөндөг (спираль)”, 12.8 хувь нь “бэлгэвч”,

<sup>37</sup> “Монгол Улс–Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа–2018” нэгдсэн тайлан, Үндэсний статистикийн хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, УБ, 2019 он. Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл хэрэглэж байгаа (нөхөр, хамтран амьдрагч нь хэрэглэж болно) (15–49 насны эмэгтэйчүүдийн хувь, арга, хэрэгслийн төрлөөр), 2018 он.

7 хувь нь “сарын тэмдгийн хуанли хөтөлдөг”, 6.2 хувь нь “суулгац хэрэглэдэг”, 3.3 хувь нь “умайн гуурсан хоолойгоо боолгосон”, 3.5 хувь нь “гадуур тавих арга хэрэглэдэг”, 0.2 хувь нь “наалт хэрэглэдэг” гэжээ. Мөн “жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэх заавар болон гаж нөлөөг эмч нар хангалттай тайлбарлаж өгдөггүй” гэж 30.9 хувь нь хариулсан байна. Энэ тохиолдолд эмчээс өөр хэнд ханддаг талаар асуухад 38.7 хувь нь “хэвлэл мэдээллийн болон сурталчилгааны мэдээлэлд”, 32.3 хувь нь “ээж, эгч дүү, найз нөхдөдөө”, 22.6 хувь нь “эмнэлгийн бусад ажилтанд ханддаг” гэж хариулжээ.

Мөн тэдний 43.4 хувь нь жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг үнэ төлбөргүй авдаг бөгөөд үүнд 35.7 хувь нь эм тариа, 17.6 хувь нь бэлгэвч, 17.3 хувь нь ерөндөг (спираль) зэргийг авдаг гэдгээ дурджээ.

Жирэмсний хяналтад тогтмол орж чаддаг эсэхийг тодруулахад малчин эмэгтэйчүүдийн 71.4 хувь нь хяналтдаа тогтмол ордог байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага жирэмсний хяналтын үзлэгт наад зах нь найман удаа хамрагдсан байхыг зөвлөхийн сацуу жирэмсний хяналтын үед цусны даралт хэмжих, шээсэнд бактери, уураг илрүүлэх шинжилгээ, тэмбүү болон хүнд хэлбэрийн цус багадалтыг илрүүлэх цусны шинжилгээ, жин/өндрийн хэмжилтийн тусгайлсан үйлчилгээ үзүүлэхийг удирдамж болгожээ.<sup>38</sup>

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 338 дугаар тушаалаар баталсан “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”-д заасны дагуу хэвийн явцтай жирэмсэн эмэгтэй

<sup>38</sup> Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. Жирэмсэн үеийн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн эрүүл мэндийн тусламжийн зөвлөмж. Женев хот: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Хэвлэл мэдээллийн агентлаг, 2016 он.  
<http://apps.who.int/iris/bitstream/handle/10665/250796/9789241549912-eng.pdf?sequence=1>.

6 удаа, өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг 8 удаа үзүүлэхийг зөвлөдөг бөгөөд эх жирэмсний эхний 12 долоо хоногт багтаж эхний үзлэгт хамрагдах ёстой юм. Тэгвэл судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүдээс сүүлийн жирэмслэлтийн үедээ хэдэн сартайдаа хяналтад орсныг тодруулахад 69.3 хувь нь “1–3 сартайдаа”, 26.9 хувь нь “4–6 сартайдаа”, 3.9 хувь “7–10 сартайдаа” гэсэн бол сүүлийн төрөлтдөө жирэмсний хяналтын үзлэг хийлгэсэн тооны хувьд 12.7 хувь нь “1–2 удаа”, 28.7 хувь нь “3–4 удаа”, 16 хувь нь “5–6 удаа”, 34.2 хувь “6–аас дээш удаа”, 8.4 хувь нь “эмч дуудсан тухай бүрт” гэж хариулжээ.

### Тохиолдол 1.30

*Малчин эмэгтэйчүүдийн жирэмсний хяналтын асуудал хэцүү. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 338 дугаар тушаалын дагуу жирэмсэн эмэгтэйчүүд эхний 3 сардаа хяналтад орох ёстой. Энэ нь ургийн гажгийг илрүүлэх зорилготой юм. Гэтэл малчин эмэгтэйчүүд ирж, хяналтад ордоггүй. Жирэмсний 5 сартайд мөн ургийн гажгийг илрүүлэх, ЭХО-д харуулах хяналт хийдэг. Үүнд бас ирдэггүй. Одоо цоо эрүүл жирэмсэн эмэгтэй гэж байхгүй болсон. Эрүүл мэндийн боловсрол дутмагаас үүдэн бөөр, үтрээний үрэвсэлтэй, даралт ихсэх эмгэгтэй малчин эмэгтэй их болжээ...*

[Сүхбаатар аймгийн нэгэн сумын  
эрүүл мэндийн төвийн эмчтэй хийсэн ярилцлагаас]

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмсний хяналтад хамрагдсан байдлыг харахад хөдөөгийн эмэгтэйчүүдийн хяналтад эрт орсон үзүүлэлт нь улсын дунджаас доогуур, мөн тэдний амаржилтын давтамж олон байна.<sup>39</sup>

<sup>39</sup> “Монгол Улс–Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа–2018” нэгдсэн тайлан, Үндэсний статистикийн хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, УБ, 2019 он.

Хүснэгт 1.18 Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд  
хамрагдсан эмэгтэйчүүдийн жирэмсний хяналтад хамрагдсан  
байдал (2010, 2013, 2018 он, хувиар)

Он	Жирэмсний хяналтад эрт үзүүлсэн (эхний 3 сард)			4 ба түүнээс олон удаа жирэмсний хяналтад үзүүлсэн		
	Улсын дүн	Хот	Хөдөө	Улсын дүн	Хот	Хөдөө
2010	77.2	80.1	72.7	81.2	82.4	80
2013	78.8	82.7	72.1	89.4	92	85.4
2018	83.8	85.1	80.8	88.5	89.7	85.9

Судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүдийн 17.4 хувь нь жирэмсний хяналтад ороход ямар нэгэн хүндрэл бэрхшээлтэй тулгардаг агаад эмч, эмнэлгийн ажилтны зан харилцаа, хандлага муу, нууц хадгалж чаддаггүй, мал маллах хүн бүл цөөн тул эмнэлэг явах зав гардаггүй, эмнэлгийн орчин нөхцөл, хүртээмж хангалтгүй гэх шалтгааныг дийлэнх нь дурдсан бөгөөд мөн жирэмсний хяналтад орох ёстойгоо мэдээгүй гэж хариулжээ.

### Тохиолдол 1.31

*Иргэн У нь Комисст хандаж “Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс иргэн И-гийн зураг болон эрүүл мэндийн талаарх мэдээллийг дур мэдэн байгууллагынхаа цахим хуудсанд байршуулсан талаар” гомдол ирүүлсэн байна.*

*Гомдлыг судлахад сумаас нүүж ирсэн түр оршин суугч И нь жирэмсний хяналтад ороогүй байсан тул түүнд хяналтын карт нээлгүүлж, ЭХО-д харуулж эмнэлэгт хэвтүүлэхээр болжээ. Хэвтүүлэхийн өмнө И-г тасаг дээрээ авчирч толгой, бүх биеийн угаалга хийж өгч, бүх хувцсыг нь сольж эмэгтэйчүүдийн тасагт хүлээлгэж өгсөн” гэх мэдээллийг байгууллагынхаа цахим хуудаст байршуулсан байна.*

*Энэ нь сувилагчдын баярыг тохиолдуулан сувилахуйн тусламж үйлчилгээний талаар хийсэн ажлуудаа цахим хуудсанд байршуулах ажлын хүрээнд тус мэдээлэлд өвчтөний нүүр царайг нуугаагүй, нэрийг нь бүтнээр нь оруулсан байжээ.*

*Үүнээс үзэхэд тус аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн нэр бүхий ажилтнууд нь иргэн И-гийн зураг болон эрүүл мэндийн талаарх мэдээллийг түүний зөвшөөрөлгүй олон нийтийн цахим хуудсанд байршуулж, нэр төр, алдар хүнд, хувь хүний нууцад халдаж, түүний олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан эрхийг зөрчсөн байна. Иймд иргэн И-гийн олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан нэр төр, алдар хүнд, хувийн болон эрүүл мэндийн нууцтай байх эрхийг зөрчсөн холбогдох ажилтнуудад хариуцлага тооцох, цаашид энэ төрлийн хүний эрхийн зөрчил гаргуулахгүй байхаар Комиссын гишүүний шаардлагыг хүргүүлэв...*

(Комиссын гишүүний 2019 оны 2/23 дугаар шаардлага)

### Тохиолдол 1.32

*Эрүүл амарждаг эмэгтэйчүүд гэж байхгүй. Дандаа л эрхтэн тогтолцооны эмгэгтэй. Тэгэхээр суманд хянаад төрүүлнэ гэдэг нь эрсдэл тохиолдох магадлалыг өндөрсгөдөг. Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан 8 удаагийн үзлэгт заавал үзүүлж баймаар байна. Жилд 80 эх амарждаг гэж тооцоход тэдний 15–20 хувь нь л эрүүл хүүхэд төрүүлж байна. Бусад нь бэлгийн замын, эсхүл эрхтэн тогтолцооны эмгэгтэй, эсхүл хүүхэд нь ямар нэгэн гажигтай төрөх магадлал өндөр байна.*

*36 долоо хоногтой жирэмсэн эхийг аймагт хүргэж өгөхөөр тушаалд заасан. Бид үнэндээ яг энэ хугацаанд нь хүргэж өгч чаддаггүй. 38 долоо хоногтойд нь эсхүл заримыг нь өвдөж эхлэнгүүт хүргэж өгдөг. Гол нь амрах байр хүрэлцэхгүй байна.*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын  
эрүүл мэндийн төвийн эмчтэй хийсэн ярилцлагаас)

### Тохиолдол 1.33

*Манай сумын эмнэлэг 15 ортой, хүүхдийн дөрөвхөн ортой, эмэгтэйчүүдийн нэг их эмч, хоёр бага эмч ажилладаг. Эм тариа хүрэлцдэггүй. 3,000 хүн амтай ч, 10,000 хүн амтай ч ялгаагүй эмнэлгийн ор, хангамж нь тооны хувьд адил учраас төрийн үйлчилгээ хүрч чадахгүй байна. Иймд сумын хүн амын тоонд харьцуулж аливаа төрийн үйлчилгээний хүртээмжийг (эмч, орны тоо гэх мэт) тооцож үзэх хэрэгтэй байна.*

*Бас нэг асуудал бол өмнө нь жирэмсэн эмэгтэйчүүдийг суманд төрүүлдэг байсан бол одоо заавал аймгийн нэгдсэн эмнэлэгт төрүүлдэг болсон. Сумаас аймагт очиж амаржих нь унаанаас авахуулаад хүндрэлтэй, мөн аймагт эхийн амрах байр олддоггүй, таван ортой нэг тасаг л ажилладаг. Дээр үед сумдад эхийн амрах байр буюу нэгдлийн амрах байр гэж байсан. Сумдаас аймагт очиж, төрж буй малчин эмэгтэйчүүд байрлах байргүй тул зарим нь төрмөгцөө замын унаанд сууж сум руугаа харьдаг, зарим нь айлд түр байрладаг ч удаан байж чадахгүй тул хэд хоноод сум руугаа буцдаг. Саяхан зэргэлдээ суманд дөнгөж амаржсан эмэгтэй нярай хүүхдээ тэврээд шуудангийн унаанд суугаад сум руу явж байгаад шуудангийн машинд чихцэлдээнтэй, агааргүй байснаас болоод нярай нь эндчихсэн. Иймд алслагдсан бүс, суманд амьдарч буй жирэмсэн эмэгтэйчүүд суманд нь амаржих, эхийн амрах байрыг нэмэгдүүлэх талаар төр арга хэмжээ авмаар байна...*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын  
төрийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас)

Судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдээс хүүхдээ хаана төрүүлж байсан талаар тодруулахад 49 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 39.8 хувь нь сумын эмнэлэгт, 3.8 хувь нь Улаанбаатар хотын эмнэлэгт, 3.1 хувь нь гэртээ, 2.8 хувь нь өөр аймгийн эмнэлэгт, 1.5 хувь нь хувийн

эмнэлэгт амаржсан гэж тус тус хариулсан нь Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дүнтэй адил байна.<sup>40</sup>

Хүснэгт 1.19 Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн амаржсан газар (2018 он)

Хүүхдээ төрүүлж буй газар		Улсын эмнэлэг	Хувийн эмнэлэг	Гэртээ	Бусад	Дун	Эмнэлэгт төрсөн	Судалгааны өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн тоо
Нийт		95.6	2.8	0.7	0.9	100	98.4	2,195
Байршил	Хот	96.2	2.2	0.3	1.3	100	98.4	1,515
	Нийслэл	96.4	2	0.2	1.5	100	98.4	1,091
	Аймгийн төв	95.6	2.7	0.8	0.8	100	98.4	424
	Хөдөө	94.3	4.1	1.4	0.1	100	98.4	681
	Сумын төв	95.8	3.9	0.3	0	100	99.7	269
	Хөдөөгийн баг	93.4	4.2	2.1	0.2	100	97.6	412

### Тохиолдол 1.34

*Манай аймагт гэртээ амаржсан 6 тохиолдол бүртгэгдсэн. Үүний 5 нь малчин эмэгтэй байсан. Орон нутгаас яаралтай тусламж хүрч очдоггүй, хүрэх гэсээр байтал төрчихсөн байдаг. Жирэмсэн малчин эмэгтэйчүүд, ялангуяа хилийн бүс нутагт амьдарч байгаа хүмүүсийн хувьд энэ нь тулгамдсан асуудал юм. Иймд хүүхдийн эмч, эх барих эмч нарыг алслагдсан бүс нутагт сургаж байршуулах ажил чухал байна. Манай аймаг*

<sup>40</sup> “Монгол Улс–Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа–2018” нэгдсэн тайлан, Үндэсний статистикийн хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, УБ, 2019 он. (2018 оноос өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн 15–49 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь, амаржсан газраар).



*23 сумтай, 6 сум эх барих эмчтэй. Одоо 3 суманд нэмж ажиллуулахаар төлөвлөж байна...*

(Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газрын удирдлагатай хийсэн ярилцлагаас)

Судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн 91 хувь нь амаржих үед ямар нэгэн хүндрэл бэрхшээл гараагүй гэж хариулсан ч үлдэж буй 9 хувь нь эх баригч эмч, эмнэлгийн ажилтны харилцаа, хандлага муу, нууц хадгалж чаддаггүй, эхийн амрах байрны хүрэлцээ хангалтгүй, эмнэлгийн тусламж авахад хугацаа алддаг гэх зэрэг шалтгааныг дурдсан байна. Түүнчлэн малчин эмэгтэйчүүдийн 53.6 хувь нь “эхийн амрах байраар үйлчлүүлж байгаагүй”, 9.6 хувь нь “тийм байр байдгийг мэддэггүй” гэсэн байна.

Эхийн эндэгдлийн дөрөвний гурав нь жирэмсний болон амаржих үеийн хүндрэлээс шалтгаалдаг тул эсэн мэнд амаржихад хамгийн чухал үүрэгтэй нөхцөл нь эх барихуйн ур чадвартай эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, яаралтай тусламж шаардлагатай үед зохих шатны эх барихуйн тусламж үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх явдал юм.<sup>41</sup>

### Тохиолдол 1.35

*Манайд 2018 онд 42 эхийг жирэмсний хяналтад авч 35 нь амаржсан. 3 сартайгаас эрүүл мэндийн төвд хяналтад аваад 8 сартайгаас нь бүсийн оношилгооны төвийн 2 дугаар шатлалын эмнэлэг руу шилжүүлдэг. Аймагт байх газаргүй эхчүүдийг бүсийн оношилгооны төвийн амрах байранд*

<sup>41</sup> Л.Сей, “Эхийн эндэгдлийн шалтгаалах хүчин зүйлс: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бүтцийн шинжилгээ” Лансет, Дэлхийн Эрүүл Мэнд 2 цуврал, 6 дахь дугаар, 2014 он: 332–333 дугаар хуудас. doi:10.1016/s2214-109x(14)70227-x.

*байрлуулдаг. Тэндээ байрлаж байгаад амаржаад ирдэг. 2019 он гарсаар солилцох хуудсаа өгөөд явуулсан боловч 2 эх буцаж ирээд энд амаржсан. Манай сум мэргэжлийн эх баригчтай учраас эх, хүүхдийн эндэгдэлгүй, хүүхэд эрүүл саруул төрж байгаа. Сүүлийн 2 жилд ургийн гажигтай хүүхэд төрөөгүй байна. Энэ нь жирэмсний хяналттай холбоотой. Хяналтад эрт авснаараа 5 сартайгаас нь эхлэн ургийн гажигтай эсэхийг эхийн хэвлийд байхаас нь тодорхойлох боломжтой болж байгаа...*

(Дорнод аймгийн нэгэн сумын  
эрүүл мэндийн төвийн эмчтэй хийсэн ярилцлагаас)

### Тохиолдол 1.36

*2012 онд манай суманд умайн гадуурх жирэмслэлттэй, 33 настай эмэгтэйд яаралтай түргэн тусламж шаардагдан нэгдсэн эмнэлэгт дуудлага өгснөөр алсын дуудлагын баг цаг алдалгүй гарсан. Харамсалтай нь дуудлага гарснаас хойш 16 цагийн дараа очиход 4 цагийн өмнө тэр эмэгтэй цус алдалтын шоконд орж нас барсан байсан. Эхийн эндэгдлийн дүгнэлт нь дэд бүтцийн хожимдол гэж гарсан...*

*Мөн 2017 онд ихэр урагтай, 29 настай эмэгтэйн ураг орчмын шингэн цагаасаа өмнө гарч, төрөлтийн 1 дүгээр үе эхэлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргэхэд зам харилцаа муу, хүндрэлтэй, цаг алдах байсан учир Оросын Холбооны Улсын Тункен аймгийн Нэгдсэн эмнэлэгт яаралтай хүргэж эх, нярайн амь насыг аварсан...*

*Манай сумаас аймгийн төв хүрэхэд 270 км зайтай бөгөөд дэд бүтэц муу, даваа бартаа ихтэй тул Оросын Холбооны Улстай хиллэдэг учраас эх, нярайн хүндрэл гарсан үед хөрш улсын Тункен аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргэж эх, нярайн амь насыг аврах шаардлага гардаг. Энэ нь цаг хугацаа алддаггүй, эрсдэлгүй, найдвартай арга боловч 2 улсын хоорондын гэрээ*

*хэлэлцээрээс шалтгаалан өртөг өндөр, эдийн засгийн хувьд  
ар гэр болон эрүүл мэндийн төвд маш их дарамт үүсгэдэг...*

[Хөвсгөл аймгийн нэгэн сумын  
малчин эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаас]

Судалгаанд оролцсон малчин эмэгтэйчүүдийн 67.7 хувь нь төрсний дараа үеийн 40 хоногийн тогтмол хяналтдаа орсон бол 32.3 хувь нь чадаагүй байна. Төрсний дараах үеийн хүндрэл бэрхшээлийн дийлэнхэд нярайн үзлэг, хяналтыг гэрээр хийдэггүйн улмаас аймаг, сумын эрүүл мэндийн төв рүү очих нь хүндрэлтэй байдаг, мал аж ахуйн ажлаас шалтгаалж нярай хүүхдээ асрахад хүнд байдаг гэх мэт шалтгааныг дурджээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Эсэн мэнд амаржихуй хөтөлбөр” нь нярай болон эхчүүдийг төрсний дараа 2 хоногт эрүүл мэндийн үзлэгт хамруулахыг зөвлөдөг.<sup>42</sup> Харин Монгол Улсын хувьд нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээг эмнэлэгт байх хугацаанд үзүүлэхээс гадна төрсний дараа эх, нярайг 3 удаа зайлшгүй үзнэ гэж заасан байдаг. Үүнд: 1) төрснөөс 24 цагийн дотор; 2) төрсний дараах 3 дахь хоногт; 3) төрсний дараах 7 дахь хоногт заавал үзнэ. Хэрэв шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй үзнэ гэжээ.<sup>43</sup> Монгол Улсын Засгийн газраас өнгөрсөн хугацаанд эх, хүүхдийн эрүүл мэнд, төрсний дараах хяналт үйлчилгээтэй холбоотой 10 гаруй бодлогын баримт бичгийг<sup>44</sup> хэрэгжүүлж байна. Нийгмийн

<sup>42</sup> Төрсний дараах 2 хоногт эх, нярайг эрүүл мэндийн үзлэг хийх нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж бөгөөд үүнийг “Эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн талаарх дэлхийн стратеги (2016–2030)”, “Нярай бүрт чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө” мөн Урьдчилан сэргийлэх боломжтой шалтгаанаар эхийн эндэгдэл гарах явдлыг зогсоох зэрэгт дэлхийн хэмжээний хяналтын гол шалгуур үзүүлэлт болгон тодорхойлжээ.

<sup>43</sup> Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 338 дугаар тушаалаар баталсан “Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”

<sup>44</sup> “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (1997–2016)-ийг дөрвөн

үзүүлэлтийн түүвэр судалгаанаас үзэхэд төрсний дараах хяналтын үзлэг улсын хэмжээнд 90-ээс дээш хувьтай байна.<sup>45</sup>

Бүдүүвч 1.16 Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд  
хамрагдсан эмэгтэйчүүдийн төрсний дараах хяналтын үзлэгт  
хамрагдсан байдал (2018 он, хувиар)



Комиссын судалгаанд оролцогчдын 21.2 хувь нь үр хөндүүлж байсан бөгөөд тэдгээрийн 69.7 хувь нь 1 удаа, 24.2 хувь нь 2 удаа, 6.1 хувь нь 3 ба түүнээс дээш удаа

удаа, "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн үндэсний хөтөлбөр" (2017–2021), "Эхийн эндэгдлийг бууруулах стратеги" (2001–2004, 2005–2010), "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж стратеги" (2009–2013), "Эх, нярайн эрүүл мэнд, стратеги" (2011–2015), "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх стратеги" (2014–2020), "Нярайн тандалт, шинжилгээний хөтөлбөр" (2014–2020).

<sup>45</sup> "Монгол Улс–Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа–2018" нэгдсэн тайлан, Үндэсний статистикийн хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, УБ, 2019 он. (Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, төрснөөс хойш 2 хоногт хүүхдийн болон эхийн эрүүл мэндийн байдлыг эмнэлэгт эсвэл гэрт нь үзсэн 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь 2018 он), (Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, төрснөөс хойш 2 хоногийн хугацаанд эмнэлгийн мэргэжилтэн хүүхдийн хүйг шалгасан, эхийн халууныг хэмжсэн, хүүхдийг жинлэсэн, эхийн сүүгээр хооллох талаар зөвлөгөө өгсөн, хүүхдээ хөхүүлж байгааг нь ажигласан, аюултай шинж тэмдэг илэрсэн үед эмнэлэгт хандах талаар мэдээлэл өгсөн 15–49 насны эмэгтэйчүүдийн хувь, 2018 он).

үр хөндүүлжээ. Тэдний 11.9 хувь нь сумын эмнэлэгт, 59.6 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 19.3 хувь нь хувийн эмнэлэгт, 2.8 хувь нь гэртээ, 5.5 хувь нь Улаанбаатар хотын аль нэг эмнэлэгт, 0.9 хувь нь бусад аймгийн эмнэлэгт үр хөндүүлсэн гэжээ.

Үр хөндөлтийг хуулиар хүлээн зөвшөөрдөггүй, энэ төрлийн үйлчилгээний хүртээмж муу, эсвэл үйлчилгээ нь чанаргүй улс оронд амьдарч буй эмэгтэйчүүд мэргэжлийн бус, чанарын шаардлага хангаагүй газарт хандах, эсвэл өөрсдөө үр хөндөлт хийх гэж оролддог бөгөөд энэ нь тухайн эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг ноцтой эрсдэлд оруулдаг билээ. Ихэнх эмэгтэйчүүд хүсээгүй жирэмслэлтээс болж үр хөндүүлдэг бөгөөд хөгжиж буй орнуудад үр хөндүүлж буй эмэгтэйчүүдийн 84 хувь нь орчин үеийн жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслээр хангагдаагүй, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг мэдээлэл дутмаг байна. Ялангуяа үр хөндөлтийн хувь хэмжээ нь гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрүүд хэр үр дүнтэй байгааг харуулах зүүллэлт болдог байна.<sup>46</sup>

Иймээс хүн амын дунд үр хөндөлтөөр төгссөн жирэмслэлтийн тоог эрчимтэй бууруулах, ингэхдээ хөдөөгийн болон алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэдэд чиглэсэн гэр бүл төлөвлөлтийн илүү боловсронгуй бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Монгол Улс 1989 онд үр хөндөлтийг хуулиар хүлээн зөвшөөрсөн билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 78 дугаар тогтоолоор баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2017–2021)-ийн хүрээнд 1,000 амьд төрөлт тутамд

<sup>46</sup> Гуттмахер Институт, Нэгдсэн дүгнэлт: Эх хүүхдийн эрүүл мэндийн төлөө Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл дэх хөрөнгө оруулалт, баримтын хуудас, Нью-Йорк хот: Гуттмахер институт, 2017 он.

үр хөндөлтийн түвшинг 224-өөс 200 хүртэл бууруулах зорилтыг дэвшүүлжээ. Улсын хэмжээнд үр хөндөлтийн тоо жилээс жилд буурсан (2016 онд 18,316, 2017 онд 17,530, 2018 онд 15,822) үзүүлэлттэй байгаа нь сайшаалтай юм.

Цаашид гэр бүл төлөвлөлтийн ач холбогдлыг олон нийтэд таниулж, жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийн талаарх өрөөсгөл ойлголтыг арилгах, үр хөндөлтийн дараах гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээгээр хангаж, үр зулбуулах эмийн хууль бус худалдааны хяналтыг чангаруулах шаардлагатай байна.

Комиссын судалгаанд оролцогчдын 12.9 хувь нь бэлгийн болон нөхөн үржихүйн өвчин эмгэгтэй холбоотой эмчилгээ, үйлчилгээг голдуу сумын эрүүл мэндийн төв болон аймгийн нэгдсэн эмнэлгээс авчээ.

Монгол Улсын хэмжээнд 2018 онд бэлгийн замаар дамжих халдварын 16,130 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 38.3 хувийг эзэлж байсан бол 2019 онд 17,865 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оноос 1,735 тохиолдлоор өссөн байна.<sup>47</sup> Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлын тоог байршлаар нь авч үзвэл Баянхонгор, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудад улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байна.

---

<sup>47</sup> Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэдээллээс, 2019 он.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:  
ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХ, БЭЛГИЙН БОЛОН  
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Хүснэгт 1.20 Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлын статистик мэдээллийн харьцуулалт (2018, 2019 он)

Байршил	Бэлгийн замаар дамжих халдвар 2018 он				Бэлгийн замаар дамжих халдвар 2019 он			
	Тэмбүү	Гонококкт халдвар	Трихомониаз	ХДВХ/ДОХ	Тэмбүү	Гонококкт халдвар	Трихомониаз	ХДВХ/ДОХ
Баянхонгор	256	328	466	0	227	399	675	0
Дорнод	230	1,058	414	0	204	724	385	0
Завхан	77	83	4	0	131	231	13	0
Өмнөговь	77	66	63	0	142	59	50	0
Сүхбаатар	196	106	59	0	213	99	71	0
Хөвсгөл	612	878	176	0	469	823	139	0
Бусад аймаг	1,913	992	1,159	0	2,064	1,248	1,365	0
Улаанбаатар	2,802	1,950	2,147	18	3,645	2,189	2,282	18
Улсын дүн	6,163	5,461	4,488	18	7,095	5,772	4,980	18

Комиссын судалгаанд хамрагдсан малчин эмэгтэйчүүд бэлгийн болон нөхөн үржихүйн өвчин эмгэгийн талаар зөвлөгөө, мэдээлэл авах, эмчилгээ хийлгэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 1.21 Эмчилгээ үйлчилгээ, зөвлөгөө, мэдээлэл авахад тулгарч буй хүндрэл бэрхшээл

№	Бэлгийн болон нөхөн үржихүйн өвчин эмгэгийн талаар зөвлөгөө, мэдээлэл авах, эмчилгээ хийлгэхэд гардаг хүндрэл бэрхшээл	Хариулт	Хувь
1	Мал аж ахуйн ажлаас шалтгаалан тэр бүр үзүүлэх зав гаргаж чаддаггүй	43	24
2	Эмч, эмнэлгийн ажилтан нууцыг хадгалж чаддаггүй	31	17.3
3	Заавал сумын эрүүл мэндийн төв эсхүл аймгийн эмнэлэгт очиж зөвлөгөө, мэдээлэл авах шаардлагатай байдаг нь хүндрэлтэй	29	16.2
4	Өвчний талаар хаана хандахаа мэдэхгүй учраас зөвлөгөө мэдээлэл тэр бүр авч чаддаггүй	48	26.7

5	Эмчилгээ үйлчилгээний хүртээмж хангалтгүй (эмч, ор, эм тариа хүрэлцдэггүй)	23	13
7	Ямар нэгэн хүндрэл бэрхшээл байхгүй	5	2.8
Нийт		179	100

Судалгаанд оролцогчдоос бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөр өвчилсөн бол эмчилгээ үйлчилгээ авахаар хаана ханддаг талаар тодруулахад 48 хувь нь сумын эрүүл мэндийн төв, 18 хувь аймгийн нэгдсэн эмнэлэг, 4 хувь нь хувийн эмнэлэг, 28 хувь нь эмийн сангаас зөвлөгөө авч гэрээр эмчилдэг, 2 хувь нь Улаанбаатар хотын эмнэлэгт хандсан гэжээ.

Малчдын дунд бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх, эмчилгээ үйлчилгээнд хамрагдах талаарх мэдлэг ойлголт хангалтгүй, мал аж ахуйгаас шалтгаалан сум, аймгийн төв орж эмчид үзүүлэх, оношлуулах, зөвлөгөө мэдээлэл авах боломж хомс байдаг нь хөдөө орон нутагт бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол нэмэгдэх хүчин зүйлс болж байна. Ялангуяа залуу малчдын дунд хүйсийн харьцаа зөрүү ихтэй байгаа нь малчдын дунд гэрлэлт оройтох, төрөлт буурах, бэлгийн замын халдварт өвчлөл болон шилжилт хөдөлгөөн ихсэх зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Нөгөө талаас малчид шинжилгээ, оношилгоонд хамрагдах хүсэлгүй байна.

### Тохиолдол 1.37

*Манай суманд гэр бүл салалт их байна. Бэлгийн замын халдварт өвчлөл ч түүнийгээ дагаад их. Саяхан бид өөрсдөө мөнгөө гаргаад явуулын амбулатори ажиллуулсан. 3,800 хүн цусны шинжилгээнд хамрагдахаас 2,171-ийг нь хамруулсан. Энэ дунд шинээр 51 хүн бэлгийн замын халдварт өвчтэй болох нь илэрсэн. Хуучин 87 хүн байсан бол одоо 100*



*гарчихлаа. Тэмбүү тээгч 116 хүн байна. Цаана нь 2,000 орчим хүн шинжилгээнд хамрагдаагүй байна. Ер нь бол тэмбүү хяналтаас гарсан гэдэг үнэн. Бид эдгээр хүмүүсийг нэлээд ажил болж байж хамруулсан юм. “Цусаар яах гэж байгаа юм” гээд цусаа өгөхгүй байна. “Байн байн цус гэх юм, худалдах гээд байгаа юм уу” гээд хардана...*

(Сүхбаатар аймгийн нэгэн сумын төрийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас)

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хүн бүр ялгаварлалгүйгээр тэгш эдлэх ёстой ч малчин охид, эмэгтэйчүүдийн амьдралын хэв шинж, газар зүйн байршил, эдийн засгийн нөхцөл зэрэг нь энэхүү эрхээ бүрэн эдлэхэд нь саад учруулж байна. Мөн тэдний нийгмийн болон эрүүл мэндийн боловсрол, мэдээ, мэдээлэл, үйлчилгээний хоцрогдол ч нэрмээс болж байна. Иймд малчин охид, эмэгтэйчүүдийг мэдлэгжүүлэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдэнд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол, мэдээллийн үйлчилгээг хүртээмжтэй, үр нөлөөтэй болгоход бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Түүнчлэн сум, багт жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийн хэрэглээ, жирэмсний эрт үеийн хяналтыг нэмэгдүүлэх, өсвөр насны охидын төрөлт, эхийн эндэгдлийг бууруулахад анхаарал хандуулж, эрүүл мэндийн байгууллагын хүний болон санхүүгийн нөөцийг хуваарилахдаа мэргэшсэн эх баригч, эмэгтэйчүүдийн эмч, багийн эмчийн орон тоог зохистой нэмэгдүүлэх, сумын эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээг сум, багийн эмэгтэйчүүдэд хүргэх шинэлэг санаачилгыг нэвтрүүлэх шаардлагатай байна.



# II

БҮЛЭГ

## ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

*“Энэхүү пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг,  
нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эдлэх  
нөхцөлийг хангах”*

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай  
олон улсын пактын 3 дугаар зүйл)

*“Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдэл, үйл  
ажиллагаанаас татгалзах, төрийн байгууллага,  
алба энэхүү үүргийн дагуу ажиллахыг хангах”*

(Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах  
тухай конвенцын 2 дугаар зүйлийн (d) хэсэг)

*“Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн  
харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй”*

(Монгол Улсын Үндсэн хуулийн  
Арван зургадугаар зүйлийн 16.11 дэх заалт)

БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн 11 дүгээр зүйлд “Тус улсын харьяат ард түмэнд үндэс угсаа, шашин эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино” хэмээн анх тунхаглаж байжээ. Үүний дараа 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй.” хэмээн нийгмийн бүхий л салбарт жендэрийн эрх тэгш байдлыг баталгаажуулсан байна. Энэ хугацаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орны хувьд тэгш байдлын талаарх олон гэрээнд нэгдэн орж төрийн бодлого үйл ажиллагаа, хуульдаа жендэрийн тэгш байдлыг тусгаж иржээ.

Монгол Улс 1999 онд Хөдөлмөрийн тухай хууль, 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг тус тус баталж, хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон эрх зүйн зохицуулалтыг бий болгосон юм. “Тогтвортой хөгжил–2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Бразилийн Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилж, 2015 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс албан ёсоор дэлхий нийтэд хэрэгжиж эхэлсэн билээ. Уг хөтөлбөрийн 5 дугаар зорилгод “жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх”-ээр тусгасан байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын

Их Хурлаас 2015 онд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг, мөн 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрийг тус тус баталжээ.

Дээрх тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Ийнхүү нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн тэгш оролцоог хангах замаар нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх үндэс суурийг тавьжээ.

Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах талаар бодлого, хууль эрх зүйн таатай орчин бүрдсэн хэдий ч хэрэгжилт нь хангалтгүй байна. Энэ нь хэрэгжүүлж буй аливаа бодлого, хөтөлбөр жендэрийн мэдрэмжтэй эсэх нь тодорхойгүй, засаглалын чадавх сул, хүйсээр ангилсан мэдээлэл дутмаг, мэдээллийг ашиглаж хэвшээгүй, бодлого төлөвлөлт, төсвийн хуваарилалтын жендэрийн мэдрэмж сул байгаа зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна.<sup>48</sup>

Комисс Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13,<sup>49</sup> 16,<sup>50</sup> 18<sup>51</sup> дахь илтгэлдээ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаар тусгаж, шийдвэр

<sup>48</sup> Монгол Улсын Засгийн газраас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн зөвлөлд хүргүүлсэн Үндэсний сайн дурын илтгэл. (Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт) 2019 оны 6 дугаар сар.

<sup>49</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. Дөрөвдүгээр бүлэг.

<sup>50</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. Тавдугаар бүлэг.

<sup>51</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл. Зургадугаар бүлэг.

гаргуулахаар тодорхой зөвлөмжүүдийг хүргүүлсэн билээ. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 9 жил, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал батлагдсанаас хойш 4 жил тус тус өнгөрч байгаа боловч Монгол Улсын Засгийн газар, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагуудын жендэрийн талаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд Комиссоос хийсэн хяналт шалгалт, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийхэд тухайн хуулийн хэрэгжилт тун хангалтгүй байна.

Канадын Засгийн газрын санхүүжилтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс 2018–2022 онд хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд Комиссоос Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Завхан, Архангай, Төв, Хөвсгөл, Булган зэрэг нийт 16 аймгийн Засаг даргын тамгын газар, тухайн аймгуудын Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв зэрэг нийт 160 байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн юм.

Комиссоос хийсэн дээрх хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, хяналт шалгалтын хүрээнд 1,681 төрийн албан хаагчаас авсан судалгааны санал асуулгын нэгтгэсэн дүн, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага болон холбогдох байгууллагаас ирүүлсэн судалгаа, баримт, мэдээлэлд тулгуурлан энэхүү бүлгийг боловсруулав.

## 2.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн хэрэгжилт

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар “тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах, тухайн салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх, зөвлөх чиг үүрэг бүхий жендэрийн салбар зөвлөл, хороо байгуулж, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах, жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах” зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт “жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим, хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох”, 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх хэсэгт “тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах” гэж тус тус заасны дагуу 2018 онд Сүхбаатар, Орхон, Өвөрхангай, Дундговь, Хөвсгөл, Архангай, Хэнтий аймгууд орон нутагт хэрэгжүүлэх



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулж, батлуулаагүй талаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлд<sup>52</sup> дурджээ.

Комиссоос зохион байгуулсан хяналт шалгалтын үед дээрх аймгуудаас Өвөрхангай, Хөвсгөл аймаг дэд хөтөлбөрөө баталсан байх бөгөөд Архангай,<sup>53</sup> Дундговь,<sup>54</sup> Орхон,<sup>55</sup> Сүхбаатар,<sup>56</sup> Хэнтий<sup>57</sup> зэрэг аймгуудын Засаг дарга нарт орон нутагтаа хэрэгжүүлэх Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулж, батлуулах талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн юм.

Тус шаардлага, зөвлөмжийн үр дүнд Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 63 дугаар тогтоолоор,<sup>58</sup> Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 2 дугаар тогтоолоор,<sup>59</sup> Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 62 дугаар тогтоолоор,<sup>60</sup> Хэнтий

<sup>52</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл. Зургадугаар бүлэг, 223 дахь тал.

<sup>53</sup> Комиссын гишүүний 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 3/39 дугаар шаардлага.

<sup>54</sup> Комиссын гишүүний 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 3/38 дугаар зөвлөмж.

<sup>55</sup> Комиссын гишүүний 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 3/32 дугаар зөвлөмж.

<sup>56</sup> Комиссын гишүүний 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 3/34 дугаар шаардлага.

<sup>57</sup> Комиссын гишүүний 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 3/32 дугаар шаардлага.

<sup>58</sup> Дундговь аймгийн Засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 1/1158 дугаар албан бичиг.

<sup>59</sup> Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 03/2327 дугаар албан бичиг.

<sup>60</sup> Сүхбаатар аймгийн Засаг даргын орлогчийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 2/1351 дугаар албан бичиг.

аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 15 дугаар тогтоолоор тус тус тухайн орон нутагтаа хэрэгжүүлэх Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг баталж, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Харин 2020 оны эхний улирлын байдлаар Архангай аймаг нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг батлаагүй байна.<sup>61</sup> Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь хэсэгт “төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх” талаар заасан байна. Жендэрийн үндэсний хорооны 2019 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл аймгууд орон нутгийн Жендэрийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр түншлэгч байгууллагуудтай гэрээлж, дэд хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэж ажиллажээ.

Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх Засаг даргын тайланг хурлаараа хэлэлцэж, дүнг нийтэд мэдээлэх” үүрэгтэй талаар заасан байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх Засаг даргын тайланг Дундговь, Төв аймгаас бусад нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа хэлэлцүүлээгүй, дээрх хуулийн заалтыг огт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<sup>61</sup> Жендэрийн үндэсний хорооны үйл ажиллагааны тайлан, 2019 он.

Баянхонгор, Булган, Дархан–Уул, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Хөвсгөл аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2019 онд орон нутгийн төсөвт 1–387 сая төгрөгийг төсөвлөж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь хэсэгт “Харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллажээ.

Харин Архангай, Говь–Алтай, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий аймгууд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг тусгайлан төсөвлөөгүй хэдий ч тухайн жилдээ 24–64.8 сая төгрөгийг орон нутагт төсөвлөгдсөн бусад эх үүсвэрээс буюу Засаг даргын нөөц сан, орон нутгийг хөгжүүлэх сан, төсөл, хөтөлбөрөөс санхүүжүүлж, жендэртэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулжээ.<sup>62</sup>

Иймээс орон нутагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж хуулийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Ингэснээр орон нутагт тухайн хууль тогтоомж үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэх юм. Орон нутагт аймгийн Засаг даргын тамгын газруудын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, эрүүл мэнд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын асуудал хариуцсан гэх зэрэг мэргэжилтнүүд үндсэн ажлаас гадна албан тушаалын тодорхойлолтод

<sup>62</sup> Жендэрийн үндэсний хорооны үйл ажиллагааны тайлан, 2019 он.

тусгагдсаны дагуу жендэрийн асуудлыг хавсран хариуцаж байна.

Дорноговь, Өвөрхангай, Говьсүмбэр, Архангай, Орхон, Хөвсгөл, Өмнөговь, Баян-Өлгий, Баянхонгор аймгуудаас бусад нь жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг сар бүр үндсэн цалингийн 10–30 хувиар тооцон олгож байна.

## Тохиолдол 2.1

*...Би аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн асуудал хариуцсан ажилтнаар ажилладаг бөгөөд аймгийн хэмжээнд жендэрийн асуудлыг хавсран ажилладаг юм. Миний үндсэн ажлын ачаалал маш их байдаг болохоор жендэрийн ажил руугаа бүрэн гүйцэд орж ажиллаж чаддаггүй. Удирдлагын зүгээс албан тушаалын тодорхойлолтод жендэрийн асуудлыг хавсран ажиллахаар заасан гэх шалтгаанаар надад ажил хавсран ажилласны нэмэгдэл хөлсийг олгодоггүй...*

[Комиссоос 2019 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын үеэр аймгийн жендэр хариуцсан ажилтантай хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс]

Түүнчлэн орон нутгийн удирдлагууд жендэрийн талаарх мэдлэг, ойлголт, хандлага дутмагаас жендэр хариуцсан ажилтнуудын үйл ажиллагааг дэмждэггүй, аливаа бодлого, шийдвэрийг гаргахдаа жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг орхигдуулдаг нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж орон нутагт бүрэн хэрэгжихгүй байх нэг гол шалтгаан болж байна.

Иймд төрийн захиргааны байгууллагыг жендэрийн асуудал хариуцсан орон тооны ажилтантай болгох,<sup>63</sup> цалинг төсөвт суулгах шаардлагатай байна. Түүнчлэн Дархан-Уул, Дундговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудын засаг захиргааны анхан шатны нэгж болох 82 суманд жендэрийн салбар хороо байгуулагдсан<sup>64</sup> хэдий ч мөн орон тооны ажилтан байхгүйгээс үүдэн үйл ажиллагаа нь тогтворжоогүй, албан тушаалын хавсарга байдлаар ор нэр төдий ажиллаж байгаагаас жендэрийн талаар баримталж буй бодлого, шийдвэр үр дүнд хүрэхгүй байгааг анхаарах нь зүйтэй юм.

## 2.2 Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг хангаж буй байдал

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь хэсэгт “төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байна” гэж заасан байна.

Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ” гэж заажээ.

<sup>63</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар өгсөн санал 6.23, 288 дахь тал.

<sup>64</sup> Жендэрийн үндэсний хорооны үйл ажиллагааны тайлан, 2019 он.

Хэдийгээр эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд оролцох оролцоо сайжирсан боловч удирдах албан тушаалтнуудын 37 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ байдал сүүлийн арван жил үргэлжилж байгаа бөгөөд 25-аас дээш насны эмэгтэйчүүдийн 91.2 хувь нь, эрэгтэйчүүдийн 86.3 хувь нь дундаас дээш боловсролтой байна. Үүнээс үзэхэд эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа хэдий ч тэдний ажиллах хүчний оролцоо 55.2 хувь байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 67.5 хувиар бага байна.<sup>65</sup>

Монгол Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар удирдах албан тушаалд ажиллаж буй нийт эмэгтэйчүүдийн эзлэх хувь 35.9 хувь байна.<sup>66</sup> Төрийн албаны зөвлөл нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 21.1.1 дэх хэсэгт зааснаар төрийн албаны хүйсээр ангилсан статистик мэдээ, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, уг мэдээллээр Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар бусад сонирхогч этгээдийг хангах чиг үүрэгтэй байна.

Төрийн албан хаагч 2019 оны 1 дүгээр сарын байдлаар 193,557 байгаагаас 76,564 албан хаагч буюу 39.6 хувь нь эрэгтэй, 116,993 албан хаагч буюу 60.4 хувь нь эмэгтэй,<sup>67</sup> 2020 оны 1 дүгээр сарын байдлаар 198,463 байгаагаас 77,716 албан хаагч буюу 39.16 хувь нь эрэгтэй, 120,747 буюу 60.84 хувь нь эмэгтэй<sup>68</sup> байна.


<sup>65</sup> Монгол Улсын Засгийн газраас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн газарт хүргүүлсэн Үндэстний сайн дурын илтгэл. (Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт) 2019 оны 6 дугаар сар.

<sup>66</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. [http://1212.mn/stat.aspx?LIST\\_ID=976\\_L03\\_976\\_L33](http://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L03_976_L33)

<sup>67</sup> Монгол Улсын төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, 2018 он.

<sup>68</sup> Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 05/520 дугаар албан бичиг.

Бүдүүвч 2.1 Төрийн албан хаагчдын тоо (2019–2020 он)




Хүснэгт 2.1 Төрийн захиргааны албан хаагчийн тоо,  
албан тушаалын ангилал (2019 он, хувиар)

№	Зэрэг дэв	Тоо	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
1	Тэргүүн түшмэл	102	28	74	27.4
2	Эрхэлсэн түшмэл	516	207	309	40.1
3	Ахлах Түшмэл	1,705	858	847	50.3
4	Дэс түшмэл	13,830	8,772	5,058	63.4
5	Туслах түшмэл	2,927	1,564	1,363	53.4
	Нийт	19,080	11,429	7,651	59.9

Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийг хүйсээр ангилбал тэргүүн түшмэлийн 27.4 хувь, эрхэлсэн түшмэлийн 40.1 хувь, ахлах түшмэлийн 50.3 хувь, дэс түшмэлийн 63.4 хувь, туслах түшмэлийн 53.4 хувь нь эмэгтэй байгаа<sup>69</sup> нь төрийн захиргааны албан хаагчийн хүйсийн тэнцвэрт байдал алдагдсаныг харуулж байна.

<sup>69</sup> Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 05/520 дугаар албан бичиг.

**Бүдүүвч 2.2 Төрийн захиргааны эмэгтэй албан хаагчдын эзлэх хувь, албан тушаалын ангилал (2019 он)**



Аймгуудын Засаг даргын тамгын газрын төрийн албан хаагчдын хувьд хуульд заасан 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдал алдагдсан, аль нэг хүйсийн төлөөлөл 60 хувиас дээш үзүүлэлттэй аймаг байхгүй байна.<sup>70</sup>

**Хүснэгт 2.2 Хяналт шалгалтад хамрагдсан аймгуудын Засаг даргын тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдал. (2019 он, тоогоор)**

№	Аймгуудын Засаг даргын тамгын газар	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
1	Архангай аймаг	Мэдээлэл ирүүлээгүй		
2	Баянхонгор аймаг	97	51	46
3	Булган аймаг	68	34	34
4	Говь-Алтай аймаг	53	23	30
5	Дархан-Уул аймаг	39	17	22
6	Дорнод аймаг	78	39	39
7	Дундговь аймаг	58	26	32
8	Завхан аймаг	58	26	32
9	Орхон аймаг	69	32	37
10	Өвөрхангай аймаг	73	29	44
11	Өмнөговь аймаг	39	17	22
12	Сүхбаатар аймаг	56	24	32
13	Сэлэнгэ аймаг	65	29	36

<sup>70</sup> Комиссоос 16 аймагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын илтгэх хуудас, 2019 он.



14	Төв аймаг	95	45	50
15	Хөвсгөл аймаг	79	38	41
16	Хэнтий аймаг	39	18	21
Нийт		966	448	518

Мөн хяналт шалгалтад хамрагдсан 16 аймгийн 160 төрийн байгууллагаас Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт эмэгтэй албан хаагчид, харин Байгаль орчин, аялал жуулчлалын газарт эрэгтэй албан хаагч илүү тоогоор ажиллаж байна. Аймгуудын Засаг даргын тамгын газрын төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын хүйсийн тэнцвэрт байдлын хувьд Булган, Дорнод, Орхон, Хэнтий аймгууд дээрх хуулийн шаардлагыг хангаагүй байна.<sup>71</sup> Тухайлбал Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргааны удирдах долоон албан тушаалтан нь бүгд нэг хүйсийн төлөөлөл буюу эрэгтэйчүүд байна.

**Хүснэгт 2.3 Хяналт шалгалтад хамрагдсан аймгуудын Засаг даргын тамгын газрын төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын хүйсийн тэнцвэрт байдал (2019 он, тоогоор)**

№	Аймгуудын Засаг даргын тамгын газар	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
1	Архангай аймаг	Мэдээлэл ирүүлээгүй		
2	Баянхонгор аймаг	7	3	4
3	Булган аймаг	7	6	1
4	Говь-Алтай аймаг	6	4	2
5	Дархан-Уул аймаг	1	1	0
6	Дорнод аймаг	11	9	2
7	Дундговь аймаг	7	4	3
8	Завхан аймаг	7	4	3
9	Орхон аймаг	8	6	2
10	Өвөрхангай аймаг	8	4	4
11	Өмнөговь аймаг	8	3	5
12	Сүхбаатар аймаг	7	4	3
13	Сэлэнгэ аймаг	7	4	3

<sup>71</sup> Жендэрийн үндэсний хорооны үйл ажиллагааны тайлан, 2019 он.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,  
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19 ДЭХ ИЛТГЭЛ

14	Төв аймаг	7	3	4
15	Хөвсгөл аймаг	7	4	3
16	Хэнтий аймаг	7	7	0
Нийт		105	66	39

Дээрхээс үзэхэд аймгуудын Засаг даргын тамгын газрын төрийн албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдал нь хуульд заасан шаардлагыг хангаж байх боловч удирдах албан тушаалтнуудын хувьд хангахгүй байна. Жендэрийн эрх тэгш байдал нь аль нэг хүйсийн төлөөлөлд давуу байдал олгодоггүй бөгөөд төрийн захиргааны удирдах албан тушаалтныг томилох, сонгон шалгаруулалтыг зарлахдаа хэдийгээр хүйс заадаггүй боловч олон улсын гэрээ конвенц, дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүйгээс аль нэг хүйсийн төлөөлөлд давуу байдал олгодог, эмэгтэйчүүдийг удирдах албан тушаалд ажиллах боломж нөхцөлөөр хангахгүй байгаа нь тэдгээрийг томилдог албан тушаалтны жендэрийн мэдрэмжгүй үйл ажиллагаатай шууд холбоотой юм.

Хүснэгт 2.4 Төрийн захиргааны удирдах албан тушаалд  
эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2018, 2019 он)


Албан тушаал	Нийт	2018 он		Нийт	2019 он	
		тоо	хувь		тоо	хувь
Яамдын Төрийн нарийн бичгийн дарга	13	1	7.7	13	1	7.7
Агентлагийн дарга	30	1	3.3	30	1	3.3
Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга	22	4	18.2	22	4	18.2
Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга	22	4	18.2	22	5	22.7

Үүнээс гадна дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нарын 44.4 хувь, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нарын 58.8

хувь, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга нарын 11.1 хувь, сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарын 57.3 хувь нь тус тус эмэгтэй байна.<sup>72</sup> Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь хэсэгт “зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх”-аар заажээ. Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор Төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоон мэдээллийг “Маш нууц”-ын зэрэглэлд хамааруулсан байдаг тул нарийвчлан гаргах боломжгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штабын алба хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлыг хувиар үзүүлэв.

### Бүдүүвч 2.3 Төрийн тусгай алба хаагчдын хүйсийн тэнцвэрт байдал (2019 он)



<sup>72</sup> Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 05/520 дугаар албан бичиг.

2019 оны байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын алба хаагчдын 65.3 хувь нь эрэгтэй, 34.7 хувь нь эмэгтэй,<sup>73</sup> Хил хамгаалах ерөнхий газрын алба хаагчдын 77.3 хувь нь эрэгтэй,<sup>74</sup> 22.7 хувь нь эмэгтэй, Онцгой байдлын ерөнхий газрын алба хаагчдын 81.6 хувь нь эрэгтэй, 18.4 хувь нь эмэгтэй,<sup>75</sup> Цагдаагийн ерөнхий газрын алба хаагчдын 85.1 хувь нь эрэгтэй, 14.9 хувь нь эмэгтэй,<sup>76</sup> Зэвсэгт хүчний жанжин штабын алба хаагчдын 75.8 хувь нь эрэгтэй, 24.2 хувь нь эмэгтэй<sup>77</sup> байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт зааснаар ажил олгогч нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тодорхой үүрэгтэй болно. Хяналт шалгалтад хамрагдсан 160 байгууллагын тушаал шийдвэрт дүн шинжилгээ хийхэд эмэгтэй ажилтныг жирэмсэн болон хүүхэд асарсан, бусад шалтгаанаар, ажилтнуудыг эрэгтэй, эмэгтэй хүйсээс нь хамааруулж ажлаас халсан, чөлөөлсөн тохиолдол гараагүй байв.

Харин хүүхэд асрах чөлөөтэй эмэгтэй ажилтны ажлын байранд түр ажилтныг томилохдоо үндсэн ажилтнаар ажиллуулахаар тушаал гаргасан<sup>78</sup> нь Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх хэсэгт “жирэмсний болон амаржсаны амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтны ажил, албан тушаалыг хэвээр хадгална”,

<sup>73</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 01/1222 дугаар албан бичиг.

<sup>74</sup> Хил хамгаалах ерөнхий газрын дэд даргын 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 3/2388 дугаар албан бичиг.

<sup>75</sup> Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 1/573 дугаар албан бичиг.

<sup>76</sup> Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 2/115 дугаар албан бичиг.

<sup>77</sup> Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 1/1080 дугаар албан бичиг.

<sup>78</sup> аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2018 оны 5/14 дүгээр тушаал.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах ба Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Дээрх тохиолдлын хувьд эмэгтэй ажилтанд жирэмслэх, хүүхэд төрүүлэх, асрах зэрэг нөхөн үржихүйн эрхээ эдлэхтэй холбоотойгоор ажлын байргүй болох, ажлын байрны нөхцөл нь дордох зэрэг эрсдлийг бий болгож байгаа нь жендэрийн ялгаварлан гадуурхалтын хэлбэр юм.

Иймээс төрийн байгууллагууд эмэгтэй ажилтныг жирэмсэн болон хүүхэд асрах хугацаанд нь ажлын байрыг хэвээр хадгалахын зэрэгцээ аль нэг хүйст давуу эрх олгох, хязгаарлалт тогтоохоос зайлсхийх, мөн жирэмсэлсэн, хүүхэд асарсан шалтгаанаар ялгаварлан гадуурхахгүй байх нь зүйтэй юм.

## Тохиолдол 2.2

*...Манай байгууллагад хэлтсийн даргын сул орон тоо гарсан юм. Тэгээд дарга 10 гаруй жил ажилласан эмэгтэйг уг албан тушаалд томилох бодолтой байсан ч тухайн эмэгтэй жирэмсний амралт авах болоод надад боломж олдож уг албан тушаалд томилогдох болсон. Манай бага хүүхэд оюутан, мөн намайг эрэгтэй хүн учраас цаашид тогтвортой ажиллана гэдэгт найдаж хэлтсийн даргын албан тушаалд томилсон юм...*

(Комиссоос 2019 онд орон нутгийн жендэрийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээний ярилцлагын тэмдэглэлээс)

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх хэсэгт “ажил олгогч нь хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх хэсэгт “албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах”-ыг хориглоно гэж тус тус заасан байна.

Хяналт шалгалтад хамрагдсан төрийн 160 байгууллагаас 103 нь ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэмдээ тусгасан байх боловч энэ төрлийн гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариуцлага тооцох механизмыг тусгаагүй зөрчил нийтлэг байна. Жендэрийн тэгш бус байдлын индексийн 2019 оны жагсаалтаар Монгол Улс 0.322 оноотойгоор нийт 189 улсаас 71 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. Үүний тод илрэл нь парламент дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 2019 оны байдлаар 17.1 хувь байгаа юм. Үүнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү 19 дэх илтгэлийн “Хүний эрхийн олон улсын индекс ба Монгол Улсын эзлэх байр” сэдэвт Дөрөвдүгээр бүлгээс үзнэ үү.

### 2.3 Орон нутгийн хэмжээнд жендэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагаа явуулж буй байдал

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь хэсэгт “тухайн салбар, орон нутгийн хэмжээнд жендэрийн сургалт, гэгээрлийн ажил явуулах”, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.2 дахь хэсэгт “бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж

хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх” үүргийг ажил олгогчид хүлээлгэсэн байна.

Комисс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр Төрийн албаны зөвлөлөөс 2018–2021 онд хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн “Төрийн захиргаан дахь жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх” 3 дахь үр дүнгийн ажлыг хариуцан гүйцэтгэж, 2018 онд 21 аймгийн төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдад “Жендэр ба хүний эрх” сэдэвт сургалтыг явуулж, нийт 420 жендэрийн сургагч багш бэлтгэсэн юм. Орон нутгийн зүгээс эдгээр сургагч багш нарын үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжлэг үзүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын гүйцэтгэлд нь хяналт тавих талаар Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг 16 аймгийн Засаг даргад хүргүүлсэн билээ.

Комиссоос 2019 онд аймгуудын Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын тамгын газрын дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, тухайн аймгуудын төрийн байгууллагуудын дарга нарыг “Жендэр ба хүний эрх” сургалтад оролцуулах хүсэлтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж улмаар тус газрын дэд даргын албан даалгаврыг 16 аймгийн Засаг даргад хүргүүлсэн бөгөөд үүний үр дүнд 16 аймаг дахь төрийн байгууллагуудад жендэрийн эрх тэгш байдлыг бий болгоход албан хаагчдын хүлээх үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулах, удирдах ажилтнуудын жендэр ба хүний эрхийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх багц сургалтыг зохион байгуулсан билээ.

Уг ажлын хүрээнд аймаг тус бүрт 30 удирдах ажилтанд сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн ч Өвөрхангай 26, Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 18, Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын

газрын хүсэлтээр 53, Дархан–Уул аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 11, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 34, Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 30, Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 16, Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 7, Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 8, Төв аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 8, Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 9, Булган аймгийн Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 2 ажилтан, нийт 221 албан хаагчийг нэмж оролцуулсан нь сайшаалтай байна.


Уг сургалтад нийт 701 төрийн албан хаагч хамрагдсанаас 418 буюу 59.6 хувь нь удирдах албан тушаалтан, 218 буюу 30.4 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан байгаагаас 344 эмэгтэй, 357 эрэгтэй байна.

Үүнээс үзэхэд аймаг, орон нутагт төрийн байгууллагын удирдлагууд дээрх сургалтад бүрэн хамрагдахгүй, өөрийнхөө оронд орлогч болон хариуцсан мэргэжилтнээ оролцуулж энэ төрлийн мэдлэг, ойлголтыг авч чадахгүй байгаа нь жендэрийн талаарх үйл ажиллагааг дэмждэггүй, шийдвэр гаргахдаа жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг орхигдуулж тухайн байгууллагад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хэрэгжихгүй байх нэг шалтгаан болж байна.

Хяналт шалгалтын хүрээнд судалгаанд хамрагдсан 1,681 төрийн албан хаагчаас жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой мэдлэг олгох сургалтад хамрагдаж байсан эсэхийг асуухад 567 нь буюу 33.7 хувь нь тийм, 1,164 нь буюу 66.3 хувь нь үгүй гэж хариулжээ.



**Бүдүүвч 2.4 Хяналт шалгалтад хамрагдсан 16 аймгийн төрийн албан хаагчдын жендэрийн мэдлэг олгох сургалтад хамрагдсан байдал (2019 он, тоогоор)**



Иймд төрийн байгууллагууд жил бүр жендэр ба хүний эрх, ялгаварлан гадуурхалт, ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой сургалт, гэгээрлийн үйл ажиллагааны талаар тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөө батлах, үе шаттай, давтамжтай зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй байна.

**2.4 Жендэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой гомдол шийдвэрлэлтийн байдал**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендэрийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, эдгээр хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Дээр дурдсан олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрүүдийг тууштай хэрэгжүүлдэггүй, гаргасан дүрэм, журамдаа байнгын хяналт тавьдаггүй зэргээс энэ төрлийн зөрчил буурахгүй, хүчирхийлэл үйлдэгчид нь хуулийн хариуцлага хүлээхгүй байна. Мөн хяналт шалгалтад хамрагдсан дийлэнх байгууллага хөдөлмөрийн дотоод журамдаа ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгаагүй, ажилтнуудад мэдлэг нэмэгдүүлэх үе шаттай сургалт зохион байгуулдаггүй, тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөөгүй байсан нь хуулийн хэрэгжилт, энэ талын ойлголт, мэдлэг тун хангалтгүй байгааг харуулж байна.

Комисс дээрх хуульд заасны дагуу улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхсантай холбоотой гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх бүрэн эрхийнхээ хүрээнд 2016–2018 онд 14, 2019 онд 9 иргэнээс ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн тухай гомдол тус тус хүлээн авсан байна. Иргэдийн гомдолд дүн шинжилгээ хийхэд 2019 онд ирүүлсэн 9 гомдлыг 25–35 насны эмэгтэйчүүд гаргасан бөгөөд үүний 2 нь ажлаас халагдсаныхаа дараа, 2 нь албан тушаал буурсныхаа дараа, 3 нь сахилгын шийтгэл хүлээснийхээ дараа тус тус ханджээ.

Ажлын байранд бэлгийн дарамт үйлдэгчийн 7 нь төрийн байгууллагын, 2 нь хувийн хэвшлийн удирдах албан тушаалтан байна. Шийдвэрлэлтийн хувьд авч үзэхэд ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлсэн болох нь тогтоогдсон гэх үндэслэлээр Комиссын гишүүний 5 шаардлага, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 зөвлөмжийг тус тус дээд шатны эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нь хүргүүлжээ.

Үүнээс үзэхэд ажлын байран дахь бэлгийн дарамтын хохирогчид нь хүчирхийлэгчийн үйлдлийг зөвшөөрөөгүй, хүлээж аваагүйн улмаас ажлаас чөлөөлөгдөж, албан тушаал буурч, үндэслэлгүйгээр сахилгын шийтгэл хүлээж, ажлын байрны дарамтад өртөж тэвчишгүй байдалд хүрснийхээ дараа холбогдох байгууллагад хандаж байна.

### Тохиолдол 2.3

*...захирал А нь байнгын дарамт үзүүлж, гэр бүл, аав ээж, нутаг ус, гадаад үзэмж, гэрлэсэн эсэх зэргийг оролцуулан элдвээр хэлж доромжилдог. Тухайлбал ажилтнуудын хурал дээр, өрөөндөө “чи гэртээ нэг эрийг бузарлаад л байж байгаа ш дээ, өмхий буриад, бүдүүн, гахай авгай, хулгайчид, бэлэвсэн авгай” гэх зэргээр доромжилдог. Тэрнийгээ та нар ажлаа хийж чадахгүй байгаа юм чинь ингэж хараалгуулж байгаа юм, би та нарт ажлын шаардлага тавьж байна гэж хэлдэг. Үүнээс гадна эмэгтэй залуу багш нарыг татаж чангаадаг, би захиралтай хамт түүний машинд суугаад нисэх буудал руу ажлаар явсан юм. Бид хоёр машины арын суудал дээр сууж явах үед захирал А надаас “ажил чинь ямархуу байна, хамт ажиллаж байгаа хүмүүс нь ямар байна” гэх зэргээр ярьж явахдаа миний баруун гарнаас атгасан. Тэгэхээр нь би гараа татаж автал дахиад гарнаас лавшруулж улам чанга атгаснаа миний гарыг өөрийнхөө зүүн гуян дээр тавиад нэлээд удаан гарыг атгаж явсан. Энэ хооронд захирлын утас дуугарахад нь би гараа татаж авсан юм. Тэгтэл захирал миний баруун гуян дээр гараа тавиад илсэн. Ингээд сургуулиас нисэх буудал хүртэл миний гарыг атгаад явахад надад маш эвгүй байсан, жолооч руу нь харахад машины голын толийг дээш нь болгочихсон байсан...*

*...сургуулийн захирал А намайг өрөөндөө ажлаа хийж байхад орж ирээд хажуу өрөө онгойлгуулж, намайг “ороод ир” гэсэн. Намайг ортол “би чамайг дэмжиж ажилладаг, одоо надтай*

*бэлгийн харьцаанд орохыг зөвшөөрчих юм бол чамайг янз бүрээр оролдохгүй мөрөөрөө ажлаа хийнэ биз” гэж дарамталсан. Үүнээс хойш ажил тэрсны дараа надруу гар утсаараа хэд хэдэн удаа залгаж “дуудсан газар ирээрэй” гэж давхар биетэй намайг байнгын сэтгэл санааны дарамтад оруулж байсан. Саналыг нь хүлээж аваагүй учир намайг өвчтэй байх хугацаанд албан тушаалыг маань бууруулж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллуулахаар ажлын байрыг сольсон...*

(Комисст ирүүлсэн иргэн Ш, Ө нарын гомдлоос)

Комиссоос гомдлын мөрөөр хяналт шалгалт явуулж, захирал А нь ажилтан Ш, Ө нарт ажлын байран дахь бэлгийн дарамт үзүүлсэн болох нь тогтоогдсон тул түүнд хариуцлага тооцуулахаар дээд шатны удирдах албан тушаалтанд нь Комиссын гишүүний шаардлага<sup>79</sup> хүргүүлсэн байна. Шаардлагын дагуу түүнд хариуцлага тооцох асуудлаар Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хуульд зааснаар сонсох ажиллагаа явуулж байгаа талаар хариу ирүүлсэн байна.<sup>80</sup> Гэвч энэ хугацаанд захирал А нь өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгджээ.

## Тохиолдол 2.4

*...С дарга амралтын өдрөөр над руу залгаж, танай хэлтсийнхэн ажиллаж байгаа, чи ирж түлхүүр аваадах би ...зочид буудлын ...тоот өрөөнд байна гэсэн. Тэгээд намайг очиход майк, дотоожтойгоо орон дээр хэвтэж байснаа наашаа суу гээд “залуу хүн тушаал дэвшихийг хүсдэг үү, би танай мастерыг халаад чамайг мастер болгоё, энийг уучих гээд хундагатай архи*

<sup>79</sup> Комиссын гишүүний 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 2/30 дугаар шаардлага.

<sup>80</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 1/3192 дугаар албан бичиг.

*өгөхөөр нь “би архи уудаггүй, хүүхдээ машинд үлдээчихсэн, гарчихаад ороод ирье” гэж хэлээд гарсан. Араас байн байн залгаад байхаар нь би “орохгүй” гэсэн чинь дарга уурласан. Үүнээс хойш байнга дарамталж загнадаг болсон. Өөрт нь зөвшөөрөөгүй учраас дарамт үзүүлж байна гэж боддог, үүнээс гадна эмэгтэй ажилтнуудын биед санамсаргүй байдлаар хүрэх асуудал энгийн үзэгдэл болсон...*

(Комисст ирүүлсэн иргэн М-ийн гомдлоос)

Комисс дээрх гомдлын мөрөөр хяналт шалгалт явуулж, С нь ажилтандаа ажлын байран дахь бэлгийн дарамт учруулсан болох нь тогтоогдсон тул хүний эрхийн ноцтой зөрчлийг таслан зогсоох, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах, цаашид энэ төрлийн зөрчлөөс сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авахуулахаар дээд шатны удирдах албан тушаалтанд нь Комиссын гишүүний шаардлага<sup>81</sup> хүргүүлсэн болно. Уг шаардлагын дагуу С-д үндсэн цалинг хоёр сарын хугацаатай 10 хувиар хасах сахилгын шийтгэл оногдуулсан байна.<sup>82</sup>

## Тохиолдол 2.5

*...нэр бүхий ТББ-ын хүсэлтээр иргэн М-ийн хамт орон нутагт томилолтоор ажилласан юм. Орой нь буудалдаа өдрийн ажлын үр дүнгээ ярилцаад сууж байхад М “танай өрөөнд орж хононо, хамт юм ярья, хоёулаа унтана” гэж удаа дараа хэлсэн. Би үүнд дургүйцэж өрөөндөө очоод байж байхад араас ирж хаалга нүдсэн. Би онгойлгоогүй тул сүүлдээ хаалганы бариулаар оролдож, онгойлгох гэж оролдож байх үед буудлын жижүүр ирсэн. Гэтэл “энэ өрөөний түлхүүрийг*

<sup>81</sup> Комиссын гишүүний 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 3/05 дугаар шаардлага.

<sup>82</sup> Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн 1 дүгээр орлогч даргын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 18/442 дугаар албан бичиг.

*аваад ир, онгойлго” гэж чанга дуугаар хэлэхийг би өрөөн дотроосоо сонссон.*

(Комисст ирүүлсэн иргэн З-гийн гомдлоос)

Комисс Шихихутуг хууль зүйн сургуультай хамтран 2018 онд хийсэн судалгаанд нийт 1,120 хүн хамрагдсанаас 805 нь буюу 82.1 хувь нь ажлын байран дахь бэлгийн дарамттай холбоотой үйлдэл, эс үйлдэхүйд өртсөн ажээ. Мөн Монголын эмэгтэйчүүдийн сан, Ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх ТББ-ын эвслээс хийсэн цахим судалгаагаар Монгол Улсад 5 эмэгтэй тутмын нэг нь ажлын байран дахь бэлгийн дарамтад өртөж, хохирогчдын 97.5 хувийг эмэгтэйчүүд, 2.5 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Бэлгийн дарамт үйлдэгчдийн 97.5 хувь нь эрэгтэй, 87.4 хувь нь дээд боловсролтой, 69.2 хувь нь удирдах албан тушаалтан байна.

Дээрх судалгаануудын дүн болон Комисст ирүүлсэн гомдлоос үзэхэд ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдал ямар түвшинд байгааг, мөн хохирогчид нь ихэвчлэн гомдлоо холбогдох байгууллагад гаргахгүй байгаа нь харагдаж байна.

Ажлын байран дахь бэлгийн дарамтын хохирогч гомдол гаргахгүй байгаа гол шалтгаан нь бэлгийн дарамтад өртөж байгаага мэддэггүй, мэдсэн ч өөрийн асуудлыг бусдад мэдэгдэхийг хүсдэггүй, нэр төрөө сэвтээх, ажлын байраа алдах, дахин дарамт ирэх болон хувийн нууцлал, мэдээлэл алдагдахаас эмээдэг, нийгэмд хохирогчийг буруутгадаг, бэлгийн сэдэл бүхий үг, үйлдлийг байх ёстой зүйл мэтээр үздэг хандлага, хэвшмэл ойлголт нийтлэг байдагтай шууд холбоотой юм.

Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой тусгадаггүй, гомдол гаргасан тохиолдолд нотлох баримт шаарддаг, гэрч, хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах асуудал баталгаагүй зэрэг нь нөлөөлж байна. Хуульд жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр болох ажлын байран дахь бэлгийн дарамтыг хориглож, энэ талаар ажил олгогч, ажилтны эрх үүргийг тодорхой зааж өгсөн хэдий ч ажлын байран дахь бэлгийн дарамт үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байсан юм.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр “бэлгийн дарамт учруулах” буюу “бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах”<sup>83</sup>-аар тусгасан нь сайшаалтай боловч олон улсын гэрээний заалт болон нөхцөл байдалтай тэр бүр уялдахгүй байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь хэсэгт “бэлгийн дарамт” гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж тодорхойлсон байна.

<sup>83</sup> Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.26.1 дэх хэсэг.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан “хурьцал үйлдэхээс өөр аргагүй байдалд оруулсан үйлдлийг” Зөрчлийн хуульд тусгаагүй байхын зэрэгцээ үүнийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдоггүй бөгөөд Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд хүчиндэх гэдэгт “... эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг” хэлнэ гэж заажээ.

Дээрхээс үзэхэд Зөрчлийн тухай хуулийн “бэлгийн дарамт учруулах” гэсэн зохицуулалт нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан “бэлгийн дарамт”-ын тодорхойлолттой бүрэн нийцээгүй, өөрөөр хэлбэл ажлын байран дахь бэлгийн дарамтын улмаас “хүч хэрэглэхгүйгээр хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан” тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх талаар эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх хэсэгт “албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах”-ыг төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглож, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсэгт “энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Тус хуулийг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа бөгөөд төрийн жинхэнэ албан



хаагчийн хувьд ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлыг хориглох, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай болсон нь сайшаалтай боловч улс төрийн болон үйлчилгээний албан хаагчдад уг хуулийн зохицуулалт хамаарахгүй байгаа нь учир дутагдалтай байгаагаас гадна практикт асуудал дагуулж эхэлсэн байна.<sup>84</sup>

Ажлын байран дахь бэлгийн дарамт нь хохирогчид биеийн болон сэтгэл санааны хүнд дарамт учруулах, хөдөлмөрийн бүтээмж нь буурах, гэр бүл салах, ажил, албан тушаалаа орхихоос өөр аргагүй байдалд хүргэх, хохирогчийн нэр төр сэвтэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх, улмаар амь нас нь хохирох хор уршиг дагуулж, далд хэлбэрээр оршсоор байх тул энэ төрлийн үйлдэл гаргагчид оногдуулах хариуцлагыг улам тодорхой болгох зүй ёсны шаардлага гарч байна.

Нөгөөтэйгүүр ажлын байран дахь бэлгийн дарамтыг хүмүүсийн хайр сэтгэлээс үүдэлтэй дотно харилцаанаас ялгаж ойлгох нь чухал бөгөөд ажлын байран дахь бэлгийн дарамтын онцлох шинж нь зөвхөн хүсээгүй байдгаараа ялгаатай юм.

Практикаас харахад ажлын байран дахь бэлгийн дарамтыг бусад харилцаанаас ялгаж танихгүйгээс болж хэн нэгнийг хүчирхийлэгч мэтээр харагдуулах, үндэслэлгүйгээр арга хэмжээ тооцуулах, хувь хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндэд нь халдах явдал гарч болзошгүй тул хууль хэрэгжүүлэгчдийн зүгээс үүнийг анхаарч ажиллах хэрэгтэй байна.

---

<sup>84</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл. Гуравдугаар бүлэг, 110 дахь тал.

Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар Бага хурлаар “Хүчирхийлэл болон дарамтын тухай” 190 дүгээр конвенцыг<sup>85</sup> баталсан байх ба одоогоор хүчин төгөлдөр болоогүй байна.

Конвенцын 14.2 дугаар зүйлд “Соёрхон баталсан тухай хоёр улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ерөнхий захиралд бүртгүүлсэн өдрөөс хойш 12 сарын дараа уг конвенц хүчин төгөлдөр болно” гэж заажээ.

2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар дээрх конвенцыг Уругвай Улс соёрхон баталсан анхны улс болсон байна. Тус улс нь конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг 9 сард парламентдаа өргөн барьсан бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр уг хуулийг баталжээ.

Азербайжан, Камерун, Эстони, Финлянд, Исланд, Иран, Люксембург, Словени, Того зэрэг 9 улсын Засгийн газар тус конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хууль тогтоох байгууллагадаа өргөн барьсан байна.<sup>86</sup> Иймд Монгол Улс “Хүчирхийлэл болон дарамтын тухай” 190 дүгээр конвенцыг соёрхон батлах шаардлагатай юм.

---

<sup>85</sup> [https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO:P12100\\_ILO\\_CODE:C190](https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO:P12100_ILO_CODE:C190)

<sup>86</sup> [http://www.industrial-union.org/uruguay-becomes-first-country-to-ratify-ilo-convention-190?utm\\_source=Newsletters+in+English&utm\\_campaign=ab5d850a78-EMAIL\\_CAMPAIGN\\_2020\\_01\\_16\\_04\\_26&utm\\_medium=email&utm\\_term=0\\_65751b77d5-ab5d850a78-19172081](http://www.industrial-union.org/uruguay-becomes-first-country-to-ratify-ilo-convention-190?utm_source=Newsletters+in+English&utm_campaign=ab5d850a78-EMAIL_CAMPAIGN_2020_01_16_04_26&utm_medium=email&utm_term=0_65751b77d5-ab5d850a78-19172081)

# III

БҮЛЭГ

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН  
ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ТАЛААР  
ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ**

*“Гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар  
сайжруулах”*

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай  
олон улсын пактын 12 дугаар зүйлийн 2 (b) хэсэг)

*“Хүн бүр эрхэмсэг сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлдэг  
дээд зэргийн орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш байх, амьдралын  
таатай нөхцөлөөр хангагдах үндсэн эрхтэй агаад одоо ба хойч  
үеийнхээ төлөө хүрээлэн буй орчноо хамгаалах хөгжүүлэх журамт  
үүргийг хүлээнэ.”*

(Хүрээлэн буй орчны тухай Стокгольмын тунхаглалын 1 дүгээр зүйл)

*“Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн  
тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”*

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалт)

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцод<sup>87</sup> 1997 онд, “Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенцод<sup>88</sup> 2001 онд, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцод<sup>89</sup> 2002 онд тус тус нэгдэн орсон байна.

Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенцын 12 дугаар зүйлийн (a) хэсэгт “Химийн бодис” гэж өөрийн үндсэн буюу хольц болон бэлтгэц байдлаар байгаа үйлдвэрлэлийн аргаар буюу байгалиас гаргаж авсан химийн бодисыг хэлэх бөгөөд түүнд ямар нэг амьд биет үл хамаарна. Энэхүү химийн бодис нь пестицидийн (онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүнийг оруулан) болон үйлдвэрлэлийн гэсэн зориулалтын ангилалтай байна”, мөн зүйлийн (b) хэсэгт “Хориглосон химийн бодис” гэж хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд эцэслэн журамласан арга хэмжээгээр нэг буюу хэд хэдэн

<sup>87</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагаас “Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц”-ыг 1989 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталж, 1992 оны 5 дугаар сарын 5-ны өдөр хүчин төгөлдөр болсон, Монгол Улс 1997 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр соёрхон баталж, 1997 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

<sup>88</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагаас “Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц”-ыг 1998 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр баталж, 2004 оны 2 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон, Монгол Улс 2001 оны 3 дугаар сарын 8-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсан.

<sup>89</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагаас “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц”-ыг 2001 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталж, 2004 оны 5 дугаар сарын 17-ны өдөр хүчин төгөлдөр болсон, Монгол Улс 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр соёрхон баталж, 2004 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

зориулалтын ангиллын хүрээнд бүх төрлийн ашиглалтыг нь хязгаарласан химийн бодисыг хэлнэ. Түүнд хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчныг хамгаалах бодит шаардлагын үүднээс анх удаагийн хэрэглээг нь зөвшөөрөөгүй түүнчлэн үйлдвэрлэлийн улмаас дотоодын зах зээлээс хасагдсан буюу дотоодод хэрэглэх асуудлыг цаашид авч хэлэлцэхгүй болсон химийн бодисууд хамаарна.” гэжээ.

Мөн конвенцын 12 дугаар зүйлийн зүйлийн (с) хэсэгт “Онцгой хязгаарласан химийн бодис” гэж хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд эцэслэн журамласан арга хэмжээгээр нэг буюу хэд хэдэн зориулалтын ангиллын хүрээнд бүх төрлийн ашиглалтыг нь хязгаарласан боловч зарим онцгой тохиолдолд ашиглахыг зөвшөөрсөн химийн бодисыг хэлнэ. Түүнд хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчныг хамгаалах бодит шаардлагын үүднээс бараг бүх төрлийн хэрэглээг нь зөвшөөрөөгүй түүнчлэн үйлдвэрлэлийн улмаас дотоодын зах зээлээс хасагдсан буюу дотоодод хэрэглэх асуудлыг цаашид авч хэлэлцэхгүй болсон химийн бодисууд хамаарна” гэж тодорхойлжээ.

Монгол Улс Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийг 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр, Хог хаягдлын тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг 1995 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр тус тус баталж, химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ, хадгалалт хамгаалалтын асуудлыг хуульчилсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 95 дугаар тогтоолын 1 дүгээр

хавсралтаар “Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайдын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 334/104 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”-ыг тус тус баталжээ.

Мөн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/356/396 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар “Химийн хорт болон аюултай бодисын ангилал”, “Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлал”-ыг баталснаас гадна “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй: Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахад тавигдах шаардлага” MNS6458:2014 стандарт хүчин төгөлдөр үйлчилж байна.

Нийгэм хөгжихийн хэрээр хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэлд хүргэх үйлчилгээтэй, мөн тэсрэмтгий, шатамхай, исэлдүүлэгч, идэмхий, цочроогч шинж чанартай химийн хорт болон аюултай бодисыг иргэд ахуйн хэрэглээндээ, аж ахуйн нэгж, байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэх нь нэмэгдэж байгаагаас түүнийг хадгалах, хамгаалах болон

устгах асуудалд онцгой анхаарал хандуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Өнөөдөр дэлхий даяар ашиглагдаж байгаа 11 сая орчим нэр төрлийн химийн бодисоос 10 мянга гаруйд нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд нь эрсдэлийн үнэлгээ хийсэн байх бөгөөд 50 жилийн өмнө жилд дунджаар 1 сая тонн химийн бодис үйлдвэрлэж байсан бол өнөөдрийн байдлаар 400 сая тонн химийн бодис үйлдвэрлэгдэж, 100 орчим мянган нэр төрлийн химийн бодисыг улс хооронд худалдаалж, жилдээ 1,000 орчим нэр төрлийн химийн бодисыг шинээр нээж байна.<sup>90</sup>

Түүнчлэн Монгол Улсад сүүлийн жилүүдэд уул уурхай, үйлдвэрлэлийн салбар хөгжихийн хэрээр химийн бодисын хэрэглээ ихэсч байгаа бөгөөд 941 аж ахуйн нэгж, байгууллага химийн бодис ашиглан үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс жилд 10 хувь нь уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлд, 11 хувь нь арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэлд, 5 хувь нь бетон зуурмагийн үйлдвэрлэлийн нэмэлт бүтээгдэхүүнд, 44 хувь нь судалгаа шинжилгээ, эмнэлгийн лаборатори, сургуульд, 3 хувь нь ургамал хамгааллын чиглэлээр, 1 хувь нь химийн бодисын үйлдвэрлэл, хөөсөнцөр, дулаалга, шугам хоолойн үйлдвэрлэл, 12 хувь нь импортлогчид, 12 хувь нь бусад төрлийнх байна. Нийт 2,893 нэр төрлийн 67.188.3 тонн химийн бодисыг хэрэглэж<sup>91</sup> байна.

Комисст Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 02/370 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэлд 2014 онд холбогдох байгууллагуудтай хамтран хийсэн судалгаагаар 335 аж ахуйн нэгж, байгууллагад давхардсан тоогоор 10,918 нэр

<sup>90</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 02/370 дугаар албан бичиг.

<sup>91</sup> Мөн тэнд.



төрлийн 368.6 тонн, давхардсан тоогоор 892 нэр төрлийн 68,368.7 литр, 578 хайрцаг бодис, 12 баллон хий зэрэг устгах шаардлагатай бодис хадгалагдаж байна. Эдгээрээс 181 нэр төрлийн химийн хорт болон аюултай бодисын нэр, хаяг нь тодорхойгүй байна.

Мөн судалгаанд хамрагдсан байгууллагуудын зөвхөн 14.6 хувь нь химийн бодис хадгалах зориулалтын агуулах ашиглаж байгаа бол 54.9 хувь нь ажлын байранд, 25.4 хувь нь зориулалтын бус агуулахад, 2.6 хувь нь ил задгай, 1.7 хувь нь ажлын байрныхаа зоорийн давхарт тус тус хадгалж байна. Тухайлбал Хөвсгөл аймагт 63 нэр төрлийн 13.7 кг, 2 нэр төрлийн 2.3 кг бодис тус аймгийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн ажлын өрөөнд хадгалагдаж байна.<sup>92</sup>

### Тохиолдол 3.1

*...Сүхбаатар аймагт 2004 оны 2 дугаар сард гарсан малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний ариутгал халдваргүйжүүлэлтэд ашиглаж байсан "формалин" гэх химийн бодис дууссанаас улсын нөөцөөс 2004 оны 2 дугаар сарын 27-ны өдөр аймгийн мал эмнэлгийн албанд 6 тонн формалин өгч, өвчин гарсан сумдад хуваарилсан байна.*

*Гэтэл тухайн бодис нь "формалин" биш маш хортой "формальдегид" гэдэг химийн хорт бодис болох нь тогтоогдсон тул ашиглагдаагүй үлдэгдэл бодисыг сумдаас буцаан татаж, мал эмнэлгийн хашаанд одоог хүртэл буюу 16 жил хадгалж байна.*

<sup>92</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 02/370 дугаар албан бичиг.

*Энэхүү бодисоор тухайн үед халдваргүйжүүлэлт хийсэн ажилтнууд хордлого авч, 20 гаруй хүн эрүүл мэндийн үзлэгээр элэг болон бусад эд эрхтний өөрчлөлттэй гарч аймгийн нэгдсэн эмнэлэгт хор саармагжуулах эмчилгээ хийлгэсэн байна.*

(Комиссоос 2019 онд Сүхбаатар аймагт ажилласан ажлын хэсгийн тэмдэглэлээс)

Одоогоор Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн хашаанд 2004 оноос хойш 4.2 тонн формальдегид, 2004 онд хугацаа нь дууссан 0.5 тонн идэмхий натри хадгалагдаж байгаа бөгөөд эдгээр бодисын хадгалалт, хамгаалалтын талаар тодруулахад аюултай бодисын ангилалд ордог бодисуудыг саармагжуулах талаар холбогдох газруудад хандсан боловч тодорхой шийдэлд хүрээгүй байна. Улмаар Онцгой байдлын ерөнхий газарт 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр хүсэлт гарган Үндэсний аврах бригадыг авчирч битүүмжлэх ажиллагаа хийлгэжээ.

Түүнчлэн 21 аймгийн хэмжээнд хэрэглэгдэж буй химийн хорт болон аюултай бодисын талаар Комисст ирүүлсэн мэдээллээс үзэхэд давхардсан тоогоор Архангай аймагт 203,<sup>93</sup> Баян-Өлгий аймагт 737,<sup>94</sup> Баянхонгор аймагт 19,<sup>95</sup> Булган аймагт 147,<sup>96</sup> Говь-Алтай аймагт 164,<sup>97</sup> Говьсүмбэр

<sup>93</sup> Архангай аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 01/150 дугаар албан бичиг.

<sup>94</sup> Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 2-01/123 дугаар албан бичиг.

<sup>95</sup> Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2/188 дугаар албан бичиг.

<sup>96</sup> Булган аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 01/134 дугаар албан бичиг.

<sup>97</sup> Говь-Алтай аймгийн Засаг даргын орлогчийн 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 2/215 дугаар албан бичиг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН  
ТАЛААР ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

аймагт 284,<sup>98</sup> Дархан–Уул аймагт 1,375,<sup>99</sup> Дорнод аймагт 108,<sup>100</sup> Дорноговь аймагт 342,<sup>101</sup> Дундговь аймагт 500,<sup>102</sup> Завхан аймагт 420,<sup>103</sup> Орхон аймагт 1,334,<sup>104</sup> Өвөрхангай аймагт 68,<sup>105</sup> Өмнөговь аймагт 707,<sup>106</sup> Сүхбаатар аймагт 774,<sup>107</sup> Сэлэнгэ аймагт 205,<sup>108</sup> Төв аймагт 571,<sup>109</sup> Увс аймагт 337,<sup>110</sup> Ховд аймагт 524,<sup>111</sup> Хөвсгөл аймагт 245,<sup>112</sup> Хэнтий аймагт 221<sup>113</sup> нэр төрлийн химийн хорт болон аюултай бодис тус тус хэрэглэгдэж байна.

---

<sup>98</sup> Говьсүмбэр аймгийн Засаг даргын орлогчийн 2020 оны 2 дугаар сарын 5–ны өдрийн 5/140 дугаар албан бичиг.

<sup>99</sup> Дархан–Уул аймгийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 5–ны өдрийн 5–10/141 дугаар албан бичиг.

<sup>100</sup> Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 2 дугаар сарын 5–ны өдрийн 2/314 дугаар албан бичиг.

<sup>101</sup> Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 2 дугаар сарын 4–ний өдрийн 3/205 дугаар албан бичиг.

<sup>102</sup> Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 4–ний өдрийн 4/159 дугаар албан бичиг.

<sup>103</sup> Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 1 дүгээр сарын 30–ны өдрийн 07/52 дугаар албан бичиг.

<sup>104</sup> Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газрын даргын 2020 оны 2 дугаар сарын 3–ны өдрийн 35 дугаар албан бичиг.

<sup>105</sup> Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 5–ны өдрийн 1/44 дугаар албан бичиг.

<sup>106</sup> Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 3–ны өдрийн 5–428 дугаар албан бичиг.

<sup>107</sup> Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 5–ны өдрийн 5/126 дугаар албан бичиг.

<sup>108</sup> Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 20–ны өдрийн 1/153 дугаар албан бичиг.

<sup>109</sup> Төв аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 4–ний өдрийн 01/218 дугаар албан бичиг.


<sup>110</sup> Увс аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газрын 2020 оны 2 дугаар сарын 12–ны өдрийн 47 дугаар албан бичиг.

<sup>111</sup> Ховд аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 5–ны өдрийн 1/244 дугаар албан бичиг.

<sup>112</sup> Хөвсгөл аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 3–ны өдрийн 1/312 дугаар албан бичиг.

<sup>113</sup> Хэнтий аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 12–ны өдрийн 9/260 дугаар албан бичиг.

Бүдүүвч 3.1 Химийн хорт болон аюултай бодисын  
хэрэглээ (давхардсан тоогоор)



Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлнэ.”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Химийн хорт болон аюултай бодисын хаягдал устгах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.”, Хог хаягдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт “аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг” гэж тус тус заасан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН  
ТАЛААР ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайдын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 334/104 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”-ын 2.1.1 дэх заалтад зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас аж ахуйн нэгж, байгууллагын албан ёсны хүсэлт, иргэний өргөдлийг үндэслэн 2010–2019 оныг хүртэлх хугацаанд химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах нийт 4,058 зөвшөөрлийг олгожээ.<sup>114</sup>

**Хүснэгт 3.1 Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах олгосон зөвшөөрөл (2010–2019 оноор)**

№	Аймаг, хотын нэр	Зөвшөөрлийн төрөл (2010–2019)						Нийт
		Ашиглах	Экспортлох	Импортлох	Худалдах	Үйлдвэрлэх	Хил дамжуулан тээвэрлэх	
1	Улаанбаатар	1404	24	1413	565	22	10	3438
2	Дорнод	21	–	15	5	–	–	41
3	Сүхбаатар	9	–	4	–	–	–	13
4	Хэнтий	2	–	–	–	–	–	2
5	Төв	7	–	4	2	–	–	13
6	Говьсүмбэр	2	–	1	–	–	–	3
7	Сэлэнгэ	14	–	10	4	–	–	28
8	Дорноговь	5	–	2	1	–	–	8
9	Дархан Уул	46	–	39	17	1	–	103
10	Өмнөговь	5	–	4	2	–	–	11
11	Дундговь	1	–	–	–	–	–	1
12	Орхон	48	–	40	10	–	–	98

<sup>114</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим хуудас. [https://eic.mn/toxic/talicense\\_stat.php?page=1&action=chart&statistic\\_list=1&statistic\\_year1=2008&statistic\\_year2=2019](https://eic.mn/toxic/talicense_stat.php?page=1&action=chart&statistic_list=1&statistic_year1=2008&statistic_year2=2019)

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,  
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19 ДЭХ ИЛТГЭЛ

13	Өвөрхангай	1	-	-	-	-	-	1
14	Булган	2	-	1	-	-	-	3
15	Баянхонгор	1	-	-	-	-	-	1
16	Архангай	16	-	11	2	-	1	30
17	Хөвсгөл	2	-	-	-	-	-	2
18	Завхан	2	-	-	-	-	-	2
19	Говь-Алтай	1	-	-	-	-	-	1
20	Баян Өлгий	2	-	-	-	-	-	2
21	Ховд	2	-	1	-	-	-	3
Нийт		1706	24	1642	649	25	12	4058

Үүнээс сүүлийн 5 жилийн дунджаар, жилд 260 орчим аж ахуйн нэгж, байгууллага 2,600 орчим нэр төрлийн 430 мянган тонн химийн бодисын тусгай зөвшөөрөл авсан байна.<sup>115</sup> Онцгой хортой шинж чанартай химийн бодис болох цианидыг тээвэрлэх үйл ажиллагааг хуулийн хүрээнд тогтмол хяналт тавьж, холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, тээвэрлэх журмын дагуу явуулж байгаа бөгөөд бусад бодисын хувьд импортлохоос ашиглах, худалдан борлуулах, хэрэглэгчид хүргэх үйл ажиллагаа ямар ч хяналтгүй байна.

Химийн хорт болон аюултай бодисын агуулах барих газрын байршлыг сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгадаггүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга тогтоож өгдөггүйгээс иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын агуулах нь шаардлага хангахгүй байна. Хуульд химийн бодисын хэмжээнээс хамаарч ашиглах зөвшөөрөл өгөх зохицуулалт байхгүйгээс бага хэмжээтэй бодис ашиглаж буй аж ахуйн нэгж байгууллагууд нь тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг зөрчил илэрч байна.<sup>116</sup>

<sup>115</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 06/1747 дугаар албан бичиг.

<sup>116</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 02/370 дугаар албан бичиг.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 95 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "альдрин, бинапакрил, бромтметил, гептахлор" зэрэг нийт 126 нэр төрлийн химийн хорт болон аюултай бодисыг Монгол Улсад ашиглахыг хориглосон бол мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар "бензидин, бифенил амин этилендихлорид" зэрэг нийт 31 нэр төрлийн химийн хорт болон аюултай бодисыг Монгол Улсад ашиглахыг хязгаарласан боловч хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэх, ашиглах явдал гарсаар байна.

### Тохиолдол 3.2

*Монгол Улсын хоёр иргэн 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "Скай ресорт" цанын баазын хашаанд ...дугаартай автомашинд Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт аюултай бодисын жагсаалт"-д багтсан мөнгөн усыг хууль бусаар хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан үйлдлийг Цагдаагийн байгууллага илрүүлэн шалгаж шүүхээр шийдвэрлүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн...*

(Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 01/122 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээллээс)

### Тохиолдол 3.3

*Иргэн Б нь 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдөр ...ДГО улсын дугаартай УАЗ маркийн автомашинаар 450 килограмм химийн хорт бодисыг улсын хилээр хууль бусаар*

*нэвтрүүлсэн үйлдлийг цагдаагийн байгууллага шалгаж шүүхээр шийдвэрлүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн...*

(Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны  
2 дугаар сарын 12-ны өдрийн О1/122 дугаар  
албан бичгээр ирүүлсэн мэдээллээс)

### Тохиолдол 3.4

*...Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг дэвсгэрт ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй "Д" ХХК-ийн уурхайн дарга Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн Ф нь 2017 оны 9 дүгээр сараас 2017 оны 10 дугаар сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд хууль бусаар олж авч тээвэрлэсэн химийн хорт болон аюултай бодис болох 82 тонн натри сульфидийг хууль бусаар хадгалж, ашиглан хүдрийн баяжмал бэлтгэх явцдаа баяжуулах технологийн горимыг зөрчсөнөөс говь цөлийн хуурай ландшафтад гадаргын ил урсац үүсгэсэн, далд уурхайн шүүрлийн усыг байгальд шууд асган 5,120 м<sup>2</sup> хөрс талбайг химийн бодисоор бохирдуулж, 2.27 га талбайд эвдрэл үүсгэж, 41,150 м<sup>3</sup> ухаш бүхий эвдрэлийг газрын хэвлийд үүсгэсэн зэргээр Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт нийт 134,168,951 төгрөгийн буюу их хэмжээний хохирол учруулсан нь тогтоогджээ...*

(Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 128 дугаар шийтгэх тогтоол ([www.shuukh.mn](http://www.shuukh.mn)))

Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаагийн хэрээр энэ төрлийн осол, зөрчлийн тоо улам бүр нэмэгдсээр байна. Монгол Улсад сүүлийн 3 жилийн байдлаар химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ, хадгалалт, хамгаалалттай холбоотойгоор Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд 2017 онд 26,



ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН  
ТАЛААР ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

2018 онд 31, 2019 онд 48 гэмт хэрэг, гомдол, мэдээлэл бүртгэгдсэн байна.<sup>117</sup>

**Хүснэгт 3.2 Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл.**

Д/д	Он	Яллах дүгнэлт үйлдэх саналтайгаар Прокурорт шилжүүлсэн	Хэрэгсэхгүй болгох саналтайгаар Прокурорт шилжүүлсэн	Шүүхэд шилжүүлэх саналтайгаар Прокурорт шилжүүлсэн	Ажиллагаанд
1	2017	9	4	4	2
2	2018	–	3	10	1
3	2019	–	–	9	10
Нийт		9	7	23	13

**Хүснэгт 3.3 Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.**

Д/д	Он	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	Харьяалаар шилжүүлсэн
1	2017	2	5	–
2	2018	12	3	2
3	2019	21	7	1
Нийт		35	15	3

Мөн химийн хорт болон аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж, хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагаас зохих арга хэмжээг авч байна.

<sup>117</sup> Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн О1/122 дугаар албан бичиг.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлд “Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ” гэж заасан байна.

Түүнчлэн энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон, их хэмжээний хохирол учирсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос найман жил хүртэл хугацаагаар хорих ялаар, гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ялаар шийтгэхээр тус тус хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчилж өгсөн байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар онцгой байдлын байгууллагад химийн хорт болон аюултай бодисын холбогдолтой осол, зөрчлийн дуудлага нийт 143 удаа бүртгэгдэж, осол, зөрчлийн улмаас 23 хүн амь насаа алдаж, 204 хүн бэртэж, гэмтсэн<sup>118</sup> байна. Химийн хорт болон аюултай бодис нь гол, далайн ус, агаар, хүн амын өргөн хэрэглээ гэх мэт бүхий л замаар хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах эрсдэлийг дагуулдаг.

Гэвч үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулиудад устгах шаардлагатай их хэмжээний

<sup>118</sup> Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 6/441 дугаар албан бичиг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН  
ТАЛААР ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ

химийн бодис, холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж байсан, хугацаа нь дууссан химийн хорт болон аюултай бодис, Мэргэжлийн хяналт, цагдаа, онцгой байдлын газрын хяналт шалгалт болон химийн бодистой холбоотой үүссэн хэрэг зөрчлийг шалгах, орчны бохирдлыг цэвэрлэх арга хэмжээний үед иргэд, аж ахуйн нэгжээс хураасан, ялгаж авсан бодис тус тус удаан хугацаанд хуримтлагдсан байна. Тэдгээр химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа, боодол элэгдэж эвдрэн, асгарч алдагдах эрсдэлийг бий болгосон, түүнийг ил задгай, зориулалтын бус байранд хадгалж байгаа нийтлэг зөрчил байсаар байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 3.1.1.1 дэх заалтад “Химийн хорт болон аюултай бодис нь зориулалтын сав, баглаа боодол, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой байна” гэж заасан байх боловч бодит байдал дээр нэр хаяг, гарал үүсэл, хугацаа нь тодорхойгүй маш олон нэр төрлийн химийн хорт болон аюултай бодис хадгалагдсаар байна.

Тухайлбал Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь хилийн боомтын Гаалийн газрын түр агуулахад хаяг шошгогүй, экспортлогч улсын дагалдах баримт бичгийн бүрдэл дутуу, холбогдох байгууллагаас тусгай зөвшөөрөл аваагүй, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэх зөрчлийн хүрээнд хураагдсан 18 нэр төрлийн,<sup>119</sup> Архангай аймагт аюулгүй байдал, стандартын шаардлага бүрэн хангаагүй, цонх, хаалганы хамгаалалт хийгдээгүй, зориулалтын бус агуулахуудад нэр, хаяг нь тодорхойгүй 436 нэр төрлийн химийн хорт болон аюултай бодисыг хадгалж байна.

<sup>119</sup> Комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 1 дүгээр сард Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ажилласан илтгэх хуудас.

Мөн Орхон аймагт нийт 1,334 (давхардсан тоогоор) нэр төрлийн, 7.1 сая тонн химийн хорт болон аюултай бодис байгаагаас 211 мянган тонн хортой бодис, 6.9 сая тонн аюултай бодис байна. Мөн устгах шаардлагатай 373 нэр төрлийн 6,863 кг хуурай бодис, 29 нэр төрлийн 135.64 литр шингэн бодис тус тус хадгалагдаж байна.<sup>120</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтэд Булган аймгийн 2 дугаар багт байрлах Мал эмнэлгийн газарт хяналт шалгалт хийсэн юм.

Тус газрын Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилга нь 1959 онд ашиглалтад орсон, аймгийн төвийн орон сууц, сургууль, цэцэрлэгийн дунд байрладаг бөгөөд лабораторид ашиглагдаж байсан химийн бодисыг устгалд оруулах эрх зүйн зохицуулалт байхгүй гэх шалтгаанаар одоог хүртэл 1960–1970 оны үед хуучин социалист орнуудын тусламжаар нийлүүлсэн 94 нэр төрлийн 61 кг хуурай химийн бодис, 25.9 литр шингэн химийн бодисыг зоорийн давхарт 50 гаруй жил хадгалж байна. Үүнээс болж тус газрын хөрсөнд болон барилга байгууламжид химийн хорт бодис ихээр шингэсэн тул уг химийн бодисыг 2014 онд зоорийн давхраас гаргаж барилгын гадна агуулахад хадгалж байна.

Хяналт шалгалтын үед тус лабораторийн барилга дотор болон ойр орчимд химийн бодисын хурц, эхүүн үнэр ихээр тархсан байдалтай байв. Тухайн лабораторид мэргэжлээрээ 1–13 жил ажиллаж байгаа 5 ажилтан байх бөгөөд ажилтнуудаас ажлын байрны нөхцөл байдлын талаар тодруулахад “...байнга амьсгаа давхцах, толгой дүйрэх, ханиалгах, бие загатнах, биеэр юм туурах зэрэг

<sup>120</sup> Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газрын даргын 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 35 дугаар албан бичиг.

шинж тэмдэг илэрдэг тул ажилтнууд жилд хамгийн багадаа нэг удаа эмнэлэгт хэвтэн эмчлүүлдэг” гэж ярьснаас үзэхэд ажилтнуудын эрүүл мэндэд ноцтой хохирол учирсаар байна.<sup>121</sup>

Монгол Улсад Бүгд Найрамдах Чех Улсаас хэрэгжүүлж буй “Хөгжлийн тусламжийн хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийн санхүүжилтээр хийгдсэн Экологийн бохирдлыг арилгахад ноу-хау технологи нэвтрүүлэх хоёрдугаар шат Монгол Улс-Булган аймаг орчмын эрсдэлийн шинжилгээгээр “Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгын газар болон ойр орчмын газрын хөрс маш их хэмжээгээр пестицидээр бохирдсон” гэх дүгнэлт гарсан байна.

Иймээс тус лабораторийн ажилтнуудыг эрүүл ахуй, чанар, стандартын шаардлага хангасан шинэ ажлын байранд нэн даруй шилжүүлэн ажиллуулах талаар Комиссын гишүүний шаардлагыг<sup>122</sup> Мал эмнэлгийн ерөнхий газрын даргад хүргүүлсэн бөгөөд тус газраас<sup>123</sup> тухайн лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд 2019 оны төсөвт шинээр барилга барихаар төлөвлөж, тэр хүртэл эрүүл ахуйн шаардлага хангасан түрээсийн байранд лабораторийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхээр судалж байна гэх хариуг ирүүлсэн юм.

Мөн Комиссоос 2019 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Булган аймагт ажиллах явцдаа Мал эмнэлгийн газрын Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн үйл ажиллагааг дахин шалгахад лаборатори нь хуучин байрандаа одоог хүртэл үйл ажиллагаа явуулж, лабораторийн байрны

<sup>121</sup> Булган аймагт 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт”-д Комиссоос хийсэн хяналт шалгалтын илтгэх хуудас.

<sup>122</sup> Комиссын гишүүний 2020 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 1/09 дугаар шаардлага.

<sup>123</sup> Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 277 дугаар албан бичиг.

агуулахын өрөөний зоорийг шороогоор дүүргэн бөглөж шалласан, агааржуулалтын систем шинээр хийсэн байх боловч химийн хорт бодисын эхүүн үнэр урьдын адил үнэртэж, ажилтнуудыг эрүүл ахуй, чанар, стандартын шаардлагад нийцсэн ажлын байраар хангаагүй байсан юм. Иймд Комиссоос Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад албан бичиг<sup>124</sup> хүргүүлсэн боловч одоог хүртэл энэ талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Тухайн газарт Бүгд Найрамдах Чех Улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Деконта” ХХК 2014 онд хөрсний бохирдлын судалгаа, химийн хорт бодисын бохирдлын шинжилгээ хийхэд газрын хөрсөнд пестицид гэх бодис агуулагдаж байгаа нь тогтоогдсон байх бөгөөд 2016 онд дахин хөрс, усанд нарийвчилсан шинжилгээ хийхэд хөрс нь маш их бохирдолтой, харин ус нь бохирдолгүй гэх дүгнэлт гарсан байна. Хөрснөөс доош 60 метрийн гүнд цооног ухаж шинжилгээ хийхэд илэрсэн пестицид гэх химийн бодис нь хүний ген удмын санд нөлөөлдөг гэж тухайн судлаачид тайлбарлаж, “энэ газрыг яаралтай цэвэрлэх нь зүйтэй” гэсэн зөвлөмжийг Булган аймгийн Засаг даргад хүргүүлжээ.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2005, 2013 онд хийсэн “Удаан задардаг органик бохирдуулагч”-ийн тооллогоор Монгол Улсад ашиглахыг хориглосон пестицид зориулалтын бус газар хадгалагдаж, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөө үзүүлж байгааг тогтоосон байна.<sup>125</sup>

<sup>124</sup> Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 1/742 дугаар албан бичиг.

<sup>125</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 02/370 дугаар албан бичиг.

### Тохиолдол 3.5

*Нийслэлийн Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байсан шилний үйлдвэрт ашиглаж байсан химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалт алдагдсанаас тухайн газрын хөрс болон агаарт шингэж, улмаар иргэдийн эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ нь иргэдийн олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ноцтой зөрчигдөхөд хүргэж байгааг анхааралдаа авна уу...*

(Комисст иргэдээс ирүүлсэн мэдээллээс)

Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах шилний үйлдвэр нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс, Бүгд Найрамдах Польш Улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1950-иад оны үед байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаад 1990 онд хувьчлагджээ. Уг үйлдвэрийн үйл ажиллагаанаас үлдсэн химийн хорт бодис болох хүнцлийн оксидыг үйлдвэрийн хуучин зоорийг агуулах болгон засаж тохижуулан хадгалж, үйлдвэр орчимд барийн сульфат, хар тугалгын сульфат, калийн хлорид, кальцийн сульфатыг ил задгай хадгалж байжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран Чехийн хөгжлийн агентлаг, “Деканто” ХХК-ийн “Экологийн ачаалалтай тэмцэх талаарх хандлагын ноу-хауг нэвтрүүлэх төслийн хүрээнд 2017 онд дээрх шилний үйлдвэрийн газар доорх усны дээжийг Cr<sup>6+</sup>, Cr<sup>tot</sup>, As, Pb, Hg, Cd, Ni, Cu, Zn, Ba зэрэг хүнд металл илрүүлэх зорилгоор магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэхэд хүнцэл, 6 валенттай хром нь Монгол Улсын MNS 6148:2010 стандартаар заасан газар доорх усанд

агуулагдсан бохирдуулагч бодисын хэмжээнээс тус тус хэтэрсэн байгааг тогтоосон байна.

Тус шилний үйлдвэрийн бохирдсон талбайг цэвэрлэх, үйлдвэрт ашиглагдаж байсан ашиглалтын шаардлага хангахгүй ил задгай хадгалагдаж байсан 56 тонн химийн хаягдал бодисыг 202 саванд савлаж, агуулах зооринд хадгалж байна.<sup>126</sup>

Түүнчлэн Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулиудад зориулалтын бус химийн танхимд хадгалж байгаа бодис нь ууршиж хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдээд байсныг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай ангийн хашаанд Мөнгөн усны төслийн санхүүжилтээр баригдсан химийн бодисын зориулалтын агуулахад нэгтгэн түр хадгалж байна.<sup>127</sup>

Энэ нь Монгол Улсын хэмжээнд хугацаа дууссан, ашиглалтын шаардлага хангаагүй химийн бодис, аюултай хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар устгах үйлдвэргүй, стандартын шаардлагад нийцсэн зориулалтын хадгалах агуулах, байгууламж байхгүйтэй шууд холбоотой юм. Монгол Улсад хорт хог хаягдал булах газар, эсхүл шатаах үйлдвэр бий болж, хангалттай санхүүгийн эх үүсвэртэй болсон нөхцөлд тухайн агуулах зооринд хадгалагдаж буй шинээр савласан болон савлаагүй хорт болон аюултай бодис, хог хаягдлыг бүрмөсөн зайлуулж, устгах боломжтой юм.<sup>128</sup>

<sup>126</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 02/429 дугаар албан бичиг.

<sup>127</sup> Онцгой байдлын ерөнхий газрын 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 6/441 дугаар албан бичиг.

<sup>128</sup> “Деканто” ХХК-ийн Налайхын талбайн бохирдлын гол эх үүсвэрийг арилгах-Налайхын талбайд хэрэгжүүлсэн цэвэрлэгээний ажлын тайлангийн дүгнэлт, 2018 оны 10 дугаар сар.



Дээрхээс үзэхэд Монгол Улсын хэмжээнд хэрэглэгдэж буй химийн хорт болон аюултай бодисын тоо хэмжээ маш их байх бөгөөд химийн бодисыг шинж чанар болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөгөөр нь ангилж буй байдал хангалтгүй, тус бодисыг хадгалах стандартын шаардлага хангасан агуулах, устгах үйлдвэр огт байхгүй байна.

Үүнээс үүдэн химийн хорт болон аюултай бодис алдагдах тохиолдолд хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлсний уршигаар хүн ам үй олноороо амь насаа алдах, аюултай өвчин, эмгэг үүсэх, тархах, хүний удамшилд нөлөөлөх эрсдэл тулгараад байна. Түүнчлэн мал аж ахуй, ан амьтанд учрах хор уршгийг урьдчилан тооцоолох аргагүй юм.

Иймд хугацаа нь дууссан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, удаан хугацаанд хадгалагдсан химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, хамгаалах, зайлуулах, устгах асуудалд төрийн зүгээс онцгой анхаарал хандуулж, яаралтай арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна.



# IV

БҮЛЭГ

## **ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ИНДЕКС БА МОНГОЛ УЛСЫН ЭЗЛЭХ БАЙР**

*“Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой.”*

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1 дүгээр зүйл)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1948 онд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталснаас хойш өнөөг хүртэл олон улсын хамтын нийгэмлэг болон хүний эрхийн олон улсын бусад механизм нь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлыг олон улсын хэмжээнд эрх зүйн хувьд сайжруулах, баталгааг хангахаар хүчин чармайлт гаргасаар байна. Гишүүн улсууд ч бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн хэм хэмжээ, стандартад хууль тогтоомжоо нийцүүлж, үндэстний хэмжээнд хэрэгжүүлэх чиглэлд гэрээ, конвенцод нэгдэн орох, хууль батлах зэргээр бодит алхам хийж ирсэн билээ.

Улс бүрийн хүний эрхийн нөхцөл байдалд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний хороод, тусгай илтгэгчид тус тусын хариуцсан хүний эрхийн чиглэлээр үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гаргахын зэрэгцээ олон улсын байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны төвүүд тодорхой шалгуураар мэдээлэл цуглуулан, үнэлж оноо өгөх, индексжүүлэн эрэмбэлэх зэргээр хүний эрхийн олон улсын индексийг жил бүр гаргадаг уламжлал тогтжээ. Эдгээр нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизмуудын зэрэгцээ аливаа улс орны хүний эрхийн хэрэгжилтийг үнэлэх нийтэд хандсан мэдээллийн чухал эх сурвалж болон хөгжиж байна.

Монгол Улсын хувьд 2010, 2015 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн хоёр циклээр хүний эрхийн төлөв байдлаа үнэлүүлж, зөвлөмжийн дагуу хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулахаар ажиллаж байгаа боловч үндэстний хэмжээнд хүний эрхийн нөхцөл байдлаа үнэлж, индексжүүлсэн мэдээлэл гаргах аргачлалгүй байна.

Иймд Комисс энэ илтгэлдээ олон улсын мэргэшсэн байгууллагууд тодорхой шалгуураар оноо, хувь өгөх замаар улс орныг эрэмбэлдэг тайлан мэдээлэлд тулгуурлан хүний эрхийн чиглэлээр олон улсад Монгол Улсын эзэлж буй эрэмбийг тусгахыг зорилоо.

Олон улсын мэргэшсэн байгууллага, хөтөлбөрүүд улс орнууд дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлыг индексэд оруулахдаа тус тусын мэргэшсэн салбарын хүрээнд томьёолж, өөрийн онцлог аргачлалаар гаргадаг тул Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлыг Үндсэн хуульд томьёолсон бүх эрх, эрх чөлөөний хүрээнд харуулах боломжгүй юм. Иймд энэхүү бүлэгт Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, мөн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээ, судалгааны болон мэргэшсэн байгууллагаас гаргасан зарим голлох индексийн хүрээнд Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлыг харуулав. Үүнд:

- **Эрх зүйт ёсны индекс.** “Дэлхийн шударга ёсны төсөл” олон улсын иргэний нийгмийн байгууллага (World Justice Project)-аас Эрх зүйт ёсны индекс (Rule of Law Index)-ийг гаргахдаа хууль сахиулах, шүүх тогтолцооны шударга, хараат бус байдлыг 1 хүртэл оноогоор үнэлж эрэмбэлдэг байна. Энэ индексийн хүрээнд шударга шүүхээр шүүлгэх, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн төлөв байдлыг харууллаа.
- **Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс.** “Хил хязгааргүй сэтгүүлчид” төрийн бус байгууллага нь үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийн төлөв байдлыг<sup>129</sup> 100 хүртэлх оноогоор үнэлдэг бөгөөд аливаа улс орны индексийн үзүүлэлт 100 оноо руу

<sup>129</sup> Бүгд Найрамдах Франц Улсад төвтэй ашгийн төлөв бус “Хил хязгааргүй сэтгүүлчид” төрийн бус байгууллага нь 2002 оноос хойш жил тутам Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексийг гаргаж байна.

дөхөх тусам уг хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал хангалтгүй болохыг илтгэдэг ажээ.

- **Хэвлэлийн эрх чөлөөний индекс.** "Фрийдом Хаус" (Freedom House) төрийн бус байгууллагаас гаргадаг Хэвлэлийн эрх чөлөөний тайланд хэвлэлийн эрх чөлөөний статусыг үнэлдэг бөгөөд "Хил хязгааргүй сэтгүүлчид" төрийн бус байгууллагаас гаргадаг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексийн хамтаар хэвлэн нийтлэх эрхийн хэрэгжилтийг харуулдаг байна.
- **Дэлхийн боолчлолын индекс.** "Эрх чөлөөт алхам" сангаас (Walk Free Foundation) хоёр жил тутам Дэлхийн боолчлолын индекс (Global Slavery Index)-ийг гаргадаг юм. Уг индексийн үзүүлэлтээр Монгол Улс дахь халдашгүй чөлөөтэй байх эрхийн хүрээнд боолчлолоос ангид байх эрхийн төлөв байдлыг харуулахыг зорив.
- **Боловсролын индекс.** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс гаргадаг Хүний хөгжлийн тайланд 2010 оноос эхлэн жил бүр Хүний хөгжлийн индексийн хүрээнд Боловсролын индексийг 1 хүртэл оноогоор тооцож улс улсаар гаргах болсон бөгөөд боловсролын тэгш байдлын индексийн хамтаар сурч боловсрох эрхийг үнэлэх нэг хэмжүүр болж байна. Хүний хөгжлийн индексийн хүрээнд гаргадаг энэ үнэлгээг тэгш бус байдлыг үнэлдэг Аткинсоны индексийн аргачлалаар боловсруулдаг юм.
- **Хүрээлэн буй орчны үзүүлэлтийн индекс.** Америкийн Нэгдсэн Улсын Йелийн их сургууль болон Колумбын их сургуулиас Дэлхийн эдийн засгийн Форумтой хамтран Хүрээлэн буй орчны үзүүлэлтийн индексийг жил тутам гаргадаг бөгөөд Монгол Улсын талаарх

уг индексийн мэдээллээр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн төлөв байдлыг харуулахыг зорив.

- **Жендэрийн индекс.** Уг индексийг Дэлхийн эдийн засгийн форумгаас гаргадаг дэлхий нийтийн жендэрийн ялгаатай байдлын индекс, Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс гаргадаг Хүний хөгжлийн индексийн хүрээн дэх жендэрийн хөгжлийн индекс болон жендэрийн тэгш бус байдлын индексийн хамтаар жендэрийн тэгш байдлын хэрэгжилтийн байдлыг илэрхийлж байна.
- **Тогтвортой хөгжлийн зорилгын индекс.** Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ (Sustainable Development Solutions Network) болон Бертелсмэн Сан (Berthelmann Stiftung)–гаас 2016 оноос эхлэн жил бүр гаргаж буй Тогтвортой хөгжлийн тайланд 2019 онд тогтвортой хөгжлийн зорилгын индексийг танилцуулж эхэлсэн нь тогтвортой хөгжлийн хүрээн дэх хүний эрхийн төлөв байдлыг илтгэх нэн чухал үзүүлэлт болсон байна.

Дээр дурдсан олон улсын индекс нь Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний магадлан итгэмжилсэн олон улсын төрийн бус байгууллага, Засгийн газар хоорондын бусад байгууллага зэрэг баталгаатай эх сурвалжаас мэдээлэл цуглуулахын зэрэгцээ тухайн улс орны төрийн байгууллага, судалгааны бусад эх сурвалж зэрэг олон талын мэдээллийг ашиглаж гаргасан байдгаараа онцлогтой юм.

Эдгээрээс гадна олон улсын судалгаа шинжилгээний байгууллага, их сургуулиудаас гаргадаг өөр индексүүд байх боловч тэдгээр нь тухайн индексийг гаргахдаа хэрэглэсэн мэдээлэл, эх сурвалжаа нээлттэй тавьдаггүй тул энэхүү илтгэлд дурдаагүй болно.



#### 4.1. Шударга шүүхээр шүүлгэх болон хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрх

*“Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль,  
шүүхийн өмнө эрх тэгш байна.”*

(Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

*“Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө  
нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар ...шударга  
шүүхээр шүүлгэх, ...эрхтэй.”*

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт)

*“Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүй  
хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй”*

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйл)

*“Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ  
тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил  
тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”*


(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

*“Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүрт өөрт  
нь тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний  
нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу  
байгуулагдсан, эрх мэдэл бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр  
нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”*

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр  
зүйлийн 1 дэх хэсэг)

Олон улсын гэрээ болон дотоодын хууль тогтоомжийн хүрээнд дээрх эрхийг бүрэн хангахаар төр иргэдийнхээ өмнө үүрэг хүлээж баталгаажуулсан боловч судлаачдын гаргаж байгаа зарим индекс үзүүлэлтээр хангалттай бус гэж үнэлэгдсэн байна. Тухайлбал дэлхий даяар эрх зүйт ёсыг хөгжүүлэх зорилготойгоор 2006 онд Америкийн Нэгдсэн Улсын хуульчдын холбооны ерөнхийлөгч Уильям Хорлик Нейкомын санаачлан үүсгэн байгуулсан "Дэлхийн шударга ёсны төсөл" (World Justice Project) олон улсын иргэний нийгмийн байгууллагаас эрхлэн гаргадаг Эрх зүйт ёсны индекс (Rule of Law Index)–ээр улс орнуудыг 1 хүртэлх оноогоор дүгнэж, эрэмбэ олгодог юм. **Монгол Улсын хувьд уг үзүүлэлтэд 2019 онд нэгдсэн дүнгээр 0.55 оноо авч, 126 орноос 53 дугаарт эрэмбэлэгджээ.**


Бүдүүвч 4.1 Эрх зүйт ёсны индексээр Монгол Улс болон хамгийн өндөр оноо авсан улсуудын харьцуулалт (нэгдсэн дүнгээр)



Шударга шүүхээр шүүлгэх болон хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн хэрэгжилттэй холбогдуулан Эрх зүйт ёсны индексийн үндсэн болон дэд шалгуур үзүүлэлтүүдийг авч үзвэл **Монгол Улс нь Иргэний шүүхийн шударга**

байдлын<sup>130</sup> (Civil Justice) хувьд 0.54 оноо, Эрүүгийн шүүхийн шударга байдлын<sup>131</sup> хувьд (Criminal justice) 0.5 оноо авсан байна.<sup>132</sup>

Бүдүүвч 4.2 Монгол Улсын эрх зүйт ёсны индексийн зарим шалгуур үзүүлэлтээр авсан онооны харьцуулалт



<sup>130</sup> Эрх зүйт ёсны индекс 2019, "Дэлхийн шударга ёсны төсөл" олон улсын иргэний нийгмийн байгууллага, 28 дахь тал. "Уг шалгуур үзүүлэлт нь энгийн иргэд өөрсдийн гомдлыг иргэний шударга шүүхийн тогтолцоогоор тайван, үр дүнтэйгээр шийдвэрлэх боломжтой эсэхийг тодорхойлдог. Тодруулбал, иргэний шударга шүүхийн тогтолцоо нь хүртээмжтэй байхаас гадна төрийн албан хаагчид ялгаварлан гадуурхах хандлага, авлига, зүй бус нөлөөллөөс ангид байгаа эсэхийг шалгадаг. Мөн шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр саатуулсан эсэх, шүүхийн шийдвэр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх болон маргааныг шийдвэрлэх бусад хувилбаруудын хүртээмж, шударга байдал, үр ашгийг хэмжинэ."

<sup>131</sup> Эрх зүйт ёсны индекс 2019, "Дэлхийн шударга ёсны төсөл" олон улсын иргэний нийгмийн байгууллага, 29 дэх тал. Үр нөлөө бүхий эрүүгийн шударга шүүхийн тогтолцоо нь гомдлыг барагдуулах болон нийгмийн эсрэг гэмт үйлдэл үйлдсэн хувь хүнд тохирох хариуцлага хүлээлгэх нийтлэг механизм болохын хувьд эрх зүйт ёсны гол бүрэлдэхүүн хэсэг юм. Уг шалгуур үзүүлэлтээр цагдаа, хуульч, прокурор, шүүгчид болон хорих байгууллагын ажилтны үйл ажиллагаа зэрэг бүхий л тогтолцоог хамруулдаг байна. "

<sup>132</sup> Эрх зүйт ёсны индекс 2019, "Дэлхийн шударга ёсны төсөл" олон улсын иргэний нийгмийн байгууллага, 28-29 дэх тал.

Мөн Шүүх байгууллагын авлигагүй байдал<sup>133</sup> (Absence of Corruption in the Judiciary) шалгуур үзүүлэлтээр 0.51 оноо авсан бол Хууль тогтоох байгууллагын авлигагүй байдал<sup>134</sup> (Absence of Corruption in the Legislature) шалгуур үзүүлэлтээр дөнгөж 0.17 оноо авсан байна.

#### 4.2. Хэвлэн нийтлэх эрх чөлөө

*“...хэвлэн нийтлэх...эрх чөлөөтэй байна.”*

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт)

*“Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”*

(Иргэний болон улс төрийн эрхийн талаарх олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг)

Хууль тогтоомжоор баталгаажсан хэвлэн нийтлэх эрх чөлөө нь бодитой хангагдсан эсэх, түүнчлэн уг эрхэд суурилан ажил үүргээ гүйцэтгэж байгаа сэтгүүлчдийн нөхцөл байдлыг тодорхойлох төрөл бүрийн индекс үзүүлэлтүүд

<sup>133</sup> Эрх зүйт ёсны индекс 2019, "Дэлхийн шударга ёсны төсөл" олон улсын иргэний нийгмийн байгууллага, 11 дэх тал. "Авлигагүй шүүхийн байгууллага буюу шүүхийн салбар дахь албан хаагчид төрийн албыг хувийн ашиг сонирхолд ашигладаггүй байх асуудалтай хамаарал бүхий уг дэд шалгуур үзүүлэлтээр шүүгч, шүүхийн ажилтнууд хээл хахуулиас ангид байгаа эсэх болон төр, хувийн байгууллагуудын ашиг сонирхол, гэмт хэргийн бүлэглэлийн зохисгүй нөлөөллөөс шүүх засаглал, шүүхийн шийдвэр ангид байгаа эсэхийг тодорхойлдог."

<sup>134</sup> Эрх зүйт ёсны индекс 2019, "Дэлхийн шударга ёсны төсөл" олон улсын иргэний нийгмийн байгууллага, 28 дэх тал. "Авлигагүй хууль тогтоох байгууллага буюу хууль тогтоох байгууллага дахь албан хаагчид төрийн албыг хувийн ашиг сонирхолд ашигладаггүй байх асуудалтай хамаарал бүхий уг дэд шалгуур үзүүлэлтээр парламентын гишүүд улс төрийн ашиг сонирхол болон хууль тогтоомжид зэрэг санал өгснийхөө хариуд хээл хахууль авдаг эсэхийг тодорхойлдог."

гардаг байна. Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс (World Press Freedom Index)-ийг Франц Улсад 1985 онд үүсгэн байгуулагдсан “Хил хязгааргүй сэтгүүлчид” ашгийн төлөө бус төрийн бус байгууллагаас эрхлэн гаргадаг бөгөөд уг байгууллага нь “Интернет дэх мэдээллийн цензур болон хэвлэл мэдээллийн шинэ төрөл дээр анхаарал хандуулах”, “Аюул бүхий бүс нутагт ажиллаж буй сэтгүүлчдэд эд материал, мөнгө санхүү, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн үйл ажиллагааны үндсэн хоёр хүрээтэй ажиллаж байна.


Түүнчлэн “Хил хязгааргүй сэтгүүлчид” төрийн бус байгууллага нь эрх чөлөөтэй, бие даасан, олон ургальч сэтгүүл зүйг дэмжих, хэвлэл мэдээллийн ажилтуудыг хамгаалах чиг үүрэгтэйн хувьд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Европын зөвлөл, Франц хэлтнүүдийн олон улсын байгууллага зэрэгт зөвлөх статустай юм.

Тэд 2002 оноос хойш жил бүр Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр 180 орны нөхцөл байдлыг үнэлж байна. 2019 оны байдлаар Норвеги (7.82 оноотойгоор 1 дүгээр байрт), Финлянд (7.9 оноотойгоор 2 дугаар байрт), Швед (8.31 оноотойгоор 3 дугаар байрт) зэрэг улсууд уг индексийг тэргүүлсэн бол **Монгол Улс 29.51 оноотойгоор 70 дугаар байрт** орсноор өмнөх жилээс нэг л байраар урагшилжээ.<sup>135</sup>

<sup>135</sup> <https://rsf.org/en/ranking>

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,  
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19 ДЭХ ИЛТГЭЛ

Бүдүүвч 4.3 Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр  
Монгол Улс болон хамгийн өндөр авсан улсуудын  
харьцуулалт<sup>136</sup>



Уг индексийг боловсруулахдаа “Хил хязгааргүй сэтгүүлчид” төрийн бус байгууллагын санал асуулгад өгсөн экспертүүдийн хариултад тулгуурлан улс орнууд дахь сэтгүүлчдийн эрх чөлөөний байдалд хийсэн чанарын шинжилгээний дүнг сэтгүүлчдийн эсрэг үйлдсэн хүчирхийллийн тоон мэдээтэй нэгтгэдэг байна.

“Фрийдом Хаус” төрийн бус байгууллагаас гаргасан Хэвлэлийн эрх чөлөөний 2002–2017 он хүртэлх 16 удаагийн тайлангаас харвал Монгол Улс Хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдлын<sup>137</sup> хувьд жил бүр зарим талаараа эрх чөлөөтэй гэж үнэлэгдсэн байна.

2017 оны үнэлгээг нарийвчлан үзвэл Монгол Улсын хууль эрх зүйн орчин 30-аас 13 оноо, улс төрийн орчин 40-өөс 12 оноо, эдийн засгийн орчин 30-аас 12 оноо, нийт

<sup>136</sup> Уг индекс нь 0-оос 100 хүртэлх оноогоор үнэлгээ хийдэг бөгөөд онооны хувьд 0-рүү тэмүүлэх тусам хэвлэн нийтлэх эрх чөлөөний нөхцөл байдал сайн, харин 100-руу ойртох тусам муу байгааг илтгэнэ. (2018 оны байдлаар Монгол Улс 29.05 оноотойгоор 71 дүгээр байрт эрэмбэлэгджээ.)

<sup>137</sup> “Фрийдом Хаус” төрийн бус байгууллагын хэвлэлийн эрх чөлөөний тайланд улс орнуудын хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдлыг эрх чөлөөтэй, зарим талаараа эрх чөлөөтэй, эрх чөлөөгүй гэж 3 ангилан тодорхойлдог байна.

100-аас 37 оноо авч Хэвлэлийн эрх чөлөөний статусын хувьд 215 улсаас 70 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.

#### 4.3. Боолчлол, боолын худалдаанд өртөхгүй байх эрх

*“Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй.  
Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааны бүх төрлийг  
хориглоно.”*

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 4 дүгээр зүйл)

*“Хэнийг ч боол болгож болохгүй; аливаа төрлийн боолчлол болон  
боолын худалдааг хориглоно”*

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 8 дугаар  
зүйлийн 1 дэх хэсэг)

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хэн боловч боолчлолоос ангид байх эрхтэй юм. Тодруулбал Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд<sup>138</sup> мөлжлөгийн аливаа хэлбэрийг, Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд<sup>139</sup> албадан хөдөлмөрийг хориглосон бөгөөд бусдыг боолчилсон этгээдэд Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага оногдуулах<sup>140</sup> дотоодын эрх зүйн орчин бий болсон байна.

<sup>138</sup> Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу “Хүүхэд ...мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй” болно.

<sup>139</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэжээ.

<sup>140</sup> Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан.

Боолчлол нь хувь хүний халдашгүй дархан байх эрхэд эн тэргүүнд заналхийлдэг хүний эрхийн зөрчил юм. Үндэстнүүдийн Холбооноос 1926 онд баталсан “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц”-д “Өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцөлийг...”<sup>141</sup> боолчлол гэж үзсэн бөгөөд Эрүү шүүлтийн тусгай илтгэгч асан Манфред Новак боолчлолыг “өөрийн ижил хүмүүсийн хувийн шинж чанар, нэр төрийг үл тоон шууд халдах замаар илрэлээ олдог хүн төрөлхтний эрх мэдлийн хамгийн ноцтой илэрхийлэл” хэмээн тодорхойлжээ.

Дээрх тодорхойлолтуудаас үзэхэд боолчлол гэдэг нь нийтлэг байдлаар төсөөлж ирсэн хэн нэгний бие махбодын хүчийг өөрийн хүсэл сонирхол, эрх ашигт нийцүүлэн ашиглах төдий ойлголтоос илүү өргөн утга бүхий үзэгдэл бөгөөд одоо ч оршсоор байна. Өөрөөр хэлбэл, боолчлолын хэв маяг, хэлбэр өөрчлөгдөж орчин цагийн боолчлолыг бий болгоод байна.

Боолчлолын эсрэг олон улсын хүний эрхийн байгууллагаас (Anti-Slavery International Human Rights Organisation) орчин цагийн боолчлол гэдэгт албадан хөдөлмөр,<sup>142</sup> өрийн төлөөс болгох,<sup>143</sup> хүн худалдаалах гэмт

<sup>141</sup> <https://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/SlaveryConvention.aspx>

<sup>142</sup> Албадан хөдөлмөр-Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж аливаа этгээдээр гүйцэтгүүлэх, ингэхдээ уг этгээд нь өөрөө сайн дураар гүйцэтгэхийг санал болгоогүй бүх ажил буюу үйлчилгээг” албадан хөдөлмөр гэж тодорхойлжээ.

<sup>143</sup> Өрийн төлөөс болгох – Энэ нь дэлхий даяар хамгийн өргөн тархсан боолчлолын хэлбэр бөгөөд нэр томьёоны хувьд тодорхойлбол “бусдаас мөнгө зээлсэн этгээд буцаан төлөх боломжгүй болж, улмаар өрийн барьцаанд ажиллан, тухайн өртэй хүн өөрийн ажил хөдөлмөр эрхлэлт болон өр зээлээ хянах боломж, чадвараа бүрэн алдах”-ыг хэлнэ. <https://www.antislavery.org/slavery-today/modern-slavery/>



хэрэг,<sup>144</sup> үе дамжсан боолчлол,<sup>145</sup> хүүхдийн боолчлол,<sup>146</sup> албадан болон эрт гэрлэлт<sup>147</sup> зэрэг багтаажээ. Боолчлол, боолын худалдаанд өртөхгүй байх эрхийг хүн бүр эдэлж чадаж буй эсэхийг тодорхойлохоор “Эрх чөлөөт алхам” сангаас<sup>148</sup> хоёр жил тутам Дэлхийн боолчлолын индексийг гаргадаг байна.

Дэлхийн боолчлолын индекс нь үндсэн 3 хэмжигдэхүүнд үнэлгээ өгдөг ажээ. Үүнд:

- Асуудлын хүрээ: Нийт хүн амын дунд тархсан хувь хэмжээ (улс бүрээр)
- Засгийн газрын авч буй хариу арга хэмжээ: Засгийн газар асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар
- Өртөмтгий байдал: Тархалтыг тайлбарлаж болон таамаглаж буй хүчин зүйлүүд хамаарна.

<sup>144</sup> Хүн худалдаалах гэмт хэрэг-Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай мөн өдрийн протоколын 3 дугаар зүйлийн (а) хэсэгт “Хүн худалдаалах гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хүлгалах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олох зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.” гэж заажээ.

<sup>145</sup> Үе дамжсан боолчлол-Боолчлогдсон гэр бүлд төрсөн хэн боловч боол мөн гэх ойлголт юм.

<sup>146</sup> Хүүхдийн боолчлол-Хэн нэгэн ашиг хонжоо олох зорилгоор албадан мөлжих үйл ажиллагааг хэлнэ. Үүнд хүүхдийн хөдөлмөр, хүүхэд худалдаалах гэмт хэрэг, цэрэг хүүхэд, хүүхдийн гэрлэлт зэрэг багтах бөгөөд эцэст нь тэдний боловсрол, хөгжилд маш сөрөг үр дагаврыг бий болгодог.

<sup>147</sup> Албадан гэрлэлт-Гэрлэж байгаа этгээдийн хүсэл зоригоос үл хамаарсан, зайлшгүй шинж бүхий гэрлэлт.

<sup>148</sup> “Эрх чөлөөт алхам” сан нь 2012 онд Австрали Улсад үүсгэн байгуулагдсан бөгөөд тэд орчин цагийн боолчлолыг төгсгөхийн тулд олон талыг мэдээллээр хангах шаардлагатай гэж үзэн, бизнесийн салбарынхан, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд болон засгийн газруудад зориулан дээрх индексийг 2013, 2014, 2016, 2018 онуудад нийт 4 удаа бэлтгэн нийтлээд байна.

Ийнхүү үнэлгээ хийхдээ тухайн улсын иргэд, иргэний нийгмийн байгууллага, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчдыг хамруулдаг бөгөөд орчин цагийн боолчлолд өртөх магадлалыг тооцоход Олон улсын Хөдөлмөрийн байгууллага болон Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран ажилласан байна.<sup>149</sup> Монгол Улсын хувьд 2018 оны байдлаар нийт 1,000 хүн тутамд тархалт 12.29 байгаа бөгөөд нийт 37,000 орчим хүн орчин цагийн боолчлолд өртсөн гэж дүгнэжээ. Мөн өртөмтгий байдлын үнэлгээг хийхэд 100 хүртэлх онооноос 43.55 байгаа нь дунджаас доогуур үзүүлэлт юм.<sup>150</sup>

Харин Засгийн газрын хариу арга хэмжээнд үнэлгээ хийхдээ “AAA, AA, A, BBB, BB, B, CCC, CC, C, D” гэх үнэлгээг өгдөг бөгөөд Монгол Улсын Засгийн газраас орчин цагийн боолчлолын эсрэг авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээнд “CCC” үнэлгээ өгчээ. Уг “CCC” үнэлгээ нь Засгийн газрын хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хязгаарлагдмал байгааг илтгэх бөгөөд хохирогчдод үзүүлэх дэмжлэг, туслалцаа бүхий үйлчилгээ ихэнхдээ олон улсын санхүүжилт бүхий төрийн бус байгууллагуудаар дамжин хүрдэг бөгөөд Засгийн газраас олгож байгаа санхүүжилт хязгаарлагдмал байгааг илэрхийлнэ.<sup>151</sup>

#### 4.4. Сурч боловсрох эрх

*“Сурч боловсрох эрхтэй.”*

(Монгол улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7 дахь заалт)

*“Хүн бүр сурч боловсрох эрхтэй.”*

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг)

<sup>149</sup> Дэлхийн боолчлолын индекс 2018, Эрх чөлөөтэй алхам сан, 8 дахь тал.

<sup>150</sup> <https://www.globallslaveryindex.org/2018/data/country-data/mongolia/>


<sup>151</sup> <https://www.globallslaveryindex.org/2018/methodology/government-response/>

“Энэхүү пактад оролцогч улс хүн бүр сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө.”

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

Монгол Улсын Үндсэн хууль болон Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактад сурч боловсрох эрхийг баталгаажуулсан бөгөөд бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгох тухай заасан билээ. Энэхүү эрх нь улс орнуудад харилцан адилгүй хэрэгжиж иржээ. Иймд Засгийн газар хоорондын болон олон улсын төрийн бус байгууллагууд, судалгааны хүрээлэнгүүд улс орнуудыг харьцуулан судалж, өөр өөрсдийн үнэлгээ гаргаж ирэв. Тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс<sup>152</sup> жил бүр Хүний хөгжлийн индексийг тооцоолж гаргахдаа Боловсролын индексийг ашигладаг байна.

Бүдүүвч 4.4 Монгол Улсын боловсролын индексийн харьцуулалт (1990–2018 оноор)




<sup>152</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр нь 1965 оноос хойш тасралтгүй буурай, хөгжиж буй улс орнуудад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн сүлжээ юм.

Дээрх бүдүүвчээс харвал дэлхий нийтийн боловсролын индекс нь тогтвортой өсөх хандлагатай байна. Монгол Улсын хувьд ч боловсролын индекс нь өсөх хандлагатай байгаа боловч 1990–1993 болон 2015–2016 онд бага зэрэг буурсан байна. 2018 онд хийсэн үнэлгээгээр **Монгол Улсын боловсролын индекс 0.734 гарсан нь** Европ болон дундад Азийн бүс нутгийн дундаж индексээс<sup>153</sup> доогуур түвшинд байна. Дэлхийн боловсролын дундаж индекс 0.633 байгаа бол Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын индексийн дундаж оноо 0.852 байна.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар Монгол Улсын Засгийн газрын зүгээс 2013–2018 онд боловсролын салбарт зарцуулсан хөрөнгийг дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулбал дунджаар 4.1 хувийг боловсролын салбарт зарцуулсан байна. Уг үнэлгээгээр буурай орнууд дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувийг боловсролодоо зарцуулдаг бол Хүний хөгжлийн индексээр тэргүүлдэг улс орнууд 4.9–5.3 хувийг зарцуулж, харин дэлхийн дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүний 4.8 хувийг боловсролд зарцуулдаг тухай тооцоо гаргажээ.

**Бүдүүвч 4.5 Засгийн газраас боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгө хэмжээ (Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, оноор)<sup>154</sup>**



<sup>153</sup> Европ болон Төв Азийн бүс нутгийн 2018 оны дундаж оноо нь 0,743

<sup>154</sup> Дэлхийн банк (2019а). Дэлхийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн мэдээллийн сан, Вашингтон хот, Холбоос: <http://data.worldbank.org> Үнэлгээг 2019 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар хийсэн болно.

Монгол Улсын хувьд боловсролын зардал нь 2000–2018 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 4.2–5.5 хувийг эзэлж байсан бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний таваас дээш хувийн зарцуулалтыг 2000, 2012, 2016 онд хийсэн байна.


Боловсролын байгууллагуудын санхүүжилт, мэргэшсэн туршлагатай багш, ном, сурах бичиг, тусгай хэрэгцээт хүмүүст зориулсан техникийн шийдэл зэрэгт ялгамжтай хуваарилалтыг тэгш бусаар хийхийг боловсролын тэгш бус байдал хэмээн ойлгоно. Боловсролын тэгш бус байдал нь улс бүрт харилцан адилгүй байдгаас гадна тухайн улсын засаг захиргааны нэгжүүдэд (хот, аймаг, сум, дүүрэг) ялгаатай байх нь бий.

Боловсролын салбар дахь тэгш бус байдлын индексийг тооцоолохдоо Аткинсоны индексийг<sup>155</sup> ашигласан бөгөөд Монгол Улсын хувьд 2016–2018 онд тус бүр боловсролын тэгш бус байдлын индекс нь 11.9 гарсан бол дээрх жилүүдэд Хүний хөгжлийн индексээр тэргүүлдэг Норвеги Улсад 5.3, 6.1, 4.4, Швейцарын Холбооны Улсад 2.4, 2.4, 1.9 гэж гарчээ.

---


<sup>155</sup> Их Британи Улсын эдийн засагч Антони Барнес Аткинсон орлогын тэгш бус байдлыг хэмжихээр Аткинсоны индексийг гаргасан байдаг. Тухайн индекс нь тэгш бус байдалд хүргэсэн эцсийн ногдол хуваарилалтыг хэмждэг байна. Оноо бага байх тусам тэгш бус байдал бага байх бөгөөд оноо ихсэх тусам тэгш бус байдал ихэссэн тухай илэрхийлнэ.

Бүдүүвч 4.6 Боловсролын тэгш бус байдлын харьцуулалт



Дэлхийн хэмжээнд боловсролын тэгш бус байдал буурсан ч ядуу буурай орнуудад өндөр хэвээр байна. Харин хүний хөгжлийн индексээр 108-д ордог Узбекистан Улсын хувьд боловсролын тэгш бус байдлын индекс нь 2016 онд 1.3, 2017 онд 0.8, 2018 онд 0.7 гарсан бөгөөд боловсролын тэгш бус байдлыг хамгийн доод үзүүлэлтэд барьж чадсан байна.

Бүдүүвч 4.7 Монгол Улс дахь Боловсролын тэгш бус байдлын индекс (2010–2018 оноор)



Монгол Улсын боловсролын тэгш бус байдлын индексийн үзүүлэлт дэлхийн дундажтай харьцуулбал бага гарсан боловч 2014 оноос хойш өсөх хандлагатай байна.

#### 4.5. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх

*“Эрүүл, аюулгүй орчинд амьдрах ...эрхтэй.”*

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалт)

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Байгаль орчин ба хөгжил сэдэвт олон улсын бага хурлыг 1992 онд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Рио дэ Жанейро хотод зохион байгуулсан бөгөөд тус хурлаас Байгаль орчин ба хөгжлийн тухай Риогийн Тунхаглалыг баталсан юм. Тус хуралд Монгол Улс оролцож, Тунхаглалыг дэмжсэн улс орнуудын тоонд багтжээ.

Америкийн Нэгдсэн Улсын Йелийн их сургууль болон Колумбын их сургуулиас Дэлхийн Эдийн засгийн Форумтой хамтран Хүрээлэн буй орчны үзүүлэлтийн индексийг хоёр жилд нэг удаа гаргадаг байна. 2018 оны Хүрээлэн буй орчны үзүүлэлтийн индекс нь хүрээлэн буй орчны эрүүл ахуй болон экосистемийн амьдрах чадвар зэргийг хамааруулан 10 ангилалд 24 шалгуур үзүүлэлтийг ашиглаж, 180 улсыг хамруулж, оноо өгч эрэмбэлсэн байна. Энэхүү хэмжигдэхүүн нь тухайн улс хүрээлэн буй орчны асуудлаарх тогтвортой бодлоготой болоход хэр ойрхон байгааг харуулдаг юм. Энэхүү индексийг 2018 онд 10 дахь удаагаа гаргасан бөгөөд энэ нь бодлого тодорхойлогч, судлаач, төрийн бус байгууллага болон хэвлэл мэдээллийн төлөөллийн хувьд бодлого, тогтвортой хөгжлийн чиг хандлагыг мэдэхэд найдвартай эх сурвалж болдог ажээ.

2018 оны Хүрээлэн буй орчны үзүүлэлтийн индекс нь 180 улсын хүрээлэн буй орчны үзүүлэлтэд хамгийн

сүүлийн үеийн болон арав орчим жилийн өмнөх мэдээллийг харьцуулан дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг нь тоон үзүүлэлтээр гаргаж эрэмбэлжээ. Өндөр оноо нь нийтийн эрүүл мэнд, байгалийн нөөц баялгийг хамгаалах, эдийн засгийн үйл ажиллагаанаас үүдэн гарч буй хүлэмжийн хийг багасгахад урт хугацаанд анхаарч ажиллаж, ахиц дэвшил гаргаж буйг илтгэдэг байна. Тухайлбал Швейцарын Холбооны Улс нь ихэнх асуудал дээр, ялангуяа агаарын чанар болон цаг уурын өөрчлөлтийн асуудалд ихээхэн анхаардаг тул хүрээлэн буй орчны үзүүлэлтээр хамгийн өндөр оноо авч дэлхийд тэргүүлсэн бол Энэтхэг болон Бангладеш улсууд хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн байна.<sup>156</sup>

Индексийн хувьд доогуур оноо нь тухайн улс нь агаарын чанараа сайжруулах, биологийн төрөл зүйлээ хамгаалах, хүлэмжийн хийг багасгах замаар олон асуудлыг үндэсний хэмжээнд тогтвортой байдлаар шийдвэрлэх шаардлагатайг илтгэн харуулж байна. Уг үзүүлэлтээр ард хоцорч буй зарим улс орнууд янз бүрийн сорилт бэрхшээлтэй тулгарч байна. Жишээлбэл зарим улсын хувьд тогтворгүй байдал, сул засаглал нь хүрээлэн буй орчны үзүүлэлтээр доогуур оноо авахад нөлөөлж байна. Монгол Улс 57.51 оноо авч дэлхийн 180 орноос 83 дугаар байрт, Ази тивийн 26 орноос 9 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна.<sup>157</sup>

<sup>156</sup> Йелийн их сургуулийн Байгаль орчны хууль болон бодлогын Йелийн төв болон Колумбын их сургуулийн Олон улсын хөрст дэлхийн шинжлэх ухааны мэдээллийн сүлжээний төв, 2018 оны Хүрээлэн буй орчны индекс, Хүрээлэн буй орчны глобал хэмжигдэхүүн: Эн тэргүүлэх чиглэлийн хүрээлэн буй орчны асуудлаарх улс орнуудын үзүүлэлтийг эрэмбэлэх нь, vi дахь тал.

<sup>157</sup> Йелийн их сургуулийн Байгаль орчны хууль болон бодлогын Йелийн төв болон Колумбын их сургуулийн Олон улсын хөрст дэлхийн шинжлэх ухааны мэдээллийн сүлжээний төв, 2018 оны Хүрээлэн буй орчны индекс, Хүрээлэн буй орчны глобал хэмжигдэхүүн: Эн тэргүүлэх чиглэлийн хүрээлэн буй орчны асуудлаарх улс орнуудын үзүүлэлтийг эрэмбэлэх нь, vii дахь тал.



Хүснэгт 4.1 Хүрээлэн буй орчны үзүүлэлтийн индексээр  
Монгол Улс болон хамгийн өндөр, хамгийн бага оноо  
авсан улсуудын харьцуулалт

Улсын нэр	Эрэмбэ	Индекс	Хүрээлэн буй орчны эрүүл ахуй	Экосистемийн амьдрах чадвар
Швейцарь Улс <sup>158</sup>	1	87.42	93.57	83.32
Франц Улс <sup>159</sup>	2	83.95	95.71	76.11
Дани Улс <sup>160</sup>	3	81.6	98.2	70.53
Монгол Улс <sup>161</sup>	83	57.51	61.97	54.54
Балба Улс <sup>162</sup>	176	31.44	10.54	45.38
Энэтхэг Улс <sup>163</sup>	177	30.57	9.32	44.74
Бангладеш Улс <sup>164</sup>	179	29,56	11,96	41,29

Хүснэгт 4.2 Монгол Улсын хүрээлэн буй орчны индексийн  
дэлгэрэнгүй үзүүлэлт (2018 он)

Монгол Улс <sup>165</sup>	Одоо байгаа эрэмбэ	Одоо байгаа оноо	Суурь эрэмбэ	Суурь оноо
Хүрээлэн буй орчны индекс	83	57.51	94	52.83
Хүрээлэн буй орчны эрүүл ахуй	94	61.97	97	58.69
Агаарын чанар	104	64.3	121	60.82
Ундны ус ба ахуйн ариун цэвэр	65	60.54	58	59.1
Хүнд металл буюу хар тугалгад өртөмтгий байдал	118	40.31	149	28.46

<sup>158</sup> Хүрээлэн буй орчны индекс, Швейцарь Улсын оноо, эрэмбийн задаргаа. <https://epi.envirocenter.yale.edu/epi-country-report/CH>

<sup>159</sup> Хүрээлэн буй орчны индекс, Франц Улсын оноо, эрэмбийн задаргаа. <https://epi.envirocenter.yale.edu/epi-country-report/FR>

<sup>160</sup> Хүрээлэн буй орчны индекс, Дани Улсын оноо, эрэмбийн задаргаа. <https://epi.envirocenter.yale.edu/epi-country-report/DN>

<sup>161</sup> Хүрээлэн буй орчны индекс, Монгол Улсын оноо, эрэмбийн задаргаа. <https://epi.envirocenter.yale.edu/epi-country-report/MNG>

<sup>162</sup> Хүрээлэн буй орчны индекс, Балба Улсын оноо, эрэмбийн задаргаа. <https://epi.envirocenter.yale.edu/epi-country-report/NPL>

<sup>163</sup> Хүрээлэн буй орчны индекс, Энэтхэг Улсын оноо, эрэмбийн задаргаа. <https://epi.envirocenter.yale.edu/epi-country-report/IND>

<sup>164</sup> Хүрээлэн буй орчны индекс, Бангладеш Улсын оноо, эрэмбийн задаргаа. <https://epi.envirocenter.yale.edu/epi-country-report/BGD>

<sup>165</sup> Хүрээлэн буй орчны индекс, Монгол Улсын оноо, эрэмбийн задаргаа. <https://epi.envirocenter.yale.edu/epi-country-report/MNG>

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,  
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19 ДЭХ ИЛТГЭЛ

Экосистемийн амьдрах чөдвэр	84	54.54	99	48.93
Биологийн төрөл зүйл ба төрөлх нутаг	90	75.28	97	65.68
Ой мод устаж буй байдал	48	28.94	138	9.74
Цаг уурын өөрчлөлт ба эрчим хүч	74	53.98	70	50.72
Агаарын бохирдол	115	41.66	101	44.07
Усны нөөц болон бохир ус	101	63	101	63
Газар тариалан буюу азотын тогтвортой менежмент	145	14.35	145	14.35

#### 4.6. Жендэрийн индекс

*“Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй.”*

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалт)

*“Энэхүү Пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцөлийг хангах үүрэгтэй.”*

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 3 дугаар)


Дэлхийн эдийн засгийн форумаас 2006 оноос хойш хүйсийн ялгаатай байдлын индексийг тооцож, эрүүл мэнд, боловсрол, эдийн засаг болон улс төрийн индексийг тус тус тооцож эдгээр салбарууд дахь жендэрийн ялгаатай байдлыг харуулдаг билээ. Энэхүү индексээр аль болох олон улс орныг хамруулахыг хичээдэг ч нийт 14 шалгуур үзүүлэлтээс хамгийн багадаа 12 үзүүлэлтийн мэдээлэлтэй орнуудыг үнэлгээнд оруулж, индексийг нь тооцоолдог ажээ. 2020 оны хувьд жендэрийн ялгаатай байдлыг үнэлсэн орны тоо нэмэгдсэн бөгөөд нийт 153 улсыг хамруулжээ. Эдгээр 153 орноос 107 орныг 2006 оноос хойш үнэлгээнд жил бүр оруулж ирсэн байна.

Монгол Улс 2018 онд нийт 149 орноос 0.714 оноотойгоор 58 дугаар байрт жагсаж байсан бол 2020 оны тайланд 0.706 оноо авч 79 дүгээр байрт жагсаж 21 байраар ухарсан үзүүлэлттэй байна. Онооны хувьд 0 нь хүйсийн тэгш бус байдлыг илэрхийлэх ба 1 нь хүйсийн тэгш байдлыг илэрхийлдэг ажээ.

Хүснэгт 4.3 Монгол Улсын үзүүлэлтийг хүйсийн ялгаатай байдлын индексийн 4 дэд индексээр гаргасан байдал

Дэд индекс	Монгол Улсын эрэмбэ	Оноо
Эдийн засгийн оролцоон дахь жендэрийн ялгаатай байдлын индекс	153 орноос 29-д	0.751
Боловсролын амжилтын жендэрийн ялгаатай байдлын индекс	153 орноос 71-д	0.993
Эрүүл мэнд болон амьдрах чадварын индекс	153 орноос 1-д (39 орны хамт)	0.98
Улс төрийн эрх мэдэлжүүлэлтийн индекс	153 орноос 120-д	0.102

Бүдүүвч 4.8 Хүйсийн ялгаатай байдлын индексийн харьцуулалт (Зүүн Ази болон Номхон далайн бус нутгийн улсуудаар)



Өнөөдрийн байдлаар хүйсийн тэнцвэртэй байдал бүрэн хангасан улс байхгүй байгаа ч уг тэнцвэрийг Исланд Улс 82 хувиар хангаж, жагсаалтыг тэргүүлж байна. Хүйсийн ялгаатай байдлыг арилгахаар тэргүүлж яваа 10 орноос дөрөв нь Скандинавын хойгийн Исланд, Норвеги, Финлянд, Швед улсууд байна. Харин Зүүн Ази–Номхон Далайн бүс нутгаас Шинэ Зеланд зургадугаар байрт жагсжээ. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас<sup>166</sup> нийгмийн байгуулал болон жендэрийн индексийг гаргадаг бөгөөд гэр бүлийн хүрээн дэх ялгаварлан гадуурхалт, бие махбодын халдашгүй байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүртээмж, иргэний эрх чөлөө гэсэн дөрвөн хэмжигдэхүүнийг авч үздэг байна.

Тус байгууллага 2019 оны тайландаа<sup>167</sup> нийт 120 улсын үзүүлэлтийг үнэлсэн бөгөөд үүнээс ялгаварлан гадуурхалт маш бага буюу нийгмийн байгуулал болон жендэрийн индекс нь 20 хувиас доош үзүүлэлттэй 33 улс, ялгаварлан гадуурхалт бага буюу уг индекс нь 20–30 хувийн үзүүлэлттэй 42 улс энэ ангилалд багтсаны дунд Армен, Азербайжан, Беларусь, Гүрж, Казахстан, Киргиз, Молдав, Монгол болон Украин зэрэг улсууд оржээ.

Ялгаварлан гадуурхалт дундаж хэмжээтэй буюу нийгмийн байгуулал болон жендэрийн индекс нь 30–40 хувийн үзүүлэлттэй 16 улс, ялгаварлан гадуурхалт өндөртэй буюу нийгмийн байгуулал болон жендэрийн индекс нь 40–50 хувьтай 17 улс, мөн ялгаварлан гадуурхалт маш өндөр буюу нийгмийн байгуулал болон жендэрийн индекс нь 50 хувиас дээш үзүүлэлттэй 12 улсыг тодорхойлжээ.

<sup>166</sup> <http://www.oecd.org/about/history/#d.en.194377>

<sup>167</sup> <https://www.oecd-ilibrary.org/sites/f6dfa21d-en/1/2/1/index.html?itemId=/content/publication/f6dfa21d-en&csp=f990744037b57ab8751f9fa409f1dbf5&itemID=oeecd&itemContentType=book>

Монгол Улсын нийгмийн байгуулал болон жендэрийн индексийн оноо нь 20 хувь бөгөөд Ази Номхон далайн бүс нутагт 3 дугаарт, нийт 120 улсаас 33 дугаарт жагсжээ. Энэ оноо нь дээрх 4 хэмжигдэхүүний нийлбэр дундаж<sup>168</sup> бөгөөд Монгол Улс хэмжигдэхүүн тус бүрээр дараах зураглалтай гарсан байна. Үүнд:

- гэр бүлийн хүрээн дэх ялгаварлан гадуурхалт–27.8 хувь;
- бие махбодын халдашгүй байдал–8.1 хувь;
- санхүүгийн эх үүсвэрийн хүртээмж–20.1 хувь;
- иргэний эрх чөлөө–22.9 хувьтай байна.

Жендэрийн хөгжлийн индексийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс жил бүр тооцоолон гаргадаг бөгөөд Хүний хөгжлийн индексийг эмэгтэй болон эрэгтэй хүйсээр нь гаргасан үзүүлэлтийн харьцаа юм. Энэ нь хүйсийн тэгш бус байдлыг хүн амын дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ноогдох орлогын хэмжээ гэсэн гурван үзүүлэлтээр илэрхийлдэг индекс юм. Уг индексийг хүний хөгжлийн индексээс тусад нь авч үздэггүй бөгөөд Жендэрийн хөгжлийн индексийг заавал Хүний хөгжлийн индексийн хамт авч үзэх шаардлагатай байдаг ажээ.

Жендэрийн хөгжлийн индексээр улс орнуудыг нийт 5 бүлэгт ангилдаг бөгөөд 1 дүгээр бүлэг нь жендэрийн тэнцвэрт байдлыг хамгийн сайн хангаж буй орнууд байдаг бол 5 дугаар бүлэг нь жендэрийн тэнцвэрийг хамгийн муу хангаж буй орнууд байна. Монгол Улс 2018 оны байдлаар эмэгтэй хүйсийн Хүний хөгжлийн индексээр нь 0.7457, эрэгтэй хүйсийн Хүний хөгжлийн индексээр 0.7236 оноотой харин жендэрийн хөгжлийн индекс нь 1,031 оноотой Катар Улсын дараа буюу хоёрдугаар бүлгийн 2 дугаар байрт оржээ.

<sup>168</sup> <https://www.genderindex.org/ranking/?region=asia>

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,  
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 19 ДЭХ ИЛТГЭЛ

Жендэрийн хөгжлийн индекс нь эмэгтэйчүүд эрчүүдээс хэрхэн хоцорч буйг илтгэдэг бөгөөд энэхүү индекс нь шийдвэр гаргах түвшинд, бодлого төлөвлөлтөд онц ач холбогдолтойгоос гадна Хүний хөгжлийн индексийн үзүүлэлт тус бүр хүйсийн ангиллаар гардаг тул юунд анхаарах ёстойг харах боломжтой юм.

Бүдүүвч 4.9 Монгол Улсын Жендэрийн хөгжлийн индексийг дэлхийн болон зарим бүс нутгийн дундаж индексстэй харьцуулсан байдал (2016–2018 оноор)



Жендэрийн тэгш бус байдлын индекс нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, чадалжуулалт болон хөдөлмөрийн зах зээл дэх тэгш бус байдлыг нарийвчлан

тооцсон үзүүлэлт юм. Монгол Улсын жендэрийн тэгш бус байдлын индекс нь 2019 оны байдлаар 0.322 оноотойгоор нийт 189 улсаас 71 дүгээрт эрэмбэлэгдсэн бол дэлхийн дундаж индекс нь 0.439, Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн хувьд 0.310, Европ, төв Азийн индекс нь 0.276, харин уг индексээр тэргүүлж яваа Швейцарын Холбооны Улсын индекс 0.037 гарчээ. Энэхүү индексийн үзүүлэлтийг 0-1 оноогоор гаргадаг бөгөөд 0 нь дээрх хэмжигдэхүүнүүдээр хүйсийн тэгш байдлыг бүрэн хангасан гэж үзвэл 1 оноо нь аль нэг хүйс давамгайл байгааг харуулж байгаа билээ.<sup>169</sup>

Монгол Улсын Жендэрийн тэгш бус байдлын индексийг задалж үзвэл:

- 100,000 төрөлт тутам дахь эхийн эндэгдлийн тоо-44,
- Өсвөр насны (15-19 нас) 1,000 охин тутмын төрөлтийн тоо-31,
- Парламент дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувь хэмжээ-17.1 хувь
- 25 ба түүнээс дээш насныхны дунд бүрэн дунд боловсролтой эмэгтэйн хувь хэмжээ-91.2 хувь
- 25 ба түүнээс дээш насныхны дунд бүрэн дунд боловсролтой эрэгтэйн хувь хэмжээ-86.3 хувь
- 15 ба түүнээс дээш насныхны хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо-53.3 хувь нь эмэгтэй, 66.7 хувь нь эрэгтэй байна.

#### 4.7. Тогтвортой Хөгжлийн Зорилгын 2019 оны индекс

*Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн*

<sup>169</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Хүний хөгжлийн тайлан, 2019 он.

*салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй.*

(Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын 193 гишүүн улс “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго”-ыг 2015 онд баталж, хүрээлэн буй орчны тогтвортой байдал болон хүн бүрийн нийгэм дэх тэгш оролцооны зарчим дээр тулгуурлаж эдийн засгийн өсөлтөө шийдвэрлэх шаардлагатай болсныг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн юм. Тогтвортой хөгжлийн зорилгыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд улс төрийн манлайлал, өндөр дээд хэмжээний үүрэг амлалт, хүчин чармайлт чухал ач холбогдолтой болно. Монгол Улсын хувьд ч гэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн юм.

Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ болон Бертелсмэн сангийн бие даасан шинжээчдийн баг 2016 оноос хойш жил бүр Тогтвортой хөгжлийн тайлан гаргаж байна. Уг тайланд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улс бүрийн Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгаа, шалгуур үзүүлэлт дэх мэдээлэл нь цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдсөн, мөн 2030 онд хүрэх замын зураглалыг тус тус оруулж байна. Тогтвортой хөгжлийн 2019 оны тайлан<sup>170</sup>-д Тогтвортой хөгжлийн зорилгын индекс, үзүүлэлтийг танилцуулж, зургаан том өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээнд хэрэгжилтийг нь

<sup>170</sup> Бертелсмэн сан болон Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ, Тогтвортой Хөгжлийн Тайлан 2019: Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг амжилттай хэрэгжүүлэх өөрчлөлт, шинэчлэлтүүд, 2019 он. <https://www.sdgindex.org/>



тодорхойлжээ. Мөн дээрх тайланд анх удаа Европын Комиссын Хамтарсан судалгааны төвөөс<sup>171</sup> Тогтвортой хөгжлийн зорилгын индекс болон үзүүлэлтэд аудит хийснийг дурдсан байна.

Өнөө үед дэлхий дахинд Тогтвортой хөгжлийн зорилгын үндсэн мэдээллийг тогтмол цуглуулж чадахгүй байгаа нь учир дутагдалтай болохыг тайланд онцолсон нь Монгол Улсад ч хамааралтай юм. Учир нь үндэсний шалгуур үзүүлэлтийг бүрэн гаргаагүй, зарим мэдээллийг гаргах боломжгүй буюу шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаа бөгөөд хүний эрхэд суурилсан арга зүйгээр ажиллах нь чухал байна. Тухайлбал Монгол Улсын хувьд Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдээс шууд гаргах боломжтой үзүүлэлт 48.5 хувь байгаа бол шууд гаргах боломжгүй үзүүлэлт 51.5 хувь байгааг Үндэсний статистикийн хорооны 2017 оны үнэлгээний тайлангаас харж болно.

Иймд улс орнууд Тогтвортой хөгжлийн зорилгын мэдээллийг цаг хугацаанд нь буюу нэн даруй гаргахын тулд илүү их чармайлт гаргах хэрэгтэй байгааг тус тайланд онцолжээ. Орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан тогтвортой хөгжлийн олон зорилгын хэрэгжилтэд бодит цаг хугацаанд нь мониторинг хийх боломжтой юм.

Тогтвортой хөгжлийн зорилгыг дараах зургаан том өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээнд бүлэглэж хэрэгжүүлж болохыг тус тайланд санал болгожээ. Үүнд:

1. Боловсрол, жендэр болон тэгш бус байдал;
2. Эрүүл мэнд, сайн сайхан байдал болон хүн ам зүй;

<sup>171</sup> Хамтарсан судалгааны төв (The Joint Research Centre) нь Европын Комисст шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр үйлчилгээ үзүүлж, Европын Холбоо бодлого боловсруулахад нь шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөгөө, дэмжлэгийг хараат бус байдлаар өгдөг байна.

3. Нүүрс хүчлээс ангид эрчим хүч ба тогтвортой аж үйлдвэр;
4. Тогтвортой хоол хүнс, газар, ус, далай, тэнгис;
5. Тогтвортой хот суурин, хүн зон;
6. Тогтвортой хөгжлийн төлөөх цахим хувьсгал орно.

Эдгээр өөрчлөлт, шинэчлэлтийг төрийн холбогдох байгууллага, иргэний нийгэм, бизнесийн байгууллага болон бусад талуудтай хамтран хөгжлөөс хэнийг ч үлдээлгүй, хүн болгоны хүний эрхийг дээдлэх зарчмыг баримтлан хэрэгжүүлэх боломжтой юм. Тогтвортой хөгжлийн зорилгын индексийг Дани, Швед, Финлянд улсууд тэргүүлж байгаа хэдий ч бусад улс орны нэгэн адил сорилт, бэрхшээлтэй тулгарсаар байна. Ялангуяа 12 дугаар зорилго (Хариуцлагатай хэрэглээ болон үйлдвэрлэл), 13 дугаар зорилго (Цаг уурын өөрчлөлт), 14 дүгээр зорилго (Далай тэнгисийн нөөцийг хамгаалах), 15 дугаар зорилго (Хуурай газар дээрх амьдрал)-ын хэрэгжилт эдгээр улсад ч сайнгүй байна. Орлого болон баялгийн хуваарилалтын тэгш бус байдал, нийгмийн бүлгүүдийн эрүүл мэнд, боловсролын ялгаатай байдал нь хөгжиж буй болон хөгжингүй улс орнуудад бодлого боловсруулахад сорилт болсон хэвээр байна.

Улс орнууд цаг уурын өөрчлөлт (13 дугаар зорилго) болон биологийн төрөл зүйл, тухайлан усны нөөцийг хамгаалах, хуурай газрын экосистемийг хамгаалах (14 болон 15 дугаар зорилго) асуудлыг шийдвэрлэх дээр маш хангалтгүй оноо авсан байна. Ямар ч улс Далай тэнгисийн нөөцийг хамгаалах (14 дүгээр зорилго) талаар өдий хүртэл амжилт гаргаагүй байна. Монгол Улсын хувьд 14 дүгээр зорилгыг өөрт шууд хамаарахгүй зорилго хэмээн үзэж, хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг гаргахгүй байгаа нь буруу бөгөөд цаашид анхаарах асуудал юм. Монгол

Улс хэдийгээр далайд гарцгүй ч усны нөөцийг хамгаалах, тухайлан гол горхи, булаг шанд, нуур усны нөөцийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх үндэсний шалгуур үзүүлэлтийг гаргах бүрэн боломжтойг энд тэмдэглэж байна.

Хүний эрх, тэр дундаа үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь олон улсад аюултай, эрсдэлт нөхцөлд байна. 16 дугаар зорилго (Энх тайван, шударга ёсыг цогцлоох)-ын хүрээнд хамаарах нэг зорилт болох бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институтийг хэвшүүлэх нь тогтвортой хөгжлийг бий болгох чухал хөшүүрэг болох юм. Дээрх тайланд дурдсан 50 гаруй улсад авлига, хээл хахууль болон хэвлэлийн эрх чөлөөний байдал нь өмнөх жилүүдээс дордсон бөгөөд үүнд дунд болон өндөр орлоготой улс орнууд ч багтаж байна. Ядуурлыг арилгах, тэгш байдлыг бэхжүүлэх нь бодлогын тэргүүлэх чиглэл хэвээр байна.

Тус тайланд дурдсанаар “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго” болон “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” Парисын гэрээний урт хугацааны зорилтуудыг хэрэгжүүлэхэд улс орнуудын төр засгаас гаргаж буй хүчин чармайлтыг дараах гурван түвшинд үнэлсэн байна. Үүнд:

1. тогтвортой хөгжлийг дэмжиж буйгаа илэрхийлсэн төрийн өндөр түвшний мэдэгдэл;
2. стратегитай уялдуулан тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх төрийн үйл ажиллагаа, үйл явц (зохицуулалтын механизм, төсөв, худалдан авалт, хүний нөөцийн удирдлага, мэдээлэл болон аудит);
3. Засгийн газрын стратегийн болон бодлогын агуулга;

Тогтвортой Хөгжлийн 2019 оны тайлан нь Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд хяналт тавих албан ёсны хэрэгсэл биш бөгөөд харин Үндэсний статистикийн хороо болон олон улсын байгууллагуудаас шалгуур үзүүлэлтүүдийг нэг стандартад оруулах, цуглуулах ажилд хувь нэмэр болж байна. Тогтвортой хөгжлийн зорилгын индексээр улс орнууд Тогтвортой Хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлэхэд одоогоор ямар ахиц дэвшилд хүрснийг тоймлон гаргажээ. Энэ жилийн тайланд 162 орныг хамруулсан бөгөөд үүнд Монгол Улс багтжээ. Улс орнууд ямар түвшинд явж байгааг 0–100 оноогоор үнэлсэн бөгөөд 0 оноо нь хамгийн муу, 100 оноо нь хамгийн сайн буюу тухайн зорилгыг амжилттай хэрэгжүүлснийг илтгэнэ.

Харин өмнөх жилүүдэд гаргасан индексийн оноог 2019 оны индексийн оноо, эрэмбэтэй харьцуулах боломжгүй юм. Учир нь энэ жил гаргасан шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалд өөрчлөлт орсон болохыг дээрх тайланд дурдсан байна. Тогтвортой хөгжлийн зорилгын индексээр 2019 онд Монгол Улс нь 64.7 оноотойгоор нийт 162 улсаас 100 дугаар байрт орсон байна.<sup>172</sup>

#### Хүснэгт 4.4 Тогтвортой хөгжлийн зорилгын индекс

Эрэмбэ	Улсын нэр	Оноо
1	Дани Улс	85.2
2	Швед Улс	85
100	Монгол Улс	64.7
161	Чад Улс	42.8
162	Төв Африкийн Бүгд Найрамдах Улс	39.1

<sup>172</sup> Бертелсмэн сан болон Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ, Тогтвортой Хөгжлийн Тайлан 2019: Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг амжилттай хэрэгжүүлэх өөрчлөлт, шинэчлэлтүүд, 21 дэх тал, 2019 он. <https://www.sdgindex.org/>

Хүснэгт 4.5 Зорилго тус бүрт авсан оноо<sup>173</sup>

Зорилго	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
Монгол Улс	95.6	44.5	65.7	97.5	67.1	65.4	55.3	76.1	23.3	73.1	48.2	80.8	64.5	-	72.3	64.6	59.5

Харин улс орнууд 13 дугаар зорилгыг (Цаг уурын өөрчлөлт) болон 15 дугаар зорилгыг (Хуурай газар дээрх амьдрал) хэрэгжүүлэхэд тааруу үзүүлэлттэй буюу сайн хэрэгжүүлж чадахгүй хэвээр байна.

Хүснэгт 4.6 Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын үзүүлэлт<sup>174</sup>

Зорилго	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
Монгол Улс	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■

Тайлбар:

- \* **Ногоон** – сайн, зорилгодоо хүрсэн
- \* **Цэнхэр** – асуудал, сорилт бэрхшээл хэвээр байгаа
- \* **Улбар шар** – асуудал их байгаа
- \* **Ягаан** – асуудал хурцадмал байгаа
- \* **Саарал** – мэдээлэл байхгүй

Эндээс Монгол Улсад 2 (Өлсгөлөнгөөс ангижрах), 3 (Эрүүл мэндийг дэмжих), 6 (Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах), 7 (Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх), 9 (Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх),

<sup>173</sup> Бертелсмэн сан болон Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ, Тогтвортой Хөгжлийн Тайлан 2019: Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг амжилттай хэрэгжүүлэх өөрчлөлт, шинэчлэлтүүд, 71 дэх тал, 2019 он. <https://www.sdindex.org/>

<sup>174</sup> Бертелсмэн сан болон Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ, Тогтвортой Хөгжлийн Тайлан 2019: Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг амжилттай хэрэгжүүлэх өөрчлөлт, шинэчлэлтүүд, 26 дахь тал, 2019 он. <https://www.sdindex.org/>

11 (Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих), 13 (Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах), 16 (Энх тайван, шударга ёсыг цогцлоох) дугаар зорилгууд дээр асуудал, сорилт бэрхшээл их тулгарч байгааг харуулж байна.

Энэ бүлэгт авч үзсэн олон улсын индексүүд нь олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад өгч буй хөндлөнгийн мэдээлэл болно.

Монгол Улсад хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөл, гэрээний хороодод хүний эрхийн хэрэгжилтийг тайлагнаж байгаа ч улс орны салбар бүрт, хүн бүрийн аж төрөлд хүн эрхээ эдэлж чадаж байгаа эсэхийг эдгээр нь бүрэн илэрхийлэхгүй юм.

Иймд үндэсний түвшинд хүний эрхийг хангах, хамгаалах төрийн үүрэг хэрхэн хэрэгжиж байгааг хууль тогтоомж, төрийн үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, ялгаварлан гадуурхалтын нөхцөл байдал зэрэг бүхий л хүрээний мэдээлэлд суурилан үнэлж гаргадаг болох шаардлагатай байна.

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ,  
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ  
18 ДАХЬ ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦСЭНТЭЙ  
ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019  
ОНЫ 62 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

*Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ.*

(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг)

*Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн сэдвийг Комиссын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.*

(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг)

*Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолд заасан үүргийн дагуу Комиссын илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийн биелэлтийг Улсын Их Хуралд жил бүр илтгэнэ.*

(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг)



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар, 2019 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар, 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцээд “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолыг баталсан билээ.

Тогтоолын 2 дугаар заалтад “Энэ тогтоолын хэрэгжилтийг хангах нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт...”, 3 дугаар заалтад “Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо...”-нд тус тус даалгасан байна.

Гэвч 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газар нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээгүй байх тул Комиссын зүгээс Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон холбогдох яам, агентлаг зэрэг төрийн 17 байгууллагад хандан зохих мэдээлэл, тайланг гаргуулан авч, тогтоолын хэрэгжилтийн байдлыг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл:

## 1.1 Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх талаар

### Тогтоолын 1.1.а хэсэг

*“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахын эсрэг конвенц”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын нэмэлт протокол”-ын хэрэгжилтэд хяналт тавьж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах эсэх асуудлыг судалж танилцуулах;*

Монгол Улс 2015 онд нэгдэн орсон “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын нэмэлт протокол”-ын 3 дугаар зүйлд “Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох эсхүл хэвээр ажиллуулах үүрэг хүлээнэ.” гэж заасан байна.

Үүнд нийцүүлэн 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаа явуулах гишүүн, түүнд дэмжлэг үзүүлэн ажиллах нэгжийн чиг үүргийг тусган үндэсний механизмыг байгуулахаар хуульчилсан болно.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан гишүүн нь аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газар (хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байр)–т аль ч цаг үед саадгүй нэвтрэх, хяналт шинжилгээ хийх, нөхцөл байдлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар шилжүүлж, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр уг хуульд тусгасан байх тул тогтоолын уг заалт хэрэгжсэн байна.

#### Тогтоолын 1.1.6 хэсэг

*Хүний эрх, шударга ёсыг хангах хууль хяналтын байгууллагын алба хаагчид хууль тогтоомжоор олгосон эрхээ хэтрүүлж, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчсөн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хараат бусаар мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах бие даасан байгууллага байгуулах эсэх асуудлыг судалж танилцуулах;*

Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 2 дугаар сард Эрүүгийн багц хуулийг боловсронгуй болгох зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэхээр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх явцад Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг сэргээн байгуулах санал

гарч анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн боловч эцсийн хэлэлцүүлгээр уг саналыг дэмжээгүй байна.

Үүний зэрэгцээ хүний эрхийн олон улсын гэрээний хороод болон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар тусгай субъектын үйлдсэн гэмт хэргийг харьяалан шалгах бүтцийг хэрхэн байгуулах талаар судлах ажлын хэсгийг 2019 оны 12 дугаар сард байгуулсан<sup>175</sup>–аас өөр албан ёсны мэдээлэл алга байна.

#### Тогтоолын 1.1.в хэсэг

*Эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх сургалтыг шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын давтан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгаж, сургалтыг тогтмолжуулах, хүний эрхийн чиглэлээр сургалтад тогтмол хамруулах;*

Улсын ерөнхий прокурорын газраас эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх хүрээнд сургалт зохион байгуулах төлөвлөгөө баталж, “Хүний эрх ба эрүү шүүлт” сэдэвт сургалтын гарын авлага боловсруулан, 2019 онд нийт 4,213 прокурор, ажилтан, мөрдөгч, бусад хуульчийг 86 удаагийн 480 цагийн сургалтад хамруулжээ.

Түүнчлэн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх, эрүү шүүлт тулгах, эрүүдэн шүүхээс ангид байх эрх зэрэг сэдвийн

<sup>175</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020 оны 3 дугаар сарын 23–ны өдрийн 1/4–1247 дугаар албан бичиг.

хүрээнд нийт прокуроруудад сургалт зохион байгуулснаар 2018 оны мөн үетэй харьцуулахад сургалтын давтамж 7.5 хувь, сургалтад хамрагдсан прокурорын тоо 9.9 хувиар тус тус өссөн байна.

Тухайлбал Хөвсгөл, Дархан-Уул аймгийн прокурорын газраас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллагын албан хаагчдад “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, анхаарах асуудал”, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц” болон “Эрүү шүүлт тулгах, эрүүдэн шүүхээс ангид байх эрх”, мөн “Хүний эрх ба эрүүдэн шүүх” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулжээ. Прокурорын байгууллага нь албан хаагчдынхаа мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ “Эрхийнхээ төлөө асууя” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц зэрэг хүний эрхийн олон улсын баримт бичгийн талаар иргэд, олон нийтэд танилцуулга мэдээлэл, зөвлөгөө өгч, “АХА” тэмцээн зохион байгуулсан зэрэг үйл ажиллагааны талаар Комисст ирүүлсэн мэдээлэлдээ дурджээ.<sup>176</sup>

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор “Шүүхийн сургалтын үндсэн хөтөлбөр”-ийг баталснаар шүүгчид жилд 4 багц цагийн сургалтад хамрагдах шаардлага тавих болжээ. Хөтөлбөрийн дагуу 2019 онд “Үндсэн хууль ба хүний эрх”, “Шүүгчийн ёс зүй” сэдэвт сургалтад анхан болон давж заалдах шатны шүүхийн 482 шүүгч хамрагдсан байна.<sup>177</sup>

<sup>176</sup> Улсын ерөнхий прокурорын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1/1055 дугаар албан бичиг.

<sup>177</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 01/188 дугаар албан бичиг.

Ийнхүү зарим байгууллага сургалтын хөтөлбөртөө эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг тусган зохион байгуулсныг эс тооцвол хууль сахиулах байгууллагын давтан сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, сургалтыг тогтмолжуулах тус заалтын хэрэгжилт хангалтгүй гэж үзэхээр байна.

### Тогтоолын 1.1.г хэсэг

*хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг хүлээлгэх, мэдүүлэг авах зорилгоор сэтгэл санаа, бие махбодод нь дарамт учруулах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа байдлыг таслан зогсоож, хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчил гаргасан алба хаагчид хуулийн хариуцлага хүлээлгэх;*

Энэ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Комисст ирүүлсэн мэдээлэлд 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах ялгаварлах зорилгоор өөрөө эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсныг дурджээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт 2019 онд 4 хүнийг холбогдуулан шалгаж, Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн

анхан шатны шүүхээс шүүгдэгч Б-д нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасч, 1 жил 6 сар хорих ял, мөн Дорнод аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шүүгдэгч Б-г 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэсэн<sup>178</sup> тухай мэдээлэл ирүүлсэн байна.

### Тогтоолын 1.1.д хэсэг

*хууль хяналтын байгууллагаас хууль зөрчин гэмт хэрэг тулган хүлээлгэх зорилгоор эрүүдэн шүүсэн нөхцөл байдал тогтоогдсон тул С.Зориг агсны амь насыг бүрэлгэсэн хэрэгт ял эдэлж байгаа иргэдийн эрхийг хангах талаар хуулийн хүрээнд яаралтай арга хэмжээг авах;*

Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтэн С.Зориг агсаны амь насыг хөнөөсөн хэрэгт ял эдэлж буй этгээдүүдэд эрүү шүүлт тулгасан, гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчсөн гэх Б.Х нарт холбогдох хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгаж, прокуророос яллах дүгнэлт үйлдэн, хэргийг 2019 оны 7 дугаар сард шүүхэд шилжүүлсэн ч шүүх одоог болтол эцэслэн шийдвэрлээгүй байна.

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа одоогоор ял эдэлж буй Б.Ч нарт холбогдох эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин авч үзэх эсэх асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу прокурорын байгууллага хянан шийдвэрлэнэ<sup>179</sup> гэх мэдээллийг Комисст ирүүлжээ.

<sup>178</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 01/188 дугаар албан бичиг.

<sup>179</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 01/188 дугаар албан бичиг.

## Тогтоолын 1.2.е хэсэг

*цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хууль, журмын дагуу хэрэгжүүлж байгаад хяналт, шалгалт хийх;*

Улсын ерөнхий прокурорын 2019 оны 06 дугаар албан даалгаврын дагуу цагдан хорих, баривчлах байр, хорих ангид эрүүдэн шүүх ажиллагаа явагдсан эсэх болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хууль зүйн үндэслэлийг улсын хэмжээнд 2 удаа шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх зорилгоор удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авахын зэрэгцээ Цагдаагийн ерөнхий газарт прокурорын шаардлага хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан байна.

Улсын хэмжээнд прокурорын байгууллагаас цагдан хорих төв, байр, албадан саатуулах байрны үйл ажиллагаатай 2019 онд давхардсан тоогоор 3,436 удаа танилцсан нь урд оны мөн үеэс 1.3 хувиар өссөн, хорих ял эдлүүлэх ажиллагаатай нийт 711 удаа танилцсан нь өмнөх оны мөн үеэс 59 удаа буюу 9 хувиар тус тус өссөн<sup>180</sup> гэх мэдээлэл ирүүлсэн боловч хяналт шалгалт хийсэн эсэх нь тодорхойгүй байна.

## 1.2. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар

### Тогтоолын 1.2.а хэсэг

*хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх;*

<sup>180</sup> Улсын ерөнхий прокурорын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1/1055 дугаар албан бичиг.



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 210 дугаар тогтоолын 2 дахь заалтад хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн хүрээнд хэрэгжүүлэх салбар дундын ажлын төлөвлөгөөг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад, салбар бүрт дэд ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгожээ.

Улмаар Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор Хүүхдийн хөгжил, хамгааллын 2019–2020 оны салбар дундын ажлын төлөвлөгөөг баталжээ. Уг төлөвлөгөөнд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг боловсронгуй болгох, эрүүл мэнд, сэтгэл зүйн нөхөн сэргээх урт хугацааны эмчилгээ, үйлчилгээний хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг 2020 оны I–IV улиралд хийх, хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам хариуцан ажиллахаар тусгасан байна.

Тогтоолын дээрх заалтын хэрэгжилтийн тухай Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүний сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг батлах субъектыг тодорхой болгохоор тусгасан байна. Энэ аргачлалд хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг тусгайлан зааж болно”<sup>181</sup> гэжээ.

---

<sup>181</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 1/4-1247 дугаар албан бичиг.

## Тогтоолын 1.2.6 хэсэг

*аливаа хэлбэрийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх шинэ төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн бий болгох;*

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн мэдээллээр хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, холбогдох дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр 2019 онд нийт 18 үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг 181,890 хүүхдэд, хариу үйлчилгээг 9,662 хүүхдэд үзүүлсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий цогц үйлчилгээ үзүүлэх Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний түр хамгаалах байрыг 2017 онд байгуулж, тухайн жилд 0–18 хүртэлх насны 285 хүүхдэд, 2018 онд 945 хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлсэн байна. 2019 онд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр 2,020 хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий сайд бөгөөд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүний санаачилгаар нийгмийн бүх орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг шинээр нэвтрүүлж, 2019 оны 8 дугаар сараас ажиллуулж эхэлжээ. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ нь Улаанбаатар хотын 9 дүүрэг, Дорноговь, Хэнтий

аймагт 13,308 иргэн, 20,580 хүүхдэд хүүхэд хамгааллын мэргэжлийн үйлчилгээ үзүүлж, 43 хамтарсан багийн 276 мэргэжилтнийг ажлын байранд нь чадавхжуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн 111 цэгт эрсдэлийн үнэлгээ хийж, цахим хуудсаар дамжуулан 113,000 хүнд мэдээлэл хүргэжээ.

Мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох дэлхийн түншлэлийн хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын INSPIRE багцыг Монгол Улсад нэвтрүүлэхээр ажиллаж, 2019 онд INSPIRE багцын эх материалыг орчуулж, Хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийн гишүүдэд сургалт зохион байгуулсан байна.<sup>182</sup>

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн бий болгох чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж 2019 онд нийслэлийн хэмжээнд хохирогч 19 хүүхдэд өмгөөллийн, 48 хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, 56 хүүхдэд хууль эрхзүйн зөвлөгөө өгч, 32 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, 30 хүүхдэд өмгөөлөгч авахад нь зуучилжээ.<sup>183</sup>

Эрүүл мэндийн яам сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал (уур бухимдал, нойргүйдэл, сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, амиа хорлолт, донтолт, мансуурал, хүчирхийлэлтэй холбоотой сэтгэл санааны хямралд өртсөн)-тай үйлчлүүлэгчид мэдээлэл өгөх 24 цагийн 1800-2000 дуудлагын утсыг ажиллуулж, 2019 онд 3,231

<sup>182</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 3/669 дугаар албан бичиг.

<sup>183</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 03/823 дугаар албан бичиг.

дуудлага хүлээн авсны 243 нь хүүхдээс ирсэн дуудлага байжээ. Дээрх утсыг нээн ажиллуулснаар уур бухимдал, нойргүйдэл, стресс, сэтгэл зүйн асуудалтай хүмүүс мэдээлэл авах боломж бүрджээ. Мөн Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн дэргэдэх Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээ болон Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Өсвөр үеийн клиникээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн 16 хүртэлх насны 128 хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, нийгмийн хамгааллын тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.<sup>184</sup>

Хууль зүй, дотоод хэргийн яам Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд 2019 оны 9 дүгээр сард өргөн мэдүүлсэн бөгөөд энэ хуулийн төсөлд насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах стандартыг бий болгох, тэдний суралцах хэрэгцээг хангах талаар төрөөс үзүүлэх тусламж үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг тусгасан тухай мэдээлэл ирүүлжээ.<sup>185</sup>

Дээр дурдсанчлан Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, тэдгээрийн харьяа байгууллагуудаас хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд ихээхэн анхаарч байгаа ч олон улсын жишигт нийцсэн цогц үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай, одоо ажиллаж буй ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг дурдах нь зүйтэй юм.

<sup>184</sup> Эрүүл мэндийн яамнаас 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1а/805 дугаар албан бичиг.

<sup>185</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 1/4-1247 дугаар албан бичиг.

## Тогтоолын 1.2.в хэсэг

*хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээнд гарч байгаа зардлыг төр бүрэн хариуцдаг байх, хохирогчийг дэмжих сан байгуулахад анхаарах;*

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/263, А/406, 321 дүгээр тушаалаар “Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам”-ын 3 дугаар зүйлд “Насанд хүрээгүй иргэнийг үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна” гэж, мөн тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Шүүх эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-ний Цогцост хийх шинжилгээний хэсгийн 5-д “цогцост хийх шинжилгээ (0–18 насны) 30,000 төгрөг” гэснийг хүчингүй болгосугай.” гэж тус тус өөрчлөлт оруулжээ.<sup>186</sup> Мөн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан тохиолдолд тухайн эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн болон яаралтай тусламж үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй, дараалал харгалзахгүй, үнэ төлбөргүй үзүүлж байна.<sup>187</sup>

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлэх, таслан зогсоох, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлдэг магадлан итгэмжлэгдсэн 19 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж 2019 онд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 586 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, түүнд

<sup>186</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 1/4-1247 дугаар албан бичиг.

<sup>187</sup> Эрүүл мэндийн яамны 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1а/805 дугаар албан бичиг.

шаардагдах 490 гаруй сая төгрөгийг хүүхдийн хөгжил, хамгааллын зардлаас олгосон байна.

Тогтоолын энэ заалтын хүрээнд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн эрүүл мэндийн болон хүүхэд хамгааллын тусламж үйлчилгээний зардлыг төр бүрэн хариуцах талаар олон чухал алхмууд хийсэн боловч хохирогчийг дэмжих сан байгуулсан эсэх нь тодорхойгүй байна.

### Тогтоолын 1.2.г хэсэг

*хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, аливаа хэлбэрийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдээллийн талаарх сургалтыг хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан явуулах;*

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар хамтран хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, аливаа хэлбэрийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдээллийн талаарх сургалтыг хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан явуулах зорилгоор Дрийм телевизтэй хамтран Бонго, Можухын найзын дүрээр Сэргийлэгч хүү, Сэргийлэгч охины адал явдал бүхий цуврал богино хэмжээний хүүхдийн киног бүтээжээ.

Уг бүтээл нь “Нууцаа хамгаал”, “Танихгүй хүнээс болгоомжил”, “Аюулгүйн зөвлөмж” зэрэг 70 дугаартай бөгөөд 7 хоногт 5 удаа давтан нэвтрүүлж, цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр түгээжээ. Хүүхдийн хөгжил, хамгаалал төрийн бус байгууллагатай хамтран гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирсон 10 хүүхэд, тэдний

эцэг, эх, асран хамгаалагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгч, нийгэмшүүлэх сургалтад хамруулжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн харилцааны сөрөг хандлага, хүчирхийлэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлвийг өөрчлөх, зөрчигдсэн эрхийг сэргээхэд төрийн болон төрийн бус байгуулага, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд “Ойлгоё, Хүндэлье” урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан тухай Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд дурдсан байна.<sup>188</sup>

## Тогтоолын 1.2.д хэсэг

*сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа хүүхдийн эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалт, цахим орчны нөлөө, хүчирхийллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;*

Тогтоолын энэ заалтын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн төв, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Дэлхийн зөн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан зэрэг төрийн болон олон улсын байгууллагууд хамтран сургуулийн

<sup>188</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 1/4-1247 дугаар албан бичиг.

орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, ялгаварлан гадуурхалт, цахим орчны нөлөө, хүчирхийллийг бууруулах чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн талаар тус тусын албан бичгээр ирүүлсэн мэдээлэлд дурдсан байна. Үүнд:

- Хүүхэд, насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэргийн сүүлийн 3 жилийн судалгаанд үндэслэн “Хүүхэд хамгаалагч” төслийг 2019 онд нийслэлийн 152 хороо, 21 аймгийн сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв болох 702.3 сая төгрөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам санхүүжүүлж, төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.
  - Улсын хэмжээнд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирч болзошгүй эмзэг цэгүүдийн судалгааг гарган, “Хүүхэд хамгаалагч” эргүүлийн ажиллах цаг, чиглэлийг хороо, баг бүрээр тооцон, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн хэсгийн байцаагч, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд зөвлөмж, зааварчилгаа өгч, нийт 454 дунд сургуулийн 123,200 сурагч, 20,900 эцэг эх, 3,400 багш, ажилтнуудад мэдээлэл хүргүүлжээ.
  - Хүүхэд хамгаалагч ажилтанд хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах мэдлэг олгох 8 цагийн багц сургалтыг үе шаттай зохион байгуулж 40 нэгжийн 194 ажилтныг хамруулсан байна.
  - Хүүхэд хамгаалагч эргүүл 2019 оны 5–12 дугаар сард давхардсан тоогоор 1,550 чиглэлд ажиллаж, 150,259 хүүхдийн аюулгүй байдлыг ханган, хүчирхийлэлд өртсөн 12 хүүхдийн мэдээллийг хамтарсан багт мэдээлж, төөрсөн 79, цасан болон шороон шуурганы үеэр хараа хяналтгүй явсан бага насны 183 хүүхдийг гэрт нь хүргэн, хүүхэд шууд



эрсдэж болзошгүй 128 тохиолдлоос урьдчилан сэргийлж, зөвшөөрөлгүй газар тамхи татсан, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулсан зэрэг 161 зөрчлийг таслан зогсоожээ. Мөн зөвшөөрөлгүй цахим тоглоомын үйл ажиллагаа явуулсан, гудамжинд архидан согтуурсан зэрэг зөрчлийн 188 дуудлага, мэдээллийг хүргэж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлжээ.

- Цагдаагийн байгууллага нь Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн эрүүл мэндийн эмч, Дэлхийн зөн орон нутгийн хөтөлбөрийн салбаруудтай хамтран дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт шахалт, эрсдэлд өртөхөөс хамгаалах талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан ажил зохион байгуулахад шаардагдах 10 сая гаруй төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэн, судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаанд зарцуулжээ.
- Хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Зөв тусгал” хөдөлгөөнийг 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс нэг сарын хугацаатай улсын хэмжээнд зохион байгуулжээ. Уг арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон тэдгээрийн харьяа хэлтэс, алба зэрэг 265 төрийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн Зөн Монгол, Гүүд нейборс зэрэг 50 гаруй байгууллага, 401 аж ахуйн нэгж, 8,600 иргэний дэмжлэгтэй хийсэн байна. Нэгдсэн аян зохион байгуулах хугацаанд буюу 2019 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүүхдийн үйлдсэн хэрэг 9.8 хувь, хүүхэд хохирсон гэмт хэрэг 14.1 хувиар тус тус буурсан байна.

- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн аян арга хэмжээний мэдээ, мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн “Амрыг эрье” нэвтрүүлэгт 4 удаа, МҮОНРТ, UBS, TV5, ТВ8, VTV, Ийгл, ТВ9, Монгол HD, орон нутгийн Саян, Дербес, Шинэ Завхан, Тусгал-1, TBS, Номин, Төв зэрэг телевизээр давхардсан тоогоор 65 удаа нэвтрүүлж, “medee.mn”, “zugii.mn”, “untsug.mn”, “news.mn”, “arслан.mn”, “zaluu.mn” зэрэг 8 цахим хуудас, өдөр тутмын 6 сонинд ярилцлага, мэдээллийг нийтэлжээ. Мөн Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хэвлэл, мэдээллийн төв, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, аймаг, дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн цахим хуудсаар 85 удаагийн давтамжтай мэдээ, мэдээлэл түгээж, ухуулга нөлөөллийн 10 видео, 2 дууны клип, хууль сурталчлах 65 зурагт хуудас, нөлөөллийн үгтэй 98 зураг, 5 арга хэмжээний шууд бичлэг зэрэг нийт 214 мэдээ, мэдээлэл, контентыг нийгмийн сүлжээнд байршуулжээ.
- Хүүхдийн аюулгүй байдал, хүмүүжил, төлөвшлийн талаар 8 сэдвийн хүрээнд сургалтын материал, мэдээлэл бэлтгэн 16 их, дээд, 98 ерөнхий боловсролын сургууль, 648 аж, ахуйн нэгж, байгууллагын нийт 59,896 сурагч, оюутан, эцэг эхийн төлөөлөл, ажилтнуудад 150 удаагийн сургалт, 13 зөвлөгөөн, 6 хэлэлцүүлэг, 25 өдөрлөг зохион байгуулж, 8,600 аж ахуйн нэгж, байгууллага болон нийтийн тээврийн 60 автобусанд 26 төрлийн гарын авлага, 77 төрлийн зурагт хуудас, 56 төрлийн 21,836 санамж, сэрэмжлүүлэг байршуулсан байна.

## Сургуулийн орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр

- Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах чиглэлээр бага, дунд бүлгийн сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дүрмийн мэдлэгийг цувралаар бэлтгэн сурагчдад мэдээлэл өгөх зөвлөмжийг нийслэлийн 121 сургуулийн удирдлагад хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцон, нийт 355 сургагч багш, ажилтан, эцэг эхэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох заалтыг тайлбарлах сургалт хийжээ.
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, тээврийн хэрэгсэлд зөв тээвэрлэх, хамгаалах хэрэгсэл, суудлаар хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх санамж бүхий 27 төрлийн 16,000 тараах материалыг хэвлүүлэн эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгчдэд тараажээ.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчмын замын тэмдэг тэмдэглэгээг стандартад нийцэж байгаа эсэхэд шалгалт хийж, Монгол Улсын стандарт MNS 56444:2014 “Сургуулийн бүс, техникийн ерөнхий шаардлага”-д нийцүүлэх арга хэмжээ авахаар нийт 26 ерөнхий боловсролын сургууль, 30 цэцэрлэгийн захирал, нийгмийн ажилтнуудад хүүхдийг осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгч, гэрээ байгуулсан байна. Хүүхдийн зорчих хэсэг буюу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчимд MNS 4597:2014 стандартын дагуу “Сургууль орчмын бүс” тэмдэг байрлуулах мэдэгдэл хүргүүлж, сургууль орчмын бүсийн явган хүний гарц, хурд сааруулагчийн тэмдэглэгээг тус тус сэргээн засч, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Нийслэлийн хэмжээнд зам тээврийн осол ихээр гардаг, гарч болзошгүй, замтай ойр байрлах эрсдэл бүхий 100 сургуулийн судалгааг гарган ойр орчмын явган хүний гарцыг лед гэрэлтүүлэг, тэмдэг, тэмдэглэл, хүүхдийн зураглал, сэрэмжлүүлэг бүхий самбараар иж бүрэн тохижуулах ажлыг хийжээ. Улмаар нийслэлийн 134 ерөнхий боловсролын сургууль орчимд “Сургууль орчмын бүс” тэмдэг 50, “Явган хүний гарц” тэмдэг 125 ширхэгийг байршуулан, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулжээ.
- “Сургуулийн бүс–техникийн ерөнхий шаардлага” MNS: 56444:2014 стандартыг хангуулахаар 100 сургуультай хамтран ажиллажээ.
- Нийслэлийн зам тээврийн осол, түгжрэл, саатал ихээр үүсдэг байршлын судалгааг гарган, Сүхбаатар, Хан–Уул, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт шинээр 4,830 метр газарт хайс байрлуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, цаашид бусад дүүрэгт 5,000 метр хайс байрлуулах ажлыг зохион байгуулж байна.
- Алслагдсан гудамж, замд байрлалтай сургууль, цэцэрлэгт ойр орчимдоо стандартын шаардлага хангасан гэрэлтүүлэг хийх, камержуулах талаар 42 албан мэдэгдлийг цагдаагийн байгууллагаас хүргүүлжээ. Үүний дагуу ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, аж ахуйн нэгжийн гадна талбайн ойр орчимд 2,450 гэрэлтүүлэг, 380 хяналтын камерыг шинээр суурилуулсан байна.
- Нийслэлийн хэмжээнд сурагчид гэр, сургуулийн хооронд ирж, очих аюулгүй байдлыг хангах, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор сургуулийн автобусны шинэ чиглэл нэвтрүүлж, ерөнхий боловсролын 29 сургуульд 40 автобусаар 2–5 дугаар ангийн 3,000 гаруй сурагчид гэр–сургууль маршрутаар үйлчилжээ. Ингэснээр хотын төвөөс алслагдсан ерөнхий

боловсролын 12 сургуулийн гэр болон сургуулийн хооронд олон километр алхаж ирдэг сурагчдын аюулгүй байдлыг хангах боломж бүрдсэн байна.

Цахим орчны нөлөө, хүчирхийллийг бууруулах чиглэлээр:

- Цахим орчны нөлөө, хүчирхийллийг бууруулах чиглэлээр “Зөв тусгал”, “Илрүүлэлт”, “Хичээлийн шинэ жил” зэрэг нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд, “Цахим тоглоом” нэгдсэн шалгалт 3 удаа, хэсэгчилсэн арга хэмжээг дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдийн хэмжээнд 78 удаа тус тус зохион байгуулж, цахим тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг 213 аж ахуйн нэгж, байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 92 удаагийн сургалт, 22 удаагийн уулзалт, 5 удаагийн өдөрлөг, 4 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, нийт 12,310 иргэнийг хамруулжээ.
- Цахим тоглоомын хор уршгийг иргэдэд сурталчлах, хууль, эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр 464 гарын авлага, 2,706 зурагт хуудас, 15,363 санамж, сэрэмжлүүлэг тус тус тарааж, ерөнхий боловсролын сургууль, цахим тоглоомын газарт 92 удаагийн сургалтад 4,520 хүүхдийг хамруулсан байна.

Тогтоолын энэ заалтыг хэрэгжүүлэх талаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан олон улсын хөтөлбөрийг боловсруулан албан бус байдлаар хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд:

- Фэйсбүүк групптэй 2018 оны 9 дүгээр сард хамтын ажиллагаа тогтоосноор Харвардын их сургуулийн Беркман Клейн төвийн мэргэжилтнүүдийн боловсруулсан “Digital literacy library” буюу “Тоон бичиг үсэгтэн” хөтөлбөрийг Faro Foundation Mongolia төрийн бус байгууллага 2019 оны 4 дүгээр сараас Монгол Улсад хэрэгжүүлж эхэлжээ. Уг сургалтын

хөтөлбөрийг 11–18 насныханд зориулсан цахим орчин дахь хувийн нууцлалаа хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эерэг хандлагыг бий болгох, нэр хүндээ хамгаалах, мэдээлэл бүтээх, хуваалцах зэрэг сэдвээр ерөнхий боловсролын 20 гаруй сургуульд хэрэгжүүлсэн байна. Мөн 2019 оны 6 дугаар сарын 22–ноос 8 дугаар сарын 2–ны өдрүүдэд Есөнбулаг, Мөрөөдөл, Янзага, Нарс зэрэг хүүхдийн зусланд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ 874 сурагчийг хамруулжээ.

- “Тоон бичиг үсэгтэн” хөтөлбөрийн сургагч багш нарыг бэлдэх сургалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Говь–Алтай, Завхан, Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад амжилттай зохион байгуулж, нийт 89 багш, нийгмийн ажилтныг хамруулжээ.

Нийслэлийн Засаг даргын тамгын газраас “Цахим тоглоом, дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх нь”, “Охидын яриа”, “Хүүхдээ сонсох өдөр” сэдэвт зөвлөгөөн зохион байгуулж 536 хүүхэд оролцуулсан байна. Мөн охидын эрхийг хамгаалах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх зөвлөгөөн зохион байгуулж, 1,500 хүүхэд оролцуулснаас гадна нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд “Бидний оролцоо–Ирээдүйн хөгжилд” сэдэвт нөхөн үржихүйн сургалтаар 1,350 сургагч багш бэлтгэн, нийт 67,500 өсвөр үеийн хүүхдэд сургалт хийжээ.<sup>189</sup>

Хүүхэд, өсвөр үеийнхний нийгмийн сүлжээний зохистой хэрэглээг бий болгох зорилгоор “Зөвийг түгээе” аяныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, “Faro Foundation Mongolia” төрийн бус байгууллагатай хамтран 2019 оны 10 дугаар

<sup>189</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17–ны өдрийн 03/823 дугаар албан бичиг.

сард нэг сарын хугацаатай зохион байгуулжээ. Аяны хүрээнд цахим орчны зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр 40 гаруй зурагт хуудас, 18 видео хичээл, 12 шторк, бусад мэдээ мэдээллийг бэлтгэн төрийн болон хувийн хэвшлийн 10 гаруй байгууллагын маркетингийн сувгаар олон нийтэд хүргэжээ. Мөн нийгмийн сүлжээний зохистой хэрэглээг сурталчилсан зурагт хуудсуудыг Ди Ди Эш, Скаймедиа телевизийн сурталчилгааны дэлгэцэд байрлуулсан бөгөөд үүрэн холбооны оператор (Скайтел–226749, Мобиком–559351, Жи–Мобайл–235225, Юнител–99911)–аар олон нийтэд хандсан зурвас илгээжээ.

Мөн Монгол Улсад цахим орчинд хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил төлөвшилд сөрөг нөлөөтэй мэдээ мэдээллээс үүсэн гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой “Цахим орчинд хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэл”–ийн төслийг боловсруулаад байна.<sup>190</sup>

Цахим орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын телевизийн холбоо, Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийн төлөөлөл хамтран “Санамж бичиг” байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна” гэжээ.<sup>191</sup>

Тогтоолын энэхүү заалтын хэрэгжилтийг хангахад төрийн байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд олон үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг Комисст ирүүлсэн байна.

<sup>190</sup> Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2020 оны 3 дугаар сарын 16–ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

<sup>191</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2020 оны 2 дугаар сарын 17–ны өдрийн 1а/945 дугаар албан бичиг.

## Тогтоолын 1.2.е хэсэг

*үндэстний болон хэлний цөөнх хүүхдийн төрийн албан ёсны хэлээр сурч боловсрох эрхийг хангах, сүм, хийдэд шавилан сууж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, унаач хүүхэд, мал маллаж байгаа хүүхдийн сурч боловсрох эрхийг хангасан бодлого, үйл ажиллагаа, зарцуулагдах төсөв хөрөнгийг нэн тэргүүнд шийдвэрлэх;*

Хүүхдийн хөгжил хамгааллын жилийн 2019–2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 32–т “Үндэстний цөөнх болон хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох, ялангуяа төрийн албан ёсны хэлээр боловсрол эзэмших, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, зөвлөмжийг хэрэгжүүлэх” ажлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2019 оны IV дүгээр улиралд хэрэгжүүлэхээр тусгасан боловч аль ч байгууллага мэдээлэл ирүүлээгүй байна.

2019 оны 5 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам” баталсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хэв шинжтэй ерөнхий боловсролын сургуульд суралцах талаар зохицуулсан чухал баримт бичиг болжээ. Энэ журмын дагуу 21 аймаг, 9 дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”, мөн сургууль бүрт “Дэмжих баг” байгуулсан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 10 дугаар сарын 7–ны өдрийн А/625 дугаар тушаалаар Боловсролын хүрээлэнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, арга зүйн сектор”-ийг шинээр



байгуулснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх арга зүй боловсруулах, эрдэм шинжилгээ, судалгаа хийхийн хамт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг хариуцан ажиллах нэгж бий болжээ.

Ерөнхий боловсролын сургуульд 2018–2019 оны хичээлийн жилд 6,518 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байсан бол 2020 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын нийслэл, аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээнд энэхүү хамрагдалтыг нэмэгдүүлэхээр тусгаснаар 7,377 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд буюу хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 75.3 хувь нь боловсролын үйлчилгээнд хамрагдсан ажээ.<sup>192</sup>

**Сүм, хийдэд шавилан сууж байгаа хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар:**

2018–2019 оны хичээлийн жилд Насан туршийн боловсролын үндэсний төв болон аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төв, сумын нэгжээс зохион байгуулсан бичиг үсгийн сургалтын 4 түвшинд нийт 2,602 иргэн суралцсанаас хийдэд шавилж буй 191 лам хүүхэд хамрагдсан байна. Мөн 2019–2020 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд нийт 157 лам хүүхэд суралцаж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн "Сүм хийдийн дэргэдэх сургалтын байгууллагуудад хяналт шалгалт хийх тухай" А/41, А/51 дүгээр хамтарсан тушаалын хүрээнд Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар хамтран 21 аймаг,

<sup>192</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1а/945 дугаар албан бичиг.

нийслэлийн нийт 466 сүм хийдэд хяналт шалгалт, сүм хийдэд шавилан сууж байгаа болон сүм хийдээр үйлчлүүлдэг хүүхдийн боловсрол эзэмшиж буй байдалд судалгаа хийжээ. Хяналт шалгалтын үеэр буддын шашны сургалт явуулдаг 54 байгууллагын 11-д нь шавилан сууж байгаа 30 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд огт хамрагдаж байгаагүй сургууль завсардсан болох нь тогтоогдсон байна.

Сүм хийдэд шавилан сууж, шашны сургуульд суралцаж байгаа хүүхдүүдэд сүм хийд, дацангийн дэргэдэх шашны сургуулиар дамжуулж эсвэл албан бус боловсролын хөтөлбөрт хамруулах байдлаар ерөнхий боловсрол олгодог хэдий ч ерөнхий боловсрол эзэмшиж чадалгүй завсарддаг, сүм хийдийн албан бус сургалт төдийлөн үр дүнтэй биш байна. Мөн нийт сургууль завсардсан хүүхдийн тоо тодорхойгүй байна.<sup>193</sup>

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас ирүүлсэн албан бичгээс үзвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургах талаар ахиц дэвшил гарсан байна. Гэвч үндэстний болон хэлний цөөнх хүүхдийн төрийн албан ёсны хэлээр сурч боловсрох, сүм хийдэд шавилан суралцаж байгаа, хөдөлмөр эрхэлж буй зэрэг хүүхдийн сурч боловсрох зэрэг эрхийг хангасан бодлогыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тодорхой мэдээлэл байхгүй тул тогтоолын энэ хэсэг бүрэн хэрэгжсэн хэмээн дүгнэх боломжгүй байна.

### Тогтоолын 1.2.ж хэсэг

*эцэг, эхийн хараа хяналтаас гадуурх хүүхэд, түүнчлэн сургуульд сурах зорилгоор эцэг, эхээсээ тусдаа амьдарч*

<sup>193</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ОЗ/823 дугаар албан бичиг.

*байгаа болон сургуулийн дотуур байранд амьдарч байгаа хүүхдэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгож, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах талаар холбогдох байгууллагад үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах;*

Аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газар, аймаг, дүүрэг дэх Цагдаагийн газар, хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, бусад байгууллагууд хамтран улсын хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хараа хяналтгүй болон хараа хяналт сул, хөдөлмөр эрхэлдэг, гуйлга гуйдаг, хог түүдэг, тэнэмэл хүүхдүүд байж болох газар, цэгүүдэд хяналт шалгалт хийх, илэрсэн хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх, зөрчил илэрсэн газруудад хариуцлага тооцох зорилгоор “Илрүүлэлт–2019” нэгдсэн арга хэмжээ, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5852–2017 стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр нийт 95 арга хэмжээ зохион байгуулсан байна.

Арга хэмжээнд эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналтгүй байж болзошгүй 188, хараа хяналт сул 274, хөдөлмөр эрхлэгч 106, гар дээрээс худалдаа эрхэлдэг 16, гуйлга гуйдаг 20, орон гэргүй, тэнэмэл 11, нийт 623 хүүхдийг олж тогтоон, бүртгэлд оруулсны 457 нь эрэгтэй, 166 нь эмэгтэй байх бөгөөд 7 хүртэл насны 48, 8–13 насны 180, 14–17 насны 261 хүүхэд байна.

Эдгээр хүүхдээс Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолборт 3, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст 62, эцэг эх, асран хамгаалагчид 296, Хүүхдийн тусламжийн утас–108 төвийн дэргэдэх түр хамгаалах байранд 53, хамтарсан багийн хяналтад 2 хүүхдийг тус тус хүлээлгэн өгч, хамгаалан байршуулж, хариу үйлчилгээ үзүүлжээ. Тус арга хэмжээний хүрээнд Зөрчлийн тухай хуулиар

насанд хүрээгүй хүнд цаг хэтрүүлэн үйлчилж байсан цахим тоглоомын 3 газарт тус бүр 350,000 төгрөг, хүүхдээ үл хайхарсан 5 эцэг, эхэд нийт 1,290,000 төгрөгийн торгууль тус тус ногдуулжээ.

Улсын хэмжээнд тэнэмэл, хараа хяналтгүй байж болзошгүй 151 хүүхэд бүртгэгдсэн бөгөөд орон гэргүй 10 гэр бүлийг шинээр судалгаанд хамруулан, тэдгээр өрхийн 19 хүүхдийг нэг цэгийн үйлчилгээнд холбон зуучилж, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд 7 хоногоос 1 сарын хугацаатай байрлуулан сэтгэл зүй, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулж, архины хамааралтай эцэг эхэд 48 цагийн сургалт зохион байгуулсан байна.

Хүүхдийн, гэр бүлийн хүчирхийллийн, ялангуяа хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн, хүүхэд хохирсон дуудлага мэдээлэл нэг бүрт хяналт тавин, дээрх хүчирхийлэлтэй холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дэмжлэг үзүүлж, хохирогч болон холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, тэднээс тайлбар мэдүүлэг авах, хамтарсан багаар аюулгүйн зэргийн үнэлгээ хийлгэх, нэг хаягнаас дахин дуудлага ирсэн тохиолдолд өндөр анхаарал хандуулах талаар мэргэжил арга зүйгээр хангах, эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчдад дуудлага мэдээллийг хүлээн авах, түргэн шуурхай очих, зарим төрлийн зөрчлийг хэрхэн шийдвэрлэх зэрэгт “ECS” программыг тогтмол ашиглаж байна.-

2019 онд “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний хүрээнд хүүхдийг урлагаар дамжуулан нийгэмшүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдэнд амьдрах ухааны дадал чадвар эзэмшүүлэх зорилготой “Би нар” төслийг Хүүхдийн урлан бүтээх төв, Монголын хүүхдийн ордонтой хамтран хэрэгжүүлж, нийслэлийн 6 дүүргийн алслагдсан

гэр хороолол болон эрсдэлт нөхцөлд амьдардаг 4,200 гаруй хүүхдийг хамруулжээ.<sup>194</sup>

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн хорооны Гудамжны нөхцөлд амьдарч буй хүүхдийн талаарх 21 дүгээр ерөнхий зөвлөмжийг орчуулж хэвлүүлэн хүүхдийн эрхийн ажилтнуудад арга зүйн сургалт зохион байгуулахын зэрэгцээ гудамжны нөхцөлд амьдарч буй хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны стратегийг боловсруулсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн Засаг дарга нар Сонгинохайрхан дүүргийн Улаан чулуутын хогийн цэг, Нарантуул худалдааны төвд ажилладаг зорилтот бүлгийн хүүхдийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, улмаар "Зорилтот бүлгийн хүүхдийн эрхийг хамгаалах тухай" 2019 оны А/343, А/1207 хамтарсан тушаал, захирамж баталж, хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд гудамжны нөхцөлд амьдарч буй хүүхдийн эрхийг хамгаалах ажлыг нийслэлийн хэмжээнд улирал тутам зохион байгуулж, тэдний эрхийг хамгаалах, нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах ажлыг зохион байгуулжээ.<sup>195</sup>

Тогтоолын энэ хэсгийн хэрэгжилтийг хангах чиглэлээр салбар бүр тодорхой арга хэмжээ авч, ахиц дэвшил гарч байгаа нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллээс харагдаж байна. Цаашид хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээллийн нэгдсэн санг бий болгож, салбар бүрийн уялдаа холбоог хангахад анхаарч ажиллах шаардлагатай байна. Учир нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр,

<sup>194</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ОЗ/823 дугаар албан бичиг.

<sup>195</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн З/669 дугаар албан бичиг.

нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн мэдээлэлд “Илрүүлэлт–2019” арга хэмжээний хүрээнд илэрсэн хараа хяналтгүй хүүхдийн тоо зөрүүтэй, мэдээлэлд дурдсан үйл ажиллагааны ангилал өөр байгаагаас нэгдсэн мэдээллийг гаргахад хүндрэлтэй байв.

### Тогтоолын 1.2.3 хэсэг

*хүүхдийн бэлгийн эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг ерөнхий боловсролын сургуулийн түвшинд үр дүнтэй зохион байгуулах арга замыг тодорхойлж, хүүхдийн нууцыг чанд хадгалдаг, итгэлийг нь хүлээдэг тогтолцоог сургуульд бүрдүүлэх;*

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг батлан ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж эхэлжээ. Энэ хөтөлбөрт бэлгийн эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлыг бие даасан сэдэв болгон оруулжээ.

Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/480 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх, нууцыг хадгалах журам”, 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн А/406 дугаар тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг тус тус батлан хэрэгжүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулийн эмч болон багшийн албан тушаалын тодорхойлолтод хүүхдийн бэлгийн эрүүл мэндийн болон бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах, хүүхдийн нууцыг чанд хадгалдаг байх чиглэлээр хийж гүйцэтгэх ажлыг тодорхой тусгаж, сургууль бүр үзлэг хийж, зөвлөгөө өгөх ажлыг

хуваарийн дагуу тогтмол зохион байгуулдаг гэжээ.<sup>196</sup> Гэвч зарим аймаг, орон нутагт ерөнхий боловсролын сургуульд “охидын үзлэг”-ийг нэгдсэн байдлаар зохион байгуулж байгаагаас үүдэн өсвөр насныхны эрүүл мэндийн нууцаа хамгаалуулах эрх зөрчигдөж, сургууль болон гэр бүлийнхээ орчинд гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтад өртөж буй талаарх мэдээлэл Комисст ирж гарч байна.

Иймд эрүүл мэндийн болон боловсролын салбарын бодлого, үйл ажиллагааг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, ингэхдээ өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн нууцыг чандлан хадгалах, тэдний эрхэм чанар, нэр төртэй байх, халдашгүй дархан байх эрхийг хөндөхгүй байхад эрүүл мэндийн болон боловсролын салбарын ажилтнууд онцгой анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

## Тогтоолын 1.2.и хэсэг

*эмнэлгийн стандарт, шаардлага хангаагүй нөхцөлд нууцаар үр хөндөх, хяналтгүйгээр үр зулбуулах эм зардаг байдлыг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх тодорхой арга хэмжээг авах;*

Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн С/О6 дугаар тушаалаар “Үр хөндөлтийн цогц тусламж, үйлчилгээ” MNS5488:2019 стандарт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А/387 дугаар тушаалаар “Үр хөндөлтийг зохицуулах журам”-ыг тус тус баталсан байна.<sup>197</sup> Гэвч “Үр хөндөлтийг зохицуулах журам”-ын холбогдох заалт нь Эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалттай зөрчилдөж

<sup>196</sup> Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

<sup>197</sup> Эрүүл мэндийн яамны 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1а/805 дугаар албан бичиг.

байгааг хуульд нийцүүлэх талаарх саналаа Мэргэжлийн хяналтын байгууллагаас Эрүүл мэндийн сайдад гаргасан байна.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/223 дугаар удирдамжаар эмнэлгүүдэд хууль бус үр хөндөлтийн тохиолдлыг илрүүлэх тэмцэх, давтан болон аюултай үр хөндөлтөөс сэргийлэх, бууруулах зорилгоор хяналт шалгалт хийжээ. Шалгалтаар эмнэлгийн стандарт шаардлага хангаагүй нөхцөлд үр хөндөлт хийсэн тохиолдол илрээгүй боловч өргөдөл, гомдлын мөрөөр хяналт, шалгалт хийхэд Баянзүрх дүүргийн 21 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд хууль бусаар үр хөндөлт хийсэн нь тогтоогдож, одоогоор хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байна.<sup>198</sup>

Хууль бус үр хөндөлттэй холбоотой мэдээллийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 1800–1286, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 7012–8012 дугаарын утсаар авах тухай олон нийтийн цахим сүлжээнд мэдээлэл байршуулсан боловч нэг ч мэдээлэл бүртгэгдээгүй байна.<sup>199</sup>

Мөн 2019 онд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 6, нийслэлийн Хүрээ амаржих газар 3, Өргөө амаржих газарт 2, Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэгт 1, нийт 12 эмэгтэй биеийн байдал нь хүндэрсэн байдалтай хандаж тусламж үйлчилгээ авсныг судлахад эдгээр эмэгтэйчүүд бүгд “Нарантуул захаас эм авч уусан” гэсэн өгүүлэмжтэй, мөн эмнэлгийн мэргэжилтнүүдэд үр хөндүүлсэн эсэхээ үнэн зөв мэдээлдэггүй нь уг асуудлыг судлах, таслан зогсооход

<sup>198</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 03/823 дугаар албан бичиг.

<sup>199</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 02/419 дугаар албан бичиг.



хүндрэл бий болгож байна. Хүнс, барааны зах, дэлгүүр, лангуугаар хувь хүний зарж байгаа үр зулбуулдаг эмийн хууль бус худалдааг илрүүлэхэд мэргэжлийн хяналтын байгууллага нь “нэгжлэг хийх, өгөөш тавих зэрэг гүйцэтгэх ажиллагаа явуулах эрх хэмжээ байдаггүй тул хууль бус үр хөндөлтийг илрүүлэхэд хүндрэлтэй байна”<sup>200</sup> гэжээ.

Эрүүл мэндийн яам болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээс харахад эмнэлгийн стандарт, шаардлага хангаагүй нөхцөлд нууцаар үр хөнддөг, хяналтгүйгээр үр зулбуулах эм зардаг зөрчлийг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх талаар арга хэмжээ авч байна. Гэвч уг асуудлыг зохицуулж буй дүрэм, стандарт нь Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай зэрэг хуулиудтай зөрчилдсөн, хууль бус үйл ажиллагааг таслан зогсооход мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хуулиар олгосон эрх хэмжээ хязгаарлагдмал, тухайлбал Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн холбогдох заалтын дагуу хяналт шалгалт хийхдээ урьдчилан мэдэгддэг зэрэг нь шалгуулагч этгээдэд хууль бус үйлдлээ нуун дарагдуулах боломжийг олгож байх тул дээрх хууль тогтоомж, стандартын холбогдох заалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

### Тогтоолын 1.2.к хэсэг

*гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсонтой холбоотой хүүхэд сэтгэлзүйн гүн хямралд орж, улмаар амиа хорлох байдалд хүрч байгааг онцгойлон анхаарч гэмт хэрэг, зөрчлийн хохирогчийн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлдэггүй байх арга хэмжээг авах;*

<sup>200</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 02/419 дугаар албан бичиг.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн санд 2019 онд гэмт хэргийн улмаас 111 хүүхэд нас барсан гэж бүртгэгдсэн бөгөөд эдгээр хүүхдийн нас барсан шалтгааныг судлахад гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсны улмаас сэтгэлзүйн гүн хямралд орж амиа хорлосон тохиолдол бүртгэгдээгүй хэдий ч ийм болзошгүй эрсдэл байгааг онцгойлон анхаарч гэмт хэрэг, зөрчлийн хохирогчийн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэхгүй байх арга хэмжээг авч байгаа ажээ.

“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-д гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хүүхдийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тараахгүй байх талаар сэтгүүлчид, алба хаагчдад чиглэсэн сургалтын агуулгад тусгуулахаар сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулж байгааг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд дурджээ.<sup>201</sup>

### Тогтоолын 1.2.л хэсэг

*олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгааллын тогтолцоог урлаг, соёл, спортын байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор бий болгож, хяналтыг сайжруулан хүүхдийн эрх зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх;*

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 21 аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа урлаг, соёлын арга хэмжээний зохион байгуулагч талуудад хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч ажилласан байна.

<sup>201</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 1/4-1247 дугаар албан бичиг.

Тухайлбал:

- Сургуулийн орчинд зохион байгуулж байгаа уралдаан, олимпиад зэрэг арга хэмжээний үед тухайн аймаг, дүүргийн Боловсрол, соёл урлагийн газарт хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдээлэл зөвлөмж өгч ажиллажээ.
- Хүүхдийн баяр болон Үндэсний баяр наадмын үед эцэг эх, асран хамгаалагчид зориулсан зөвлөмж, мэдээлэл түгээж, хүүхдийн гарын бугуйвч тарааж, эцэг эхээсээ төөрсөн хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгжийг Улаанбаатар хотод Сүхбаатарын талбай, Төв цэнгэлдэх хүрээлэн, Хүй долоон худагт, аймгуудын наадмын талбайд ажиллуулж, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Мөн 2019 онд морь унаач хүүхдийн бүртгэл, хяналтыг сайжруулах зорилгоор улсын хэмжээнд нийт 10,235 хүүхдийг биосканаар бүртгэж, “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандарт”-ын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласны үр дүнд 2019 онд 172 удаагийн уралдаан зохион байгуулагдсан нь өмнөх оныхоос 2.8 дахин буурсан үзүүлэлт бөгөөд мориноос унасан хүүхдийн тоо 213 тохиолдлоор буурч 448 болсон байна.

Унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалын нөхөн олговрын хэмжээг нэмэгдүүлэхээр даатгалын компаниудтай хамтран ажиллаж, нөхөн олговрын хэмжээ 5 сая хүртэлх төгрөг байсныг 20 сая хүртэлх төгрөг болгон нэмэгдүүлжээ. 2018 онд хурдан морины уралдааны үед мориноос унаж

бэртсэн 86 хүүхэд 49.5 сая төгрөг, 2019 онд 121 хүүхэд 186.6 сая төгрөгийг гэнэтийн ослын даатгалын нөхөн олговорт авсан байна.<sup>202</sup>

Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллээс харахад тогтоолын энэ хэсгийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ нь зөвхөн хурдан морины унаач хүүхдээр хязгаарлагдаж байгаа нь хангалтгүй байх тул цаашид тогтоолын энэ хэсгийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн арга хэмжээг авах шаардлагатай байна.

### Тогтоолын 1.2.м хэсэг

*Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хууль тогтоомжийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр сурталчлах, хүүхдийн эрх, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалтай холбоотой өөрчлөлтийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.*

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуулийг сурталчлах, олон нийтэд түгээх, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллагын албан хаагчдыг сургаж чадавхжуулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн мэдээлэлд дэлгэрэнгүй дурдсан байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Хүүхдийн хөгжил хамгааллын жилийн 2019–2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Хөдөлмөр, нийгмийн

<sup>202</sup> Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн О1/116 дугаар албан бичиг.

хамгааллын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан хийж дуусгахаар ажиллаж байна.<sup>203</sup>

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг багц хуулийн төслийг боловсруулсныг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталсан байна. Энэ хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор Эрүүгийн хуулийн Арван зургадугаар бүлэгт болон Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Тухайлбал Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Хүчиндэх (12.1 дүгээр зүйл) гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж үйлдсэн бол хоёроос найман жил хүртэл хорих ялтай байсныг таваас арван хоёр жил хүртэл хорих ялтай болгож, арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгож үйлдсэн бол таваас арван жил хүртэл хорих ялтай байсныг наймаас арван таван жил хүртэл хорих ялтай болгож ялын бодлогыг чангатгажээ. Мөн Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (12.2 дугаар зүйл) гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүн болгож хоёр жил хүртэл хорих ялтай байсныг 8 хүртэл жил болгож ялыг нэмэгдүүлсэн байна. Биеэ үнэлэхийг зохион

<sup>203</sup> Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 01/116 дугаар албан бичиг.

байгуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон бөгөөд энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарахаар зохицуулалт тусгасан байна.<sup>204</sup> Тиймээс тогтоолын энэхүү хэсэг хэрэгжсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

### 1.3 Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар

#### Тогтоолын 1.3.а хэсэг

*эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах;*

Тогтоолын хүрээнд Ойн үрийн байнгын талбай байгуулах MNS6531:2019, Ундны ус. Нитритын агуулга тодорхойлох арга MNS6779:2019, Ундны ус. Хатуулаг тодорхойлох арга MNS6778:2019, Лабораторийн био аюулгүйн зэрэглэл. Ерөнхий шаардлага MNS6815, Сорьц авах. 3 дугаар хэсэг: Усны сорьцтой харьцах ба сорьцыг тогтворжуулах MNS ISO5667-3:1999 зэрэг Монгол Улсын үндэсний стандартыг 2019 онд баталсан байна.

Барилга, хот байгуулалтын яам болон Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Мөн Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд “төлбөрийн орлогыг усны нөөцийг хамгаалах, усны

<sup>204</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамны 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 1/4-1247 дугаар албан бичиг.

бохирдлыг арилгах, хяналт–шинжилгээ хийх, нөхөн сэргээх цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд тус тус зарцуулах”-аар тусгасан зэргээр тогтоолын энэ хэсгийг хэрэгжүүлэн ажиллаж байна гэжээ.

### Тогтоолын 1.3.6 хэсэг

*ашигт малтмал хайх, ашиглах явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх стандартын дагуу хүний аюулгүй байдал болон хүрээлэн байгаа орчинд үзүүлдэг сөрөг нөлөөллийг багасгаж, уул уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг олон улсын жишигт нийцүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;*

Уул уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн хаалтын талаарх хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагаар Монгол Улсын Их Хурлын 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарын талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг баталсан бөгөөд уг баримт бичгийн 3.6.3 дахь заалтад “уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах”, мөн Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх хэсэгт “уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь хэсэгт “газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс доошгүй хугацааны өмнө боловсруулж, тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, байгаль орчны

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх” зохицуулалтыг тус тус тусгажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.67.2–т заасан “Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх” зорилтын хүрээнд “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181, А/458 дугаар хамтарсан тушаалаар баталсан байна.<sup>205</sup> Цаашид тогтоолд дурдсан ашигт малтмал хайх, ашиглах явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх стандартын дагуу хүний аюулгүй байдал болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах талаар Монгол Улсын Засгийн газар, төрийн холбогдох байгууллагууд анхаарч ажиллах шаардлагатай байгааг тэмдэглэж байна.

### Тогтоолын 1.3.в хэсэг

*Улаанбаатар хотын агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх;*

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 20–ны өдрийн 98 дугаар тогтоолоор баталсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” болон Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны 19/01 дүгээр тогтоолд зааснаар дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

<sup>205</sup> Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 2 дугаар сарын 13–ны өдрийн 01/436 дугаар албан бичиг.



- Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн, усан халаалтын 98 зуухыг буулгаж, 133 сургууль, цэцэрлэг, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламжийг төвлөрсөн дулаанд холбож, 16 цэцэрлэг, 3 сургуулийг цахилгаан халаалтад тус тус шилжүүлсэн. Мөн 101 кВт-аас дээш хүчин чадалтай 220 усан халаалтын зуухны янданд шүүлтүүр суурилуулжээ.
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын 175,000 гаруй айл өрхийг сайжруулсан түлш, угаарын хий мэдрэгч төхөөрөмжөөр хангасан байна.
- Нийтийн тээврийн үйлчилгээнд шатдаг хийгээр ажилладаг 70 автобус нийлүүлж, дизель хөдөлгүүртэй 24 автобусанд хөө торггийг 90 хүртэл хувиар бууруулах хүчин чадалтай шүүлтүүр суурилуулжээ.
- Дөрвөн төрлийн агаар цэвэршүүлэгч, арван төрлийн эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлж, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулж ногоон гэрчилгээ олгожээ.
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр "Агаар, орчны бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе", "Гэр байшингаа дулаалъя, сайжруулсан шахмал түлш хэрэглэе", "Ногоон зээлд хамрагдаж агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе", "Одонтой ээжүүд агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэж байна", "Хандлагаа өөрчлөө", "Хоггүй цэвэрхэн Монгол" зэрэг уриалгыг олон нийтэд цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах болон

бусад ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, холбогдох байгууллагууд хэрэгжүүлсэн байна.

- Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1016 дугаар захирамж, Нийслэлийн онцгой комиссын хурлын шийдвэрээр нийслэлийн 6 дүүрэгт түүхий нүүрс хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан айл өрхийг “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан түлшээр хангаж, хяналт тавьснаар 2018 оны агаарын чанарын их эрсдэлтэй объект нь 17 хувь болж буурсан, бага эрсдэлтэй объект 17.99 хувь болж өссөн байна.<sup>206</sup> Дурдсан ажлуудын дүнд Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 19–38 хувиар, PM10 тоосонцор 3–43 хүртэлх хувиар тус тус буурсан байна.<sup>207</sup>

### Хөрсний бохирдлыг бууруулах талаар:

“Төв цэвэрлэх байгууламжийн лагийг цэвэрлэж, үнэргүйжүүлэх” төслийн хүрээнд 2019 оны төсөвт 12.5 тэрбум төгрөг тусгаж Төв цэвэрлэх байгууламжийн лаг усгүйжүүлэх технологийн дамжлагыг 2019 оны 9 дүгээр сард ашиглалтад оруулж, механик болон химийн аргаар усгүйжүүлснээр лагийн хэмжээ 5–8 дахин, үнэрийн хэмжээ 5–6 дахин багасчээ. Үнэр тархалтыг бууруулахаар цэвэрлэх байгууламж дотор 8 цэг, байгууламжийн эргэн тойрон суурьшлын бүсийн 12 цэгт 9 төрлийн үнэр тархалтын дээж авч, лабораторийн дүн шинжилгээ хийлгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэжээ.<sup>208</sup>

<sup>206</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ОЗ/823 дугаар албан бичиг.

<sup>207</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн О1/1092 дугаар албан бичиг.

<sup>208</sup> Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн О1/710 дугаар албан бичиг.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/995 дугаар захирамжийн дагуу төвлөрсөн болон бие даасан ариутгах системд холбох боломжгүй газарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, бохирын цооногтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, хүнд металлын бохирдол ихтэй 0.8 га газрын хөрсний бохирдлыг саармагжуулах, хотын төв, нийтийн эзэмшлийн талбайн ургамлыг тогтмол хугацаанд зохистой тайрч, хөрсний доройтлыг бууруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран турших, шаардлага хангахгүй нүхэн жорлонгоос татгалзах тухай сурталчилгааг олон нийтэд хүргэх зэрэг ажлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулсан байна. 2019 онд 34 га талбайд хогийн цэгийн ариутгал, 8 дүүрэгт нийт 31,894 нүхэн жорлон, бохирын цооног, нийтийн эзэмшлийн бохирдол ихтэй 91,565 кв талбайд халдваргүйжүүлэлт хийжээ.

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд Улаанбаатар хот, 21 аймагт хог хаягдлыг ангилан ялгах, хамгаалалтын бүсэд байгаа хог хаягдлын төвлөрсөн цэгийг яаралтай нүүлгэн шилжүүлэх, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодолсон жагсаалтад нэмэлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 199 дүгээр тогтоолыг батлуулах, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа туршилтын төслийн хүрээнд Цагаан давааны хог хаягдлын төвлөрсөн цэгт үнсний хог хаягдлыг дарж булшлах эрүүл ахуйн шаардлага хангасан ландфиллыг барих зэрэг ажлыг хийж байна.

Улс, орон нутгийн төсөв, “Монгол Солонгосын Ногоон хэрэм” төслийн хөрөнгөөр шинээр ойн зурвас байгуулах, хот суурин газрын орчимд ойн зурвасыг ногоон байгууламж, хамгаалалтын зурвас хэлбэрээр байгуулах жишиг ажлын

хүрээнд 21 аймаг, 9 дүүрэгт нийт 105 га талбайд (тус бүр 3.5 га талбайтай) "Ногоон паспорт – Ногоон төгөл" байгуулж, нийт улсын төсөв болон төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр 8,954.1 га талбайд ойжуулах ажлыг гүйцэтгэсэн байна. Засгийн газрын 2019 оны 318 дугаар тогтоолоор "Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр", "Улаанбаатар хотын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл"-ийн хүрээнд эрүүл хөрсийг хамгаалах, бохирдож доройтсон хөрсийг цэвэрлэн эрүүлжүүлэх, хөрс бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах ажлыг хийж, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 6, 7, 40 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны 1,500 өрхөд сайжруулсан эко-ариун цэврийн байгууламж суурилуулсан талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн мэдээлэлд<sup>209</sup> дурджээ.

#### **Усны бохирдлыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар:**

Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт хориглолтын бүсийг гүний худгаас 500 метр, хязгаарлалтын бүсийг 800 метр байхаар тогтоож, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн 6 байршилд 145 камер суурилуулан, цэвэр, бохир усны шугам, шугамын хамгаалалтын бүсэд баригдсан барилга байгууламж болон эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсэд газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжийг судалж, хууль, журам зөрчсөн 234 иргэн, аж ахуйн нэгжид хариуцлага тооцсон байна.

Мөн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт унд, ахуй, үйлчилгээнд ашиглаж байгаа 472 худгийн усанд 57 үзүүлэлтээр судалгаа хийж мэдээллийн сан бүрдүүлэх, булгийн эх бохирдох, усны нөөц багасахаас сэргийлэх

<sup>209</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 01/1092 дугаар албан бичиг.

зорилгоор Хан-Уул дүүргийн 14 болон Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 3 булгийн эхийг хашиж хамгаалах, Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороон дахь Толгойтын баруун салааны Бумбатын булгийг түшиглэн 1,380.5 метр квадрат талбайтай, 10,500 метр куб ус хуримтлуулах хүчин чадалтай хөв (хиймэл нуур) байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэжээ.

### Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр:

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийт 1,899 айлын газрыг чөлөөлж, 9,229 айлын орон сууц ашиглалтад оруулжээ. Бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил хийгдээгүй, явц удаашралтай байгаа 14 төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг холбогдох хууль, журмын дагуу цуцалж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн 2 байршлыг нэмж баталснаар дахин төлөвлөлтийн 26 байршил, 78 хэсэгчилсэн талбайтай болж, 5 төсөл хэрэгжүүлэгчийг шинээр шалгаруулж батламжилсан<sup>210</sup> байна.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, түүнийг дагалдан гарах журам, гэрээний үлгэрчилсэн загварыг баталснаас хойш 5 жил болсон хэдий ч хот суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийг хангах чиглэлээр гүйцэтгэж буй ажлын явц удаашралтай, шаардлага хангаагүй төсөл хэрэгжүүлэгч зарим ажлыг давтан гүйцэтгэж байгаа зэргээр дээрх хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

<sup>210</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ОЗ/823 дугаар албан бичиг.

### Тогтоолын 1.3.г хэсэг

*цэвэр усны түгээлт, хэрэглээнд хэмнэлтийн горимыг баримтлах, үйлдвэрлэлийн хэрэгцээнд саарал ус ашиглах дэвшилтэт технологийг нэвтрүүлэх асуудлыг зохицуулсан бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх;*

Хаягдал усыг цэвэрлэж ариутгах татуургын технологийн хэрэгцээнд болон суултуур зайлах, нүүрс угаах, зам, талбайн тоос дарах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээнд дахин ашиглахыг дэмжих зорилгоор "Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага". MNS 6734:2018 стандарт, "Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглах MNS 130:16075 багц стандарт"-ыг Стандартчилал хэмжил зүйн газрын Байгаль орчны стандартчиллын техникийн хорооны 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаас баталжээ.

Мөн "Бохирусыг цэвэршүүлэн ариутгах татуургын систем, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах" стандартын төслийг боловсруулж, мэргэжлийн байгууллагаас санал авах, батлуулах ажлыг гүйцэтгэж байна. Эдгээр багц стандартыг хэрэгжүүлснээр хаягдал усыг цэвэрлэж, газар тариалан, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглах нөхцөл бүрдэх ажээ.<sup>211</sup> Төв цэвэрлэх байгууламжаас гарах цэвэршүүлсэн усыг дулааны 3, 4 дүгээр цахилгаан станцад дахин ашиглах асуудлыг Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын сангаас хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын усан хангамжийг сайжруулах төсөлд тусгаад байна.

Ус сувгийн удирдах газар нь бохирдуулагч 27 үйлдвэртэй технологийн хаягдал ус татан зайлуулж, урьдчилан цэвэрлэх гэрээ байгуулж, стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн

<sup>211</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 03/823 дугаар албан бичиг.

бохирдолтой ус нийлүүлсэн 57 үйлдвэрт яаралтай хэвийн ажиллагаанд оруулах, биелүүлээгүй тохиолдолд усан хангамжийг зогсоох албан бичиг хүргүүлж, хяналт тавьж ажиллажээ. 2019 оны жилийн эцсийн байдлаар усаа дахин ашиглах тоног төхөөрөмжтэй машин угаалгын 37 газар, 6 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.<sup>212</sup>

Хэдийгээр дээр дурдсанчлан тодорхой стандарт, журам батлах, хяналт шалгалт хийх зэрэг ажлууд хийгдсэн нь зохих ахиц мөн боловч үйлдвэрлэлийн хэрэгцээнд саарал ус ашиглах технологийг нэвтрүүлэх бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх заалтын хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгааг анхаарах шаардлагатай байна.

### Тогтоолын 1.3.д хэсэг

*хот төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийн хүрээнд газраа чөлөөлж, үл хөдлөх эд хөрөнгөгүй болж хохирсон иргэдийн хохирлыг нэн даруй барагдуулах арга хэмжээг авах;*

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 2019 онд нийт 219 бүтээн байгуулалтын ажил хийхээр төлөвлөжээ. Уг ажлын нөлөөлөлд 2,193 нэгж талбарын 120 га газар өртсөн бөгөөд 1,047 иргэнд нөхөх олговор олгож, 265 өрх орон сууцанд, 191 өрх түр суурьшуулах байранд орж, 600 гаруй нэгж талбарыг нөхөх олговоргүйгээр чөлөөлсөн байна.<sup>213</sup> Газраа чөлөөлж, үл хөдлөх эд хөрөнгөгүй болж хохирсон гэх иргэд учирсан хохирлоо нэхэмжилсэн 9 хэргийг Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2019 онд хянаж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж 2 хэрэг, зарим хэсгийг хангаж 5 хэрэг,

<sup>212</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ОЗ/823 дугаар албан бичиг.

<sup>213</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ОЗ/823 дугаар албан бичиг.

шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож 2 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.<sup>214</sup>

### Тогтоолын 1.3.е хэсэг

*газар чөлөөлж, үл хөдлөх эд хөрөнгийг буулгахад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хохирлыг төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага бүрэн хариуцдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;*

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.3.в дэх хэсэгт “төсөл хэрэгжүүлэгч энэ хуулийн 14.7.1 дэх хэсэгт заасан үе шатыг дуусах хүртэл газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй харилцан тохиролцоогүй тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн нөхөх олговортойгоор газар чөлөөлөх тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах” гэж заасныг баримтлан “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 222 дугаар тогтоолоор баталсан байна.

Мөн “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 125 дугаар тушаалаар баталж, Хот, суурин газрын ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загварын 5.7-д “Сууц өмчлөгч, төсөл хэрэгжүүлэгч нь гэрээнд заасан өөрийн овог, нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, төлөөлөх эрх бүхий албан

<sup>214</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 01/188 дугаар албан бичиг.



тушаалтны овог, нэр болон хаяг өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухайгаа эрх олгогчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ийнхүү мэдэгдээгүйн улмаас учирсан хохирол, үр дагаврыг бүрэн хариуцна.” хэмээн зааж хохирлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд хариуцахаар зохицуулсан байна.

### Тогтоолын 1.3.ж хэсэг

*Монгол Улсын үндэсний болон хүнсний аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр хилийн боомтуудад орчин үеийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон лаборатори байгуулж, хүчин чадлыг нэмэгдүүлэх санхүүжилтийг шийдвэрлэх, шаардлага хангаагүй хүнс, хүнсний түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэх явдлыг таслан зогсоох.*

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар хамтран Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” (МОН3313) төслийг 2017 оноос хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумдад байрлах Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын болон Дорноговь, Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн лабораторийн барилгыг шинээр барих, тоног төхөөрөмжөөр хангах, Алтанбулаг, Замын-Үүд боомтод мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн байгууламж шинээр барих, тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлт хийх автомат төхөөрөмж суурилуулах ажлыг тус тус төлөвлөжээ.

Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Гашуунсухайт,

Сүхбаатар аймгийн Бичигт, Увс аймгийн Боршоо боомтын зураг төсөлд мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторийн барилгыг тусгуулж батлуулсан байна. Гэвч эдгээр лабораторийн барилга баригдах эсэх нь тухайн төслийн санхүүжилтээс шалтгаалж шийдвэрлэгдэнэ гэжээ.<sup>215</sup>

Ийнхүү Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр нэр бүхий хилийн боомтуудад орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон лаборатори байгуулах ажлыг төлөвлөсөн нь тогтоолын уг заалтыг хэрэгжүүлэхэд гарч буй чухал алхам хэдий ч цаашид чанарын шаардлага хангаагүй хүнс, хүнсний түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэх явдлыг таслан зогсооход анхаарах шаардлагатай байна.

#### 1.4. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар

##### Тогтоолын 1.4.а хэсэг

*Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн санг бий болгох, мэдээлэл тогтмол цуглуулах тогтолцоог ажиллуулах, судалгаа, мэдээллийг шийдвэр гаргахад ашиглах;*

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар баталсан эрүүл мэндийн статистик мэдээлэлд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн жирэмсний хяналтын зарим үзүүлэлтийг шинээр тусгаж мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн нь бодлого боловсруулагч,

<sup>215</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 02/419 дугаар албан бичиг.

шийдвэр гаргагчдыг нотолгоонд тулгуурласан мэдээллээр хангах боломж гэж үзэж байгаагаа Эрүүл мэндийн яамнаас Комисст ирүүлсэн мэдээлэлд дурдсан байна.<sup>216</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас дээрх зөвлөмжийг биелүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудаас хийсэн ажлын талаарх мэдээллүүдийг нэгтгэж байгаа<sup>217</sup> ажээ. Тухайлбал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо нь Монгол дахь Норвегийн тусламжийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих төсөлтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх туршилтын тооллогыг 2019 оны 2 дугаар сард Ховд аймагт зохион байгуулжээ.<sup>218</sup> Тооллогын хүрээнд Ховд аймгийн 17 сумын 3,099 өрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдээс ганцаарчилсан асуулга авсан байна.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/304, А699, А/460 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн маягт, Хүүхдийн хувийн хэрэг хөтлөх маягт, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэлийн маягтыг тус тус баталсан нь хүүхдийн хөгжлийн үнэлгээ, хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэхэд зохих ахиц дэвшил болсон байна.

Эрүүл мэндийн салбарын статистик мэдээлэлд зарим үзүүлэлтийг бүртгэж эхэлсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй

<sup>216</sup> Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

<sup>217</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 1/58 дугаар албан бичиг.

<sup>218</sup> Мөн тэнд.

эмэгтэйчүүдэд зориулсан тусламж, үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдээгүй нь тогтоолын энэ хэсгийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

#### Тогтоолын 1.4.6 хэсэг

*Эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах;*

Эрүүл мэндийн яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээс дүгнэхэд тогтоолын энэ хэсгийн хэрэгжилт хангалтгүй буюу эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг тусгаагүй байна.

Харин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдал, жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл, нөхөн үржихүйн эрхийн талаарх ойлголт хандлагыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж, 2019 оны 12 дугаар сард нийт 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэргэжилтнүүдийг хамруулан сургалт зохион байгуулжээ.<sup>219</sup>

Тус яамны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай ойлголт, хандлагыг сайжруулах зорилгоор 2019 онд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, иргэдэд “18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж

<sup>219</sup> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 3/669 дугаар албан бичиг.

бүрэн үзлэг”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах нь”, “Сэргээн засалтын тусламж үйлчилгээ, нөлөөлөл”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдэвт сургалт, мөн төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын 920 орчим төлөөлөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийн талаарх нөлөөллийн сургалтыг тус тус зохион байгуулжээ.

Эрүүл мэндийн яамны хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тус төвийн захиалгаар эмнэлгийн 12 мэргэжилтнийг улсын төсвийн санхүүжилтээр суралцуулж байгаа ажээ.

#### Тогтоолын 1.4.в хэсэг

*Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах;*

Эрүүл мэндийн яамны мэдээлэлд дурдсанаар эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жирэмсэн эхэд хүлээлт, чирэгдэл үүсгэхгүй үйлчлэх зорилгоор Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/102 дугаар тушаалаар Жирэмсний хяналт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний журам баталсан байна.

Энэ хүрээнд нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төвд Нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц тусламж,

үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээг нээн ажиллуулжээ. Улаанбаатар хотын хэмжээнд 2019 онд тус кабинетуудаар давхардсан тоогоор 58,886 эмэгтэй үйлчлүүлжээ.<sup>220</sup> Улмаар Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын А/155 дугаар тушаалын дагуу дээрх журмын хэрэгжилтийг үнэлэх хяналт, үнэлгээний ажлыг нийслэлийн 8 дүүрэг, 2 салбар амбулатори, 2 тосгонд хийж, удирдлагын баг, эх барих эмэгтэйчүүдийн эмч, мэргэжилтнүүдтэй уулзаж, арга зүйгээр хангажээ.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, нийслэлийн амаржих газруудад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан төрөх орыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр нийлүүлсэн байна.<sup>221</sup> Олон үйлдэлт зориулалтын ор нь хөгжлийн бэрхшээлтэй, тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах зориулалттай юм. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын А/162 дугаар тушаалын дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих сарын аян” өрнүүлж, Өргөө, Амгалан амаржих газарт нугасны гэмтэлтэй 60 эмэгтэйг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв хөгжлийн бэрхшээлтэй 100 гаруй эмэгтэйд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлжээ.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд Сэргээн засах төвөөр үйлчлүүлсэн хүмүүст мэдээлэл хүргэхийн зэрэгцээ Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуульд “Нөхөн үржихүйн булан”-г тогтмол ажиллуулах, дотуур байрны оюутнуудад нөхөн үржихүйн

<sup>220</sup> Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ОЗ/823 дугаар албан бичиг.

<sup>221</sup> Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

сэдэвт гарын авлага, танилцуулга тараах, Баасан гарагийн 19 цагт тогтмол нөхөн үржихүйн цуврал нэвтрүүлэг үзүүлэх, “Жирэмслэлтээс хэрхэн хамгаалах вэ?” сэдвээр сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулжээ.<sup>222</sup>

Эдгээр тайлан, мэдээллээс харахад нөхөн үржихүйн зөвлөгөө, мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх, нөхөн үржихүйн кабинет, төрөх тасгуудыг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцүүлэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах ажил нийслэлийн түвшинд эхлэл төдий бөгөөд цаашид аймаг, орон нутгийг хамруулан үндэсний хэмжээнд зохион байгуулах хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

#### Тогтоолын 1.4.г хэсэг

*Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа дүрэм, журамд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, конвенцод заасан зохицуулалттай нийцүүлэх*

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн яам эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын, мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд дунд хугацааны үнэлгээ 2019 онд тус тус хийжээ.<sup>223</sup>

<sup>222</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 1/58 дугаар албан бичиг.

<sup>223</sup> Эрүүл мэндийн яамны 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1а/805 дугаар албан бичиг.

Үүнээс үзэхэд эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд зохих хяналт–шинжилгээ, үнэлгээ хийсэн боловч тэдгээрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, конвенцод заасан зохицуулалттай нийцүүлсэн, салбарын дүрэм журамд өөрчлөлт оруулсан эсэх нь тодорхойгүй байна.

## 1.5. Хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжих талаар

### Тогтоолын 1.5.а хэсэг

*Боловсролын салбарын бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр болон “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг харгалзан үздэг байх;*

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас ирүүлсэн тайлан мэдээлэлд дурдсанаар боловсролын бодлогын баримт бичиг боловсруулах, сургалтын хөтөлбөрийг сайжруулахдаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр болон Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг харгалзан тусгаж байгаа ажээ.<sup>224</sup> Тухайлбал:

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” баталжээ.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/492 дугаар тушаалаар “Бага, суурь,

<sup>224</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1а/945 дугаар албан бичиг.



бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг сайжруулан баталжээ.

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/528 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг батлав. Ерөнхий боловсролын сургуулиуд 4 бүлэг, 57 заалтаас бүрдэх уг чиглэлийг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлыг төлөвлөх, зохион байгуулах, багшийн мэргэжлийн хөгжлийг хангах, эрүүл, аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэхэд баримталдаг байна.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/756 дугаар тушаалаар “Насан туршдаа суралцахуйг дэмжих хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд 2019–2021 онд хэрэгжих тус хөтөлбөр тогтвортой хөгжлийн үзэл санаа, хувь хүний хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чадварыг иргэдэд нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр тасралтгүй эзэмшүүлэх нөхцөл бүрдүүлэх, насан туршийн боловсролын тогтолцооны чадавхыг нэмэгдүүлэх зорилгыг дэвшүүлжээ.

Ийнхүү боловсролын салбарын зарим бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхдээ Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг харгалзан үзсэн нь сайшаалтай хэдий ч Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тайлагнах талаар Монгол Улсын Засгийн газар зайлшгүй анхаарч, хүчин чармайлтаа нэмэгдүүлэх шаардлагатайг тэмдэглэж байна.

### Тогтоолын 1.5.6 хэсэг

*Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх зорилгыг бүх шатны боловсролын хичээлийн хөтөлбөрт тусгах;*

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Боловсролын хүрээлэн нь “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг 2019 онд шинэчлэн батлахдаа тогтоолын дээрх заалтын дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Дээрх хөтөлбөрийн дагуу 2019–2020 оны хичээлийн жилд бага ангийн сурагчид “Хүн, байгаль”, “Хүн нийгэм”, “Хүн орчин”, дунд ангийн сурагчид “Нийгмийн ухаан”, “Иргэний ёс зүйн боловсрол”, ахлах ангийн сурагчид “Нийгмийн ухаан”, “Монголын түүх” зэрэг хичээлээр хүний эрхийн боловсрол эзэмшиж байна.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/491 дүгээр тушаалаар бага, дунд, ахлах ангийн сурагчид “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг долоо хоногт 2 цагаар судалж байна. Уг хичээлийн зорилго нь хүнлэг энэрэнгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг, үндэсний хэл, соёлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, хүндэлж хамгаалдаг, эх орноо эрхэмлэн дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан монгол иргэнийг өсгөх, хүмүүжүүлэх, бэлтгэхэд чиглэдэг байна.

Үүнээс харахад бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөрт хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн зохих агуулга туссан боловч мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрт нэгдсэн байдлаар тусгах ажил бүрэн

хэрэгжээгүй байна. Энэ хүрээнд Комисс 2019 оны 10 дугаар сард “Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал” семинарыг 29 их, дээд сургуулийн захирал, сургалт, хөтөлбөрийн албаны дарга, менежерийг оролцуулан зохион байгуулж, дээд боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах асуудлыг хэлэлцэв. Улмаар их, дээд сургуулиудын хүний эрхийн боловсрол олгох хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, багш нарын хүний эрх, жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, чадавхыг бэхжүүлэх талаар үндэсний хэмжээнд нэгдмэл ойлголттой болж, хамтын хүчин чармайлт гаргах шаардлагатайг тодорхойлсон болно.<sup>225</sup>

#### Тогтоолын 1.5.в хэсэг

*Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт, шаардлагад хүний эрхийн боловсролын асуудлыг тусгах, хэрэгжилтэд хяналт тавих;*

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн магадлан итгэмжлэлд Дотоод хэргийн их сургууль “Гэмт явдал судлал–эрх зүй” хөтөлбөртөө 2019 онд магадлан итгэмжлэлийн гэрчилгээ авсан бөгөөд тус хөтөлбөрт хүний эрхийн зохих агуулга тусгагдсаныг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны мэдээлэлд дурджээ. Цаашид дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтэд хүний эрхийн боловсролын агуулгыг заавал тусгах шаардлагатай байна.

<sup>225</sup> Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2020 оны 3 дугаар сарын 16–ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

### Тогтоолын 1.5.г хэсэг

*Хууль, эрх зүйн сургалттай их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг заавал судлан үзэхээр тусгаж, багш бэлтгэж, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулахыг дэмжих.*

Комисст ирүүлсэн мэдээллээр 2018–2019 оны хичээлийн жилд Монгол Улсын Их Сургуулийн сонгон судлах хичээлийн хүрээнд “Хүний эрх” 3 багц цагийн сургалтыг 812 оюутан, эрх зүйн бакалаврын хөтөлбөрийн мэргэжлийн суурь хичээлийн хүрээнд 2 багц цагийн “Хүний эрх” хичээлийг 312 оюутан, мэргэжлийн сонгон судлах 2 багц цагийн “Хүний эрх ба олон улсын хүмүүнлэгийн эрх зүй” хичээлийг 15 оюутан судалжээ. Тус сургуулийн эрх зүй, философи, шашин судлалын докторын хөтөлбөрт 3 багц цагийн “Хүний эрхийг хамгаалах институт ба сайн засаглал” хичээлийг 15 докторант, эрх зүйн магистр, докторын хөтөлбөрт 3 багц цагийн “Хүний эрхийн олон улсын эрх зүй” хичээлийг 11 суралцагч тус тус судалсан байна.<sup>226</sup> Мөн Шихихутуг их сургуулийн оюутнууд 2 багц цагийн “Хүний эрх” хичээлийг заавал судалдаг байна.

Хууль, эрх зүйн сургалттай зарим их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг судалж буй нь сайшаалтай боловч тогтоолын энэ хэсгийг хэрэгжүүлэх талаар ахиц дэвшил, бодлогын өөрчлөлт гараагүй байна.

<sup>226</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 1а/945 дугаар албан бичиг.

## 1.6. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн асуудлаар

### Тогтоолын 1.6.а хэсэг

*Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн зөвлөмжийн биелэлтийн мэдээллийн нэгдсэн сантай болох;*

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл, олон улсын гэрээний хороод, тусгай процедур, мөн хүний эрхийн үндэсний байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянах мэдээллийн сан (National Recommendations Tracking Database-NRTD) нь зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, тайлагнах үйл явцыг хялбаршуулах, үндэсний болон салбарын бодлогын уялдаа зохицуулалтыг сайжруулахад чиглэсэн мэдээллийн чухал арга хэрэглүүр болжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс 2015 онд Монгол Улсад өгсөн 150 зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Орон тооны бус зөвлөлийг Ерөнхий сайдын 2016 оны 112 дугаар захирамжаар Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулан байгуулжээ.

Зөвлөлийн гишүүдээр 11 яамны Төрийн нарийн бичгийн дарга, 4 агентлагийн дарга, иргэний нийгмийн 8 байгууллагын төлөөлөл ажилладаг байна.<sup>227</sup> Засгийн газрын холбогдох яам, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум

<sup>227</sup> Гадаад харилцааны яамнаас 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

хамтран Монгол Улсад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлгийг бүсчлэн зохион байгуулж, оролцогч талуудын саналыг сонсч, мэдээлэл цуглуулжээ.

Монгол Улсын Засгийн газар хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайланг 2020 онд хэлэлцүүлсний дараа зөвлөмжийн хэрэгжилтийг хянах дээрх мэдээллийн санг шинэчилж ашиглахаар Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд Комиссарын газарт хүсэлт тавьсан байна.<sup>228</sup>

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлд Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форумгаас хүргүүлэх хөндлөнгийн мэдээлэл, Засгийн газрын тайланг танилцуулах хэлэлцүүлгийг 2019 оны 9 дүгээр сар, 2020 оны 1 дүгээр сард тус тус зохион байгуулсан нь Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагын ойлголтыг нэгтгэх, харилцан мэдээлэл солилцохын зэрэгцээ хүний эрхийн төлөв байдлыг үндэсний түвшинд бодитой үнэлэхэд чухал алхам болжээ.

Цаашид Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн зөвлөмжийн биелэлтийн мэдээллийн нэгдсэн сантай болох заалтын хэрэгжилт эхлэл төдий байгааг анхаарч, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар жил бүр хэлэлцэж, цаашид авах шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх, холбогдох мэдээллийг монгол хэлээр олон нийтэд нээлттэй байршуулах шаардлагатай байна.

---

<sup>228</sup> Гадаад харилцааны яамнаас 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

### Тогтоолын 1.6.6 хэсэг

*Хүний эрхийн олон улсын гэрээний албан ёсны орчуулгын чанарыг сайжруулах, үндэсний хууль тогтоомж, хүний эрхийн олон улсын гэрээний нэр томьёог нэг мөр болгох.*

Гадаад харилцааны яам 2005 оноос эхлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн тусгай дугаар болгон хэвлүүлэх ажлыг зохион байгуулжээ. Гэвч одоогийн байдлаар Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протокол, Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээ зэрэг 10 гаруй олон улсын гэрээ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдээгүй байна.

Гадаад харилцааны сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар “Монгол Улсын олон улсын гэрээний орчуулга хийх, хянан баталгаажуулах журам”-ыг баталжээ. Уг журамд тухайн олон улсын гэрээнд хэрэглэсэн нэр томьёо Монгол Улсад хэрэглэдэг хууль зүйн нэр томьёотой нийцэж байгаа эсэх, гэрээний орчуулга найруулгын хувьд хуулийн шаардлага хангаж байгаа эсэхийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянахаар тусгасан байна. Гэвч нэгдэн орсон хүний эрхийн гэрээний орчуулгын чанар тааруу болон зарим олон

улсын гэрээ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдээгүй зэрэг шалтгаанаар шүүхийн практикт хэрэглэхгүй байх, хэрэглээнд хүндрэл бэрхшээл гарч байгаа асуудлыг Гадаад харилцааны яам судалж, шийдвэрлэх боломжийг эрэлхийлж байгаа талаар мэдээлэл ирүүлжээ.<sup>229</sup>

Иймд хүний эрхийн олон улсын гэрээний албан ёсны орчуулгын чанарыг сайжруулах, үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээний нэр томъёог нэг мөр болгох, албан ёсоор нийтлэх зэрэг ажлын биелэлт хангалтгүй байгааг Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг хуулиар үүрэг хүлээсэн байгууллагууд анхааралдаа авч, Гадаад харилцааны яамтай хамтран зохих арга хэмжээ авч, тогтоолын заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### 1.7. Бусад асуудлаар

#### Тогтоолын 1.7.а хэсэг

*Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах, хянан шалгах, холбогдох дүгнэлт гаргах, хариуцлага тооцох зэрэг асуудлаар Хүний эрхийн Үндэсний Комиссын эрх хэмжээг нэмэгдүүлэх, ажиллах эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчлэн найруулж, өргөн мэдүүлэх;*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталснаар уг хууль 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Хуулийн шинэчилсэн найруулгад Монгол

<sup>229</sup> Гадаад харилцааны яамнаас 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.



Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст гаргасан гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрх хэмжээг тодорхой болгож баталгаажуулж, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлээгүй, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээ аваагүй албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, чөлөөлөх, огцруулах, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг нь зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах зэрэг хариуцлагын механизмыг бий болгож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах гишүүн, түүнд дэмжлэг үзүүлэн ажиллах нэгжээс бүрдсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг тусгах зэргээр эрх зүйн орчин сайжирсан тул тогтоолын уг хэсэг бүрэн хэрэгжсэн гэж үзэж байна.

#### Тогтоолын 1.7.6 хэсэг

*Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж Жендэрийн үндэсний хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, хариуцлагыг сайжруулж, гишүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлж, холбогдох зардал, төсвийн асуудлыг шийдвэрлэх;*

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас Комисст ирүүлсэн мэдээлэлд тогтоолын зохих заалтыг хэрэгжүүлэх талаар дараах ажлыг зохион байгуулсныг багцлан танилцуулж байна. Үүнд:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 3.4.3 дахь заалтад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх ажлыг 2017–2021 онд хийхээр тусгасны дагуу 2020 оны II, III улиралд эхлүүлэхээр төлөвлөжээ.

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 111, 285 дугаар тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтцээс гаргаж, Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар шийдвэрлэсэн байна. Үүний дагуу Ажлын алба нь 2019 оны 1 дүгээр сараас эхлэн бие даасан бүтэц, төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, яамд дахь 13 салбар зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн 31 салбар хороо, холбогдох төрийн бус байгууллага, олон улсын хөгжлийн түншлэгч байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тус албаны цалингийн сан, үйл ажиллагааны зардлыг Ерөнхий сайдын төсвийн багцад тусган 2019 оны төсөвт 706.8 сая төгрөг, 2020 оны төсөвт 555.9 сая төгрөгийг тус тус баталж, албаны орон тоо 8 байсныг 6-аар нэмэгдүүлсэн байна. Хорооны дэргэд Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, Эрдэмтэн судлаачдын бүлэг, Хэвлэл мэдээллийн зөвлөлийг шинэчлэн байгуулж хамтран ажиллаж байна.
- Ажлын алба нь Жендэрийн үндэсний хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, гишүүдийн хариуцлагыг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх хүрээнд Хорооны цахим хуудас ажиллуулах, мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэх, Хороо, Ажлын албаны жил, улирал, сар, долоо хоногийн ажлын төлөвлөлтийг Хорооны гишүүд болон олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллаж байна.<sup>230</sup>

Түүнчлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн мэдээлэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөл Жендэрийн эрх

<sup>230</sup> Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанаас 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 3/34 дугаар албан бичиг.

тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны сайдын А/114 дүгээр тушаалаар Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого болон 2019–2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулжээ.<sup>231</sup>

Комисс нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн талаар аймаг, орон нутгийн түвшинд 2019 онд зохион байгуулсан хяналт шалгалт, сургалт нөлөөллийн ажиллагаа, түүний үр дүнг энэ илтгэлийн хоёрдугаар бүлэгт тодорхой санал, зөвлөмжийн хамт тусгасан болно.

#### Тогтоолын 1.7.в хэсэг

*Онцгой байдлын алба хаагчийн ажиллах орчин нөхцөл, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангах, амь нас, эрүүл мэндийг болзошгүй эрсдэлээс хамгаалах үүднээс аврах ажиллагааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр хангахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх, албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол нэг удаагийн тусламж олгохоос гадна амь насны даатгалыг нэмэгдүүлэх, эрүүл мэндээ нөхөн сэргээхэд нь шаардлагатай эмчилгээ, оношилгооны зардлыг төрөөс бүрэн хариуцдаг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх;*

Тогтоолд тусгасан уг асуудлын хүрээнд Монгол Улсын Шадар сайдын Ажлын албанаас дараах тайлан мэдээллийг ирүүллээ. Үүнд:

- 2019 оны байдлаар Онцгой байдлын ерөнхий газрын аврах багаж хэрэгслийн хангалт 50 хувь, гал унтраах тоног төхөөрөмжийн хангалт 53 хувь, тусгай зориулалтын

<sup>231</sup> Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

хувцас, хэрэгслийн хангалт 35 хувьтай байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 25 дугаар тогтоолын дагуу Онцгой байдлын байгууллагын гал түймэртэй тэмцэх техник тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөлд 3 сая еврогийн өртөг бүхий гал унтраах албаны 13 автомашин, 6 сая еврогийн өртөг бүхий хээрийн хөдөлгөөнт 2 эмнэлгийг Бүгд Найрамдах Польш Улсаас худалдан авчээ.

- Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр “Онцгой байдлын байгууллагын техник, хэрэгслийн чадавхыг сайжруулах” төсөл хэрэгжүүлж Беларусь Улсад үйлдвэрлэсэн гал түймэр унтраах, аврах ажиллагааны зориулалтын 15.4 сая еврогийн өртөг бүхий 15 нэр төрлийн 72 автомашин, техник хэрэгслийг худалдан авах гэрээ байгуулжээ.
- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт заасны дагуу амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд аврагч, гал сөнөөгч, бүлгийн дарга (эрсдэл ихтэй) нарыг 33 сая, бусад алба хаагч (эрсдэл багатай) тус бүрийг 21.5 сая төгрөгийн үнэлгээ бүхий даатгалд хамруулж, даатгалын жилийн хураамжид нийт 336.2 сая төгрөг төлжээ.
- Мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсэгт заасны дагуу гал түймрийн улмаас түлэгдсэн 7 алба хаагчийн эмчилгээний зардалд Онцгой байдлын ерөнхий газраас 40 сая төгрөг, хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсэгт заасны дагуу нас барсан 5 алба хаагчийн ар гэрт 183 сая төгрөгийг, мөн алба хаагчдын нөхөн сэргээх эмчилгээ, сувилуулах зардалд 283 сая төгрөгийг, 2019 онд ойн түймэрт өртөж түлэгдсэн Орхон аймгийн Онцгой байдлын газрын аврагч, гал сөнөөгчид Засгийн газрын 2019 оны 309 дугаар тогтоолоор 100 сая төгрөг тус тус олгосон<sup>232</sup> байна.

<sup>232</sup> Монгол Улсын Шадар сайдын Ажлын албанаас 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн мэдээлэл.

Үүнээс харахад онцгой байдлын алба хаагчдын ажиллах орчин нөхцөл, хөдөлмөрийн аятай нөхцөлийг бүрдүүлэх, амь нас, эрүүл мэндийг нь болзошгүй эрсдэлээс хамгаалах үүднээс аврах ажиллагааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, хэрэгслээр бүрэн хангахад шаардагдах санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

### Тогтоолын 1.7.г хэсэг

*Уул уурхайн салбарт ажиллагчдыг осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;*

Уул уурхай, олборлолтын салбарт 2018 онд 73 осол гарч, 12 хүн нас барсан бөгөөд хөдөлмөр эрхлэлтээс үүдэлтэй нийт ослын 25.8 хувь нь уг салбарт хамаарч байна.<sup>233</sup> Монгол Улсын Засгийн газар 2019 онд “Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 236 дугаар тогтоолыг баталжээ. Уг тогтоолоор геологи, уул уурхайн салбарт хууль зөрчсөн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлах, зөрчил үйлдэхэд ашигласан машин механизм, техник тоног төхөөрөмжийг хураах албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх стандарт, дүрэм, журмыг боловсронгуй болгох, сурталчлан таниулах, осол гэмтлийн шалтгаан нөхцөлийг судалж урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагууд, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг арга хэмжээ авахыг холбогдох

<sup>233</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 02/419 дугаар албан бичиг.

сайд нарт үүрэг болгосон байна. Тухайн тогтоолын хүрээнд Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 313 дугаар тогтоолоор баталж,<sup>234</sup> мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/231, А/368 дугаар хамтарсан тушаалаар Ил уурхайн аюулгүй байдлын дүрмийг шинэчлэн баталжээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 02/04 дугаар албан бичигт дурдсанаар ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдлыг сайжруулах, тоос, шуугиан, хувийн хамгаалах хэрэгслийн талаарх стандартыг хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөмж өгсөн байна. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг хатуу мөрдөх, аюул ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах талаарх зөвлөмжийг 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 02/438 дугаартай албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад хүргүүлжээ.<sup>235</sup>

Холбогдох төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээллээс дүгнэхэд уул уурхайн салбарт ажиллагчдыг осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах, ажлын байрны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд Засгийн газар анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

<sup>234</sup> Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 01/436 дугаар албан бичиг.

<sup>235</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 02/419 дугаар албан бичиг.

### Тогтоолын 1.7.д хэсэг

*Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг мөнгөн дүнгээр үнэлэх, тооцох аргачлалыг бий болгож, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах;*

Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Сэтгэл санааны хохирол тооцох журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор хамтран батална.” гэж тусгаснаас өөрөөр гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг мөнгөн дүнгээр үнэлэх талаар холбогдох хууль тогтоомжид тусгаж хэрэгжүүлсэн эсэх талаар мэдээлэл байхгүй тул тогтоолын уг хэсгийн хэрэгжилт хангалтгүй байна.

### Тогтоолын 1.7.е хэсэг

*Ажиллах нөхцөл, боломжоор барьцаалан дарамтлах, байгууллага, ажил олгогч ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх хэм хэмжээг дотоод журамдаа тусгах, хэрэгжүүлээгүй, эсхүл журмаа зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох зохицуулалтыг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд тусгах асуудлыг судлах.*

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар тус хуулийн 5.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бусад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан

сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” хэмээн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Ийнхүү Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдлыг заалт, хэсэг тус бүрээр холбогдох яамд, төрийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан танилцууллаа. Цаашид тогтоолын хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй заалт, хэсэг бүрийг хуулийн дагуу үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд анхааралдаа авч, зохих арга хэмжээ авч тайлагнах байдлаар хэрэгжилтийг бүрэн хангах шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан билээ. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт зааснаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Монгол Улсын Их Хуралд хүргүүлэх, уг зүйлийн 17.3 дахь хэсэгт зааснаар Комиссын илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийн биелэлтийг Засгийн газар жил бүр Улсын Их Хуралд илтгэх ёстойг анхаарч, цаашид хуульд заасан хугацаанд санал, зөвлөмжийн биелэлтийг тайлагнаж хэвших нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад чухал ахиц дэвшил болохыг Комисс онцлон тэмдэглэж байна.



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААР  
ШИЙДВЭР ГАРГУУЛАХААР МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС  
ТАВЬЖ БУЙ САНАЛ**

Нэг. Малчин эмэгтэйчүүдийн хүний эрх, хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлаар

А. Хүчирхийллээс ангид байх эрхийн чиглэлээр:

1. Түр хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг бүх аймагт бий болгож, тэдгээрт ажиллах алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх, алслагдсан газарт хүрч ажиллахад шаардагдах автомашин, шатахуун болон бусад зардлыг шийдвэрлэх;
2. Аймаг сум, багын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэх, шаардагдах төсвийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа шийдвэрлүүлдэг байх;
3. Цагдаагийн төв байгууллагын бүтэц дэх гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийг аймаг дахь Цагдаагийн газарт бий болгож, хамтарсан багийн үйл ажиллагаатай уялдуулах;
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл нь соён гэгээрүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхдээ алслагдмал газарт амьдардаг, мэдээлэл авах боломжгүй, бичиг үсэг үл мэддэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагааг нэмэгдүүлэх;
5. Цагдаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай сургагч багшийг бэлтгэх, орон тоог нэмэгдүүлэх, сургалтын байр, танхим,

сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, шаардагдах зардлыг шийдвэрлэх;

**Б. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн чиглэлээр:**

6. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах замаар жирэмсний хяналтын тусламж, үйлчилгээг алслагдсан сум, багийн эмэгтэйчүүдэд хүргэх, жирэмсэн эхийг аймгийн нэгдсэн эмнэлгийн хяналтад амаржуулах талаар аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн дүгнэлт гарснаас бусад тохиолдолд эрсдлийг үнэлсний үндсэн дээр аймгийн төвөөс алслагдсан газарт амьдарч буй жирэмсэн эмэгтэйчүүдийг сумандаа амаржих нөхцөлөөр хангах;
7. Эрүүл мэндийн байгууллагын хүний болон санхүүгийн нөөцийг хуваарилахдаа мэргэшсэн эх баригч, эмэгтэйчүүдийн эмч, багийн эмчийн орон тоог зохистой нэмэгдүүлэх, сумын эрүүл мэндийн төвүүдийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай орчин үеийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах;
8. Малчдад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх болон гэр бүл төлөвлөлт, хүчирхийллийн талаарх мэдээллийг тогтмол, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх;
9. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа жирэмслэхээс сэргийлэх хэрэгслийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх;
10. Аймгийн эрүүл мэндийн газар харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ,

мэдээлэлд малчдыг нарийвчлан ангилсан статистикийг гаргадаг болох.

### В. Бусад эрхийг хангах чиглэлээр:

11. Бага, дунд боловсролын тухай хуульд бага боловсрол олгож буй ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн насны онцлогт тохирсон байдлаар тохижсон, алслагдмал орон нутагт амьдардаг хүүхдүүдийг 7 хоногийн ажлын өдрүүдэд хүлээн авах цэцэрлэгийн нөхцөл бүхий дотуур байртай байх зохицуулалтыг тусгах;
12. Малчин эмэгтэйчүүд, тэдгээрийн гэр бүлийг олон нийтийн үйл ажиллагаанд тогтмол хамруулах, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах чиглэлээр аймаг, сумдын түвшинд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
13. Мал аж ахуйн бус ажлыг туслах малчны ажилд хамааруулахгүй байх, 16 насанд хүрээгүй хүүхдийг туслах малчнаар ажиллуулахгүй байхаар тооцож “туслах малчин”-ы нэр томъёог холбогдох хуульд оновчтой тодорхойлох, Хөдөлмөрийн тухай хуульд туслах малчны хөдөлмөрийн гэрээ, цалин хөлс, олговор, ажил, амралттай холбоотой зохицуулалтыг тусгах.

### Хоёр. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар

14. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар Ерөнхий сайдын албан даалгавар гаргаж аймгуудын Засаг дарга нарт хүргүүлэх;

15. Орон нутгийн төсөвт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тогтмол тусгах;
16. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгох;
17. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн биелэлтийн дүнг Засаг дарга нарын ажлыг дүгнэх нэг үзүүлэлт болгож үйл ажиллагааг идэвхжүүлэх;
18. Төрийн албаны зөвлөл, Жендэрийн үндэсний хорооноос гаргаж буй хүйсийн тэнцвэрт байдлын тайлан, мэдээг нэг загвар, шалгуураар гаргах;
19. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хүчирхийлэл болон дарамтын тухай 190 дүгээр конвенцыг соёрхон батлах.

**Гурав. Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалттай холбоотой асуудлаар**

20. Хот суурин газарт сургууль, эмнэлэг, лаборатори, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгжүүд дээр олон жил хуримтлагдаж хадгалагдаж байгаа, хугацаа нь дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлыг байршуулах, хадгалах зориулалтын барилга, байгууламжийг яаралтай бий болгох;
21. Химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй аргаар устгах үйлдвэрийг барих асуудлыг нэн даруй шийдвэрлэх;

22. Химийн хорт болон аюултай бодисын нэгдсэн бүртгэлтэй болох, хариуцах байгууллагыг тодорхойлох;
23. Байгууллага, аж ахуйн нэгжид хадгалагдаж байгаа хугацаа нь дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон химийн хорт болон аюултай бодис, хог хаягдлыг зөөвөрлөх, стандартын шаардлагад нийцсэн барилга, байгууламжид хадгалах.




*Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлнэ.*

*(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг)*

*Комиссын илтгэлийг жил бүрийн Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурал тогтоол гаргана.*

*(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг)*

ISBN 991995313-X



9 789919 953133